МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

# ЖИЛИЙН ТАЙЛАН 2023

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

# АГУУЛГА


**АЛСЫН ХАРАА | ЭРХЭМ ЗОРИЛГО | ҮНЭТ ЗҮЙЛ**

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ, САНГИЙН САЙДЫН МЭНДЧИЛГЭЭ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

**ЗАСАГЛАЛ**
- Бүтэц, зохион байгуулалт
- Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
- Гүйцэтгэх удирдлага

**ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН**
**ХӨГЖЛИЙН БАНКНЫ ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧООН**
**САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**
**ГАДААД ӨР ТӨЛБӨР**
**ЭХ ҮҮСВЭР, ХАМТЫН АЖИЛЛАГАА**
- Зээлжих зэрэглэл
- Төслийн санхүүжилт, эргэн төлөлт
- Тогтвортой хөгжлийн бодлого

**ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**
**МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ, ЦАХИМЖУУЛАЛТ**

**"ДИ БИ ЭМ ЛИЗИНГ" ХХК**
**"ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК**
**АУДИТЛАГДСАН ТАЙЛАН**

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

**АЛСЫН ХАРАА**

ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ, ТЭРГҮҮЛЭХ САЛБАРЫГ ДЭМЖИГЧ БОДЛОГЫН БАНК БАЙНА.

**ЭРХЭМ ЗОРИЛГО**

ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭКСПОРТЫГ ДЭМЖИЖ НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХУВЬ НЭМЭР ОРУУЛНА.

**ҮНЭТ ЗҮЙЛС**

ЭХ ОРОНЧ СЭТГЭЛ
ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ИТГЭЛ ҮНЭМШИЛ
ЁС ЗҮЙ, ШУДАРГА БАЙДАЛ
МЭРГЭШСЭН ӨНДӨР УР ЧАДВАР
ИЛ ТОД БАЙДАЛ




# МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсын эдийн засаг сэргэж, төсөв, төлбөрийн тэнцэл ашигтай гарч, Хөгжлийн банк Самурай бонд болон Ди Би Эм 2023 Евробондын эргэн төлөлтөө амжилттай төлж барагдуулсан олон сайн үзүүлэлттэйгээр 2023 оныг үдэж байгааг Хөгжлийн банкны тайланг хүлээн авч буй Та бүхэнд дуулгаж байгаад таатай байна.

Гурван жилийн өмнө манай улсын эдийн засаг -4.6 хувь хүртлээ агшиж байсан бол 2023 оныг бид 7 хувийн өсөлттэй үдлээ. Үүгээрээ Монгол Улс дэлхийн хамгийн өндөр өсөлттэй эдийн засагтай 20 улсын нэгээр нэрлэгдэж, хоёрдугаарт эрэмбэлэгдээд байна.

Өнгөрсөн онд Монгол Улсын Засгийн газрын хувьд хамгийн их гадаад өр төлбөрийг төлөх жил байв. Засгийн газар эдгээр гадаад өр төлбөрийг хугацаанд нь төлөхийн төлөө гурван жилийн өмнөөс эрчимтэй ажилласнаар сүүлийн жилүүдэд 13.3 их наяд төгрөгийн гадаад өр төлбөрийг барагдууллаа.

Улсын Их Хурлаас Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэхдээ эдийн засагт дарамтгүйгээр шийдэх үүрэг даалгаврыг өгсөн. Энэ хүрээнд Сангийн яамнаас Засгийн газрын гадаад өрийн төсөвт үзүүлэх ачааллыг урт хугацаанд бууруулах, өрийн багцын эргэн төлөлтийн дундаж хугацааг уртасгах, гадаад үнэт цаасны төлбөрийг боломжит хэмжээгээр төсвөөс төлж, нийт үлдэгдлийг бууруулах зорилгоор Сенчири II, III төслүүдийг хэрэгжүүлснээр өрийн зохицуулалтыг амжилттай хийж чадлаа.

Засгийн газар ийнхүү эргэн төлөх хугацаа нь болсон, өндөр дүнтэй гадаад өр төлбөрүүдийг өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд дахин санхүүжүүлснээр төсөв, төлбөрийн тэнцэлд ирэх өрийн дарамтыг бууруулж, гадаад валютын ханшийг тогтвортой барих, санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн. Үүний зэрэгцээ 2024, 2025 онд бондын хуваарьт төлөлтгүй болж, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг B түвшинд хадгалснаар хувийн хэвшлүүд гадаад зах зээлээс бага хүүтэй бонд босгох боломжтой боллоо. Цаашид эдийн засгийг нээлттэй, ил тод болгох бодлогоо тогтвортой хадгалж чадвал валютын албан нөөцийг 10 тэрбум ам.долларт хүргэх нөөц боломж байна.

Засгийн газрын хуралдаанаар Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжсэн бөгөөд Улсын Их Хуралд өргөн барихаар зэхэж буй. Цаашид хууль, засаглал, бизнес загварын өөрчлөлтийг ийнхүү хийснээр экспорт, импортын банкны чиг үүргийг хэрэгжүүлэх боломж бүрдэж, ирэх жилүүдэд “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд батлагдсан төслүүдийг санхүүжүүлэхэд Хөгжлийн банк чухал үүрэгтэйгээр ажиллах болно.

Эдгээр үр дүнд хүрэхэд сэтгэл, оюунаа дайчлан ажилласан Хөгжлийн банкны хамт олон болон чанаргүй зээлийг бууруулж, зээлийн эргэн төлөлтийг цаг хугацаанд нь төлөхөд хамтран ажилласан байгууллагууд, олон нийт Та бүхэндээ Засгийн газрын нэрийн өмнөөс талархал илэрхийлье.

**Б.ЖАВХЛАН**
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, САНГИЙН САЙД



# МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс эрхэм харилцагч, хамтран ажиллагч, хувьцаа эзэмшигч Та бүхэндээ чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүд 2023 оны есдүгээр сард шинэчлэгдэж, шинэ бүрэлдэхүүнтэйгээр бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллалаа. Хөгжлийн банк тайлант жилд Засгийн газар болоод гадны хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, хоёр бондын өр төлбөрийг хугацаанд нь, өөрийн эх үүсвэрээр төлж барагдуулсан. Энэ нь Хөгжлийн банк цаашид үйл ажиллагаагаа хэвийн, тогтвортой үргэлжлүүлэх чадвартайгаа баталсан үйл явдал байв. Ялангуяа олон улсын зах зээлээс санхүүжилт татан төвлөрүүлж, шаардлагатай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд ихээхэн чухал ач холбогдолтой юм.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс чанаргүй зээлийн эргэн төлөлтийг барагдуулах ажлыг үргэлжлүүлж, Хөгжлийн банкны санхүүгийн үзүүлэлт, цаашид авах арга хэмжээг нарийвчлан тодорхойлох, санхүүгийн чадавхыг сайжруулах тал дээр түлхүү анхаарч ажиллав. Ирэх 2024 онд дээрх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Тухайлбал, чанаргүй активыг барагдуулах, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг мөнгөжүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэх, шүүхийн шатанд явж буй болон шүүхээс эцэслэн шийдвэрлэсэн зээлийн эргэн төлөлтийг мөнгөн хэлбэрээр барагдуулах зарчим баримтлан ажиллах болно. Мөн Хөгжлийн банкны нийт актив, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлтийг бууруулах, шинээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж зээлийн багцыг нэмэгдүүлэх, төсөл хөтөлбөрийн судалгааг эрчимжүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг татан төвлөрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Цаашид Хөгжлийн банкны үйл ажиллагаанд тулгамдаж буй засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцооны үр нөлөөтэй байдлыг нэмэгдүүлэх хүрээнд Азийн Хөгжлийн банкнаас эрх зүйн орчин, стратеги, засаглал болон бизнес загварыг сайжруулах чиглэлээр техникийн туслалцаа авахаар төлөвлөж, бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Төлөөлөн удирдах зөвлөл Хөгжлийн банкны үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлж, экспорт, импортын банкны чиг үүргийг хэрэгжүүлж, эдийн засагт дэмжлэг үзүүлэхэд ил тод, нээлттэй, шударга зарчмыг баримтлан ажиллах болно.

**Б.ДОРЖСЭМБЭД**
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



# МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсын Хөгжлийн банк хувьцаа эзэмшигч, эрхэм харилцагч, хамтран ажиллагч байгууллагууд Та бүхэнд 2023 оны үйл ажиллагааны тайлангаа хүргэж байна.

Цар тахлын дараах сэргэлтийг дохиолж, геополитикийн тодорхойгүй нөхцөл дунд тасралтгүй өссөн Монгол Улсын эдийн засгийн голлох үзүүлэлтүүд түүхэн дээд түвшинд хүрсэн онцлох цаг үе 2023 онд тохиолоо. Энэхүү өсөлттэй зэрэгцээд Хөгжлийн банк өөрийн дотоод нөөц бололцоогоо ашиглан олон улсын зах зээлд арилжаалсан 500 сая ам.долларын Ди Би Эм 2023 Евробондын эх үүсвэрийг 2023 оны аравдугаар сарын 23-нд, 30 тэрбум иенийн Самурай бондын эх үүсвэрийг арванхоёрдугаар сарын 25-ны өдөр бүрэн төлж барагдуулсан. Ийнхүү гадаад бондуудын эх үүсвэрийг хугацаанд нь эргэн төлж, төлбөрийн чадварын эрсдэлээс сэргийлж чадсан нь өнгөрсөн оны томоохон амжилт байв.

Хөгжлийн банк улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих стратегийн томоохон төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх гол зарчмынхаа хүрээнд 2023 онд “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн дэд бүтэц болон “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-д санхүүжилт олгосон нь шатахуун, эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг дотоодын эх үүсвэрээр хангах, цаашлаад ирээдүйн томоохон хөгжилд хувь нэмэр болсон чухал ажил болж байна.

Бид чанаргүй активыг барагдуулах асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, чанаргүй зээлийн эргэн төлөлтийг хангуулах ажлыг үргэлжлүүлснээр өнгөрсөн онд 516.5 тэрбум төгрөгийн зээлийг эргэн төлүүлэв. Үүний зэрэгцээ шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд шаардлагатай бодлого, журмыг боловсруулж ажиллалаа.

Хөгжлийн банкны зээлжих зэрэглэлийг “Стандард энд Пүүрс” болон “Мүүдис“ агентлаг B (тогтвортой), B3 (тогтвортой) түвшинд буюу Засгийн газартай ижил түвшинд хадгалсан төдийгүй “Мүүдис” агентлаг зээлийн суурь үнэлгээг CAA2 түвшнээс CAA1 болгон нэмэгдүүлсэн нь 2023 онд хийж, хэрэгжүүлсэн бодлогын үр дүн хэмээн үзэж байна.

Өнгөрсөн хугацаанд Хөгжлийн банк экспортыг дэмжсэн, импортыг орлох төсөл хөтөлбөрийг санхүүжүүлж ирсэн ч хууль, эрх зүйн шинэчлэлийг бүрэн утгаар нь хийж чадаагүй алдаа дутагдлыг бид энэ удаа засаж залруулж, компанийн хууль, засаглал, бизнес моделийг өөрчилснөөр экспорт, импортын банкны чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах боломжийг бүрдүүлэх юм. Хөгжлийн банкны үйл ажиллагааг тогтворжуулж, эрх зүй, засаглалын хувьд ийнхүү шинэчлэлийг эхлүүлж буй бидний хүчин чармайлт Хөгжлийн банкийг олон улсын хөгжлийн банкны жишигт нийцэж, цаашид урт хугацаанд тогтвортой, үр ашигтай ажиллах бат бөх суурь болно гэдэгт итгэлтэй байна.

**Ж.БАТАА**
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ШИНЭ БҮРЭЛДЭХҮҮНТЭЙГЭЭР АЖИЛЛАВ

Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн ердийн гишүүд шинэчлэгдэж, 2023 онд шинэ бүрэлдэхүүнээр ажиллалаа. Ингэхдээ зээлийн эргэн төлөлтөд анхаарч, Улсын Их Хурал болон хувьцаа эзэмшигч Засгийн газар, Сангийн яам чиглэл өгч, Хөгжлийн банкны тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн хяналт шалгалт, аудитыг цаг хугацаанд нь тогтмол хийлгэж байна.



- АШИГТАЙ АЖИЛЛАХ
- ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ТОГТВОРТОЙ ЯВУУЛАХ
- ХАРААТ БУС ИЛ ТОД БАЙХ
- ХАРИУЦЛАГАТАЙ, ХАМТЫН УДИРДЛАГАД ҮНДЭСЛЭСЭН БАЙХ
- ХАРААТ БУС ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТТАЙ БАЙХ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Хөгжлийн банк нь 2023 онд зээлийн эргэн төлөлтөд онцгой анхаарч, Улсын Их Хурал, Засгийн газар, Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Сангийн яамнаас тодорхой чиглэл авч ажиллав.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДРИЙН 26 ДУГААР ТОГТООЛООР** Хөгжлийн банкийг цогцоор нь иж бүрэн өөрчлөн зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, 2023 онд багтаан өргөн мэдүүлэхийг үүрэг болгов.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДРИЙН 26 ДУГААР ТОГТООЛООР** Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцад хийсэн Улсын Их Хуралын Хянан шалгах түр хорооны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх үүрэг өгсөн.

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 26-НЫ ӨДРИЙН ХУРАЛДААНААР** Хөгжлийн банкны 2023 онд төлөх гадаад бондуудын эргэн төлөлтийг нарийвчилсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, энэ хүрээнд чанаргүй зээлийг бууруулах зохих арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг хувьцаа эзэмшигч, ТУЗ-д даалгав.

**САНГИЙН САЙДЫН 2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДРИЙН ШИЙДВЭРЭЭР** Хөгжлийн банк нь дотоодын биржийн бус зах зээлд 100 сая ам.доллартой тэнцэх төгрөгийн үнэт цаасыг арилжаалж, валютын нөөцийг нэмэгдүүлсэн.

**ХӨГЖЛИЙН БАНК** нь 2023 оны 10 дугаар сард Ди Би Эм 2023 **ЕВРОБОНДЫН 500 САЯ АМ.ДОЛЛАР**, 12 дугаар сард Япон Улсын хөрөнгийн зах зээлд хаалттай хэлбэрээр арилжаалсан **30 ТЭРБУМ ИЕНИЙН САМУРАЙ БОНДЫН ӨР ТӨЛБӨРИЙГ ХУГАЦААНД НЬ ТӨЛЖ,** олон улсын хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ амжилттай биелүүлсэн.

# БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

- НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО
- ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО
- АУДИТЫН ХОРОО
- ЭРСДЭЛИЙН ХОРОО

- ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

- ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛ
- ХӨРӨНГИЙН УДИРДЛАГЫН ХОРОО
- ЗЭЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО
- ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

- БИЗНЕС ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТЫН АЛБА
- ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЛБА

**ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ**

**ХӨРӨНГИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР**
- ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС
- ЭХ ҮҮСВЭР, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС
- АКТИВЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХЭЛТЭС

**ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ГАЗАР**
- ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС
- ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ХЭЛТЭС

**ЭКСПОРТ, ИМПОРТ, ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ГАЗАР**
- ЭКСПОРТ, ИМПОРТ, ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛТЭС
- БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ХЭЛТЭС

**ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР**
- ЭРСДЭЛИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС
- ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН ХЭЛТЭС
- КОМПЛАЙНСЫН ХЭЛТЭС

**САНХҮҮГИЙН ГАЗАР**
- ТАЙЛАН, БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС
- ТӨЛБӨР ТООЦООНЫ ХЭЛТЭС

**ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗАР**
- ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС
- ХУУЛИЙН ХЭЛТЭС
- МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ЦАХИМЖУУЛАЛТЫН ХЭЛТЭС

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн 2023 онд нийт 17 удаа ээлжит болон ээлжит бусаар хуралдаж, 49 тогтоол баталгаажуулж, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.



**Батсэнгээ ДОРЖСЭМБЭД**
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
Сангийн яам, Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга





**Дааданхүү БАТБААТАР**
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга



**Будсүрэн БОЛОРМАА**
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
Сангийн яам, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга



**Гомбосэд ХОНГОР**
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
Монголын Олон улсын Арбитрт, Арбитрч



**Батаа ЧОЙЖИЛ**
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
“Монголын төмөр зам” ТӨХК, Боомтын төслийн менежер



**Дамиран СУВДАА**
Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн
МУИС-ийн Профессор



**Баяр ЭНХТУЯА**
Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн
Хуульч, Эдийн засагч



**Гансүх БУЯН**
Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн
Хуульч



**Сангаа НАСАНЖАРГАЛ**
Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн
Эдийн засагч

# ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАЛАА

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн дэргэдэх Дотоод аудитын газар нь Аудитын олон улсын байгууллагын баталсан стандартад нийцүүлэн Хөгжлийн банкны “Дотоод аудитын ёс зүйн дүрэм” болон “Дотоод аудитын дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, ТУЗ-ийн 33 дугаар тогтоолоор батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Дотоод аудитын газар нь 2023 онд газар, нэгжийн үйл ажиллагаа болон чиг үүргийн хэрэгжилтийг дүгнэхэд чиглэсэн аудитын ажил гүйцэтгэж, үйл ажиллагааг сайжруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой зөвлөмжүүдийг хүргүүлэн ажиллав. Мөн ТУЗ-ийн тогтоол, тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын гүйцэтгэлийг улирал бүр хянаж, үр дүнг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо болон ТУЗ-ийн хуралд танилцуулан ажиллаж байна.

Дотоод аудитын газраас Банкны үйл ажиллагаанд хийж гүйцэтгэсэн аудитаар Гүйцэтгэх удирдлагад зөвлөмж, цаашид авах арга хэмжээний талаар санал хүргүүлж ажиллав.

**ТУХАЙЛБАЛ:**

- ТУЗ-ийн тогтоол, тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилт хангалтгүй үүрэг даалгаврын шалтгааныг дүгнэн цаашид авч хэрэгжүүлэх санал, зөвлөмж хүргүүлэв.

- Актив хөрөнгийн чанарыг багцын түвшинд сайжруулах, чанаргүй актив хөрөнгийг бууруулах үйл ажиллагааг оновчтой удирдан зохион байгуулах, холбогдох дүрэм, журамд шаардлагатай өөрчлөлтийг оруулж хөрөнгийн үнэ цэн буурах аливаа эрсдэлийг хааж ажиллах арга хэмжээний саналыг гарган хүргүүлэв.

- Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үнэлэлт дүгнэлт өгч, эрсдэлийг илрүүлэх, хүлээн зөвшөөрөх, удирдах, бууруулах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төвлөрч ажиллах зөвлөмж, саналыг хүргүүлэн хэрэгжүүлж байна.

- Бүртгэл тайлагналын үйл ажиллагаанд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн бодлогын баримт бичгийг шинэчлэх, банкны тайлагналын үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэх ажлыг эхлүүлж, бүртгэл тайлагналын хяналтын тогтолцоо алдагдах эрсдэлээс сэргийллээ.

- Худалдан авалтын үйл ажиллагааны тохиромжтой аргачлалыг сонгох, үнэлгээний хорооны хараат бус байдлыг хангах санал хүргүүлж, учирч болзошгүй эрсдэлээс сэргийлж, хяналтын тогтолцоог сайжруулан ажиллалаа.

- Мэдээллийн аюулгүй байдлын үйл ажиллагаанд үүссэн эрсдэлийг тодорхойлж, аудитын хугацаанд засварлуулах боломжтой зүйлсийг тухай бүрд нь засварлуулж, цаашид анхаарах шаардлагатай асуудлуудыг зөвлөмжөөр хүргүүлсэн ба банканд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийллээ.

- Захиргаа удирдлагын газарт хийсэн аудитын хүрээнд хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хууль зүйн эрсдэлээс хамгаалах зөвлөмжүүдийг хүргүүлж, банкийг үйл ажиллагаа, нэр хүндийн эрсдэлээс сэргийлж ажиллалаа.

- Бизнесийн төлөвлөлт, түүний гүйцэтгэлийн хяналтын тогтолцоог сайжруулах, тайлагналын оновчтой бүтцийг санал болгох замаар банкны урт, дунд хугацааны зорилго, зорилт, алсын харааг бэхжүүлэх, засаглалын тогтолцоог сайжруулахад хувь нэмрээ оруулж ажиллалаа.

Цаашид эрсдэлийн удирдлагын тогтолцоог олон улсын чиг хандлагад нийцүүлэх, аудитын олон улсын стандартын шинэчлэлийг тухай бүр үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан аудитыг илүү сайжруулан ажиллаж байна.

# ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Гүйцэтгэх удирдлагын баг нь Хөгжлийн банкны дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ирлээ. Энэ хүрээнд Компанийн тухай хуульд зааснаас гадна банкны дотоод дүрэм, журмыг батлах, банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуурыг хангаж ажиллах, зээл болон бусад санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар шийдвэр гаргах, боловсон хүчнийг сонгох, бэлтгэх, сургах бодлогыг тодорхойлох зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллаж байна.





**Жалсрай БАТАА**
Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч



**Зулпай БАТЫРБЕК**
Эрсдэлийн удирдлагын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч



**Баттулга АМГАЛАН**
Экспорт, импорт, худалдааны санхүүжилтийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч



**Лхагвасүрэн ТЭМҮҮЖИН**
Хөрөнгийн удирдлагын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч



**Бат-Өлзий САЙНЗАЯА**
Төслийн санхүүжилтийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч



**Төмөр БААСАНЖАВ**
Санхүүгийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч



**Дагвадорж АНХБАЯР**
Захиргаа, удирдлагын газрын Дотоод үйл ажиллагааны хэлтсийн захирал



# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ 2023

# ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ БҮС НУТАГТАА ТЭРГҮҮЛЭВ

Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн 2015 оны зэрэгцүүлэх үнээр 2023 оны жилийн эцэст 30.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 7% буюу 2 их наяд төгрөгөөр өслөө. Эдийн засгийн энэхүү өсөлт нь бүс нутаг төдийгүй дэлхийд тэргүүлэх үзүүлэлтэд тооцогдов.

Хөдөө аж ахуйн салбар 9 орчим хувиар унасныг эс тооцвол 2023 онд бусад бүх салбар эдийн засагт эерэг хувь нэмэр оруулсан. Ялангуяа, уул уурхайн салбар ба түүнийг дагасан тээвэр, үйлчилгээ, худалдааны салбар эдийн засгийн 7%-ийн өсөлтөд голлох үүрэг гүйцэтгэлээ.





Мөнгөний нийлүүлэлт буюу М2 2023 оны эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 37.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оныхоос 7.9 их наяд төгрөг буюу 27 хувиар өслөө.

Сүүлийн хоёр жилд 13 хувь давaад байсан инфляц 2023 оны эцэс гэхэд нэг оронтой тоо руу бууж, улсын хэмжээнд 7.9 хувьтай гарсан. Инфляц ийнүү буурахад хүнсний бүлэг 42, импортын барааны үнэ 35 хувийн нөлөө үзүүлэв.




Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 23.2 их наяд төгрөгт хүрч, 35.6%, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 22.5 их наяд төгрөгт хүрснээр улсын төсөв 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарав.






Монгол Улс 2023 онд нийт 163 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 24.4 тэрбум ам.долларт хүрсэн нь мөн түүхэн дээд үзүүлэлтэд тооцогдов. Үүнээс экспорт 15.2 тэрбум ам.доллар, импорт 9.3 тэрбум ам.доллар болж, манай улсын гадаад худалдааны тэнцэл 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 3.2 тэрбум ам.доллар буюу 15 хувь өссөн ба экспорт 2.6 тэрбум ам.доллар буюу 21%, импорт 548 сая ам.доллар буюу 6.3% тус тус өсөв. Улмаар гадаад худалдааны тэнцэл 2.1 тэрбум ам.доллар буюу 55% өссөн байна.



МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧООН 2011-2022 ОН

**2011.02.10**

УИХ-аас Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг батлав.

**2011.05.12**

Засгийн газрын 151 дүгээр тогтоолоор Хөгжлийн банкны дүрмийг шинэчлэн, бүтэц зохион байгуулалтыг батлснаар банкны үйл ажиллагаа албан ёсоор эхлэв.

**2012.03.21**

Засгийн газрын баталгаатай 580 сая ам.долларын дүн бүхий Евробондыг анх удаа олон улсын зах зээлд нээлттэй хэлбэрээр, 5 жилийн хугацаатай, 5.75 хувийн хүүтэй арилжаалав.

**2012.12.31**

Евробондыг олон улсын зах зээлд амжилттай гаргаж, Блүүмберг телевизийн “Best Debut Bond” шагнал хүртэв.

**2013.05.01**

Олон улсын нэр хүнд бүхий Ази, Номхон Далайн Бүс Нутгийн Санхүүгийн Байгууллагуудын Холбоо” (ADFIAP)-нд элссэн.

**2013.12.25**

Засгийн газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны банкны баталгаатайгаар 30 тэрбум иенийн үйлдвэржилтийн Самурай бондыг жилийн 1.52 хувийн хүүтэйгээр Япон Улсын хөрөнгийн зах зээлд арилжаалав.

**2014.04.22**

Экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн зориулалттай төслүүдэд Хөгжлийн банкны эх үүсвэрээс арилжааны банкуудаар дамжуулан зээл олгох зорилгоор 13 банктай Хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан.

**2014.08.21**

БНХАУ-ын Хөгжлийн банктай байгуулсан Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 162 сая ам.долларын зээлийн хөтөлбөрийн гэрээ байгуулж, авто зам болон эрчим хүчний төслүүдийг дахин санхүүжүүлэх зорилгоор амжилттай татан төвлөрүүлэв.

**2014.08.29**

УИХ, Засгийн газрын тогтоолын дагуу олон улсын нэр хүнд бүхий “Кредит Свисс” банктай 300 хүртэлх сая ам.долларын хамтарсан зээлийн хөтөлбөр байгуулав.

**2015.01.25**

Бүгд Найрамдах Унгар Улсын Эксим банктай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, хамтын ажиллагааг эхлүүлэв.

**2015.06.15**

Дулааны IV цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлж, шинээр суурилуулах турбингенераторыг худалдан авах, суурилуулахад шаардагдах хөрөнгийг дахин санхүүжүүлэх зорилгоор ОХУ-ын Внешэкономбанктай 20 сая хүртэлх ам.долларын зээлийн гэрээ байгуулав.

**2016.01.25**

УИХ, Засгийн газрын тогтоолын дагуу ОХУ-аас авах газрын тосны бүтээгдэхүүний импортод шаардагдах гадаад валютын урсгалыг тэнцвэржүүлэх зорилгоор 300 сая ам.долларын зээлийн шугамыг ОХУ-ын ВТБ банктай байгуулав.

**2016.06.23**

Бүгд Найрамдах Узбекистан Улсын Ташкент хотноо зохион байгуулсан Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын Банк хоорондын нийгэмлэгийн XII чуулга уулзалтаар Монгол Улсын Хөгжлийн банканд “Түнш банк” статус олгов.

**2016.12.14**

ОХУ-ын СберБанктай Харилцан ойлголц-лын санамж бичигт гарын үсэг зурав.

**2017.02.10**

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар хэлэлцэн батлав.

**2017.03.21**

580 сая ам.долларын Евробондыг төлж, хөрөнгө оруулагчдын өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн олон улсын санхүүгийн зах зээл дэх банкны байр суурийг бэхжүүлэв.

**2017.05.13**

БНХАУ-ын Аж үйлдвэр, худалдааны банктай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.

**2017.06.16**

Хөгжлийн банкны үйл ажиллагааг өргөжүүлж, бэхжүүлэх хүрээнд тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх зорилготой “Ди Би Эм Лизинг” ХХК-ийг байгуулав.

**2017.08.23**

Хөгжлийн банкны үйл ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтын сан байгуулах зорилготой “Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийг байгуулав.

**2017.10**

Ази, Номхон Далайн Бүс Нутгийн Санхүүгийн Байгууллагуудын Холбоо (ADFIAP)-ны ТУЗ-ийн гишүүнээр сонгогдов.

**2018.01.19**

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч “Мүүдис” агентлаг Хөгжлийн банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээ Caa1 байсныг B3 болгон Монгол Улсын зээлжих зэрэглэлтэй ижил түвшинд ахиулав.

**2018.06.21**

“Их түмэн санаачилга” хөтөлбөрийн Эксим банкуудын холбооны Дээд хэмжээний болон Зөвлөлдөх шатны уулзалтыг 2018 оны 6 дугаар сарын 21-23-нд Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулав.

**2018.07.09**

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч “Фитч” агентлаг анх удаа Хөгжлийн банкны зээлжих зэрэглэлийг тогтоож, Монгол Улсын зээлжих зэрэглэлтэй ижил түвшинд B (тогтвортой) хэмээн үнэлэв.

**2018.10.17**

Хөгжлийн банк олон улсын хөрөнгийн зах зээлд анх удаа Засгийн газрын баталгаагүй 500 сая ам.долларын бонд амжилттай арилжаалав.

**2018.11.13**

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч “Стандард энд Пүүрс” агентлаг Хөгжлийн Банкны зээлжих зэрэглэлийг Монгол Улсын зээлжих зэрэглэлтэй ижил түвшинд буюу B (тогтвортой) гэж үнэлсэн бол “Мүүдис” агентлаг B3 (тогтвортой) хэмээн үнэлэв.

**2019.04.26**

БНХАУ-ын Экспортын Зээлийн Даатгалын Корпорац Синошүрэтэй Хамтын ажиллагааны гэрээ байгуулав.

**2019.04.30**

БНХАУ-ын Бээжин хотод болсон “Бүс ба Зам” олон улсын хамтын ажиллагааны чуулга уулзалтын үеэр Хятадын Банк оф Чайна банктай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.

**2020.03.13**

Ази, Номхон Далайн Бүс Нутгийн Орнуудын Санхүүгийн Байгууллагуудын Холбоо (ADFIAP)-той хамтран 43 дахь удаагийн чуулга уулзалтыг нийслэл Улаанбаатар хотноо удирдан, зохион байгуулахаар товлосон ч дэлхий нийтэд тархсан Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан цахим хэлбэрээр оролцов.

**2020.10.30**

Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын Банк хоорондын консорциумын XVI чуулга уулзалт ОХУ-ын Челябинск хотод зохион байгуулахаар төлөвлөсөн ч цар тахлын улмаас цахимаар хуралдав.

**2021.08.18**

Засгийн газрын 252 дугаар тогтоолоор Хөгжлийн банкны дүрмийг шинэчлэн батлав.

Хөгжлийн банкны охин компани болох “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК, “Ди Би Эм Лизинг” ХХК-ийн үйл ажиллагааг сэргээсэн.

**2021.08.25**

Засгийн газраас Хөгжлийн банкны үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөн Экспорт, Импортын банкны чиг үүргийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.

**2021.09.20**

Дэлхийн банктай байгууллагын засаглал, үйл ажиллагаа, эрсдэлийн хяналтын талаар зөвлөх техникийн туслалцаа авах гэрээ байгуулав.

**2021.11.04**

Ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын Биржийн бус зах зээлд 100 сая ам.доллар хүртэлх дунтэй тэнцэх хэмжээний буюу Биржийн бус зах зээлийн хамгийн өндөр дүн бүхий төгрөгийн үнэт цаасыг гаргаж, эхний транч болох 142.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гадаад хөрөнгө оруулагчаас татан төвлөрүүлэв.

**2022.01.20**

Хөгжлийн банкны зээлийн багц болон активын чанарын талаар анх удаа олон нийтэд нээлттэй мэдээлэв.

**2022.03.24**

Сангийн сайдын 65 тоот тушаалаар Хөгжлийн банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тухайн үеийн бүрэлдэхүүнийг бүрэн өөрчилж, шинэчлэн байгуулав.

**2022.03.29**

УИХ-аас Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах ерөнхий хяналтын нээлттэй сонсголыг Төрийн ордонд зохион байгуулав.

**2022.04.15**

УИХ-ын 14 дүгээр тогтоолоор Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, зээлийн эргэн төлөлтийн талаар УИХ-ын Хянан шалгах түр хороог байгуулав.

**2022.06.16**

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгасан Эрчим хүчний сэргэлтийн хүрээнд Амгалан дулааны станцыг 116МВт-аар өргөтгөх төслийн санхүүжилтийн 85 хувь буюу 56.6 тэрбум төгрөг олгохоор шийдвэрлэв.

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧООН 2023 ОН

**2023.01.16 - 2023.03.17**

УИХ-ын Хянан шалгах түр хорооноос Хөгжлийн банктай холбоотой нотлох баримтыг шинжлэн судлах гурван шатны сонсгол зохион байгууллаа.

**2023.04.26**

Засгийн газрын хуралдаанаар Хөгжлийн банкны 2022 оны Аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулав.

**2023.05.10**

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн өргөтгөлийн төсөлд нийт 42.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олголоо.

**2023.05.12**

Дотоодын биржийн бус зах зээлд 100 сая ам.доллартой тэнцэх төгрөгийн үнэт цаасыг арилжаалж, валютын нөөцийг нэмэгдүүлэн биржийн бус зах зээлийн хамгийн өндөр дүн бүхий үнэт цаас гаргасан байгууллага боллоо.

**2023.07.07**

“Фитч” агентлаг Хөгжлийн банкны зээлжих зэрэглэлийг В тогтвортой түвшинд хэвээр үлдээв.

**2023.08.28**

Санхүүжилтийн үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгарлыг үнэлэн, тайлагнах зорилгоор “Пи Си Ай Эф” олон улсын хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр нэгдлээ.

**2023.10.04**

“Стандард энд Пүүрс” агентлаг зээлжих зэрэглэлийг В (тогтвортой) түвшинд хэвээр үлдээлээ.

**2023.10.23**

Ди Би Эм 2023 500 сая ам.долларын Евробондын төлбөрийг амжилттай төлж барагдуулав.

**2023.10.27**

Корреспондент банкны харилцаагаа өргөжүүлж, "Ай Си Би Си Асиа" банканд ам.долларын ностро данстай болсноор экспорт, импортын банкны үйл ажиллагаар хэрэгжүүлэх сууриа тавилаа.

**2023.11.10**

"Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн Чойбалсан ДЦС-ын өргөтгөлийн төсөлд нийт 74.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгов.

**2023.11.21**

Хөгжлийн банкны үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор Тогтвортой хөгжлийн бодлогоо баталлаа.

**2023.12.25**

Засгийн газрын баталгаатай 30 тэрбум иенийн "Самурай" бондыг амжилттай төлж барагдуулав.

**2023.12.27**

Засгийн газрын хуралдаанаар Монгол Улсын Хөгжлийн банкны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжлээ.

**2023.12.28**

"Мүүдис" агентлаг зээлжих зэрэглэлийг B3 тогтвортой түвшинд хэвээр үлдээж, банкны зээлийн суурь үнэлгээг CAA2 түвшнээс CAA1 болгон ахиулав.

# 516.5 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙГ ЭРГЭН ТӨЛҮҮЛЭВ

**ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БАРИМТЛАН АЖИЛЛАВ**

**37.3%**
ТӨСВИЙН ХЭМНЭЛТ

**ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ**

**₮516.5**
ТЭРБУМ

**ТАТВАРЫН ДАРААХ АШИГ/ АЛДАГДАЛ**

| 2022.12.31 | 2023.12.31 |
|---|---|
| ₮88.6 ТЭРБУМ | -₮58.7 ТЭРБУМ |

**БОНДЫН ТӨЛБӨРИЙГ БҮРЭН ТӨЛЖ, БАРАГДУУЛЛАА**

| САМУРАЙ БОНД | DBM 2023 БОНД |
|---|---|
| ¥30 ТЭРБУМ ИЕН | $500 САЯ АМ.ДОЛЛАР |

**ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ**

| 2022.12.31 | 2023.12.31 |
|---|---|
| 13.8% | 16.4% |

Хөгжлийн банкны нийт актив 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2,441 тэрбум төгрөг, нийт өр төлбөр 1,703 тэрбум төгрөг байна.

## 2022 БОЛОН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**ЭРГЭН ТӨЛӨЛТ**

| 2022 ОН | 2023 ОН |
|---|---|
| ₮1,086.3 ТЭРБУМ | ₮517.6 ТЭРБУМ |

**ЗЭЭЛ ОЛГОЛТ**

| 2022 ОН | 2023 ОН |
|---|---|
| ₮26.2 ТЭРБУМ | ₮79.6 ТЭРБУМ |

**ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН БУЦААЛТ**

| 2022 ОН | 2023 ОН |
|---|---|
| ₮128.6 ТЭРБУМ | ₮73.5 ТЭРБУМ |

**ТАЙЛАНТ ҮЕИЙН АШИГ / (АЛДАГДАЛ)**

| 2022 ОН | 2023 ОН |
|---|---|
| ₮88.6 ТЭРБУМ | -₮58.7 ТЭРБУМ |

## МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ХОЛБОГДОХ БОДЛОГО, ЖУРАМД ЗААСАН САНХҮҮГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР:

| Санхүүгийн зохистой харьцаа үзүүлэлтүүд | Шаардлага | ГҮЙЦЭТГЭЛ 2022.12.31 | ГҮЙЦЭТГЭЛ 2023.12.31 |
|---|---|---|---|
| **Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд заасан харьцаа үзүүлэлт** | | | |
| Нийт зээл, зээлтэй адилтгах актив / ӨХ | <=30 дахин | 4.1 | 3.8 |
| Нэг этгээд, хамааралтай этгээдийн санхүүжилт / ӨХ | <=8 дахин | 1.7 | 1.1 |
| **Монголбанкнаас тогтоосон харьцаа үзүүлэлт** | | | |
| Өөрийн хөрөнгийн хүрэлцээ | >=9% | 13.8% | 16.4% |
| Тогтвортой санхүүжилтийн харьцаа | >=100% | 37.8% | 73.1% |
| Нийт гадаад валютын нээлттэй позиц / ЦӨХ | <=±30% | 14.3% | 27.2% |
| Том зээлийн багц / нийт багцад | <=80% | 80.3% | 85.4% |

# ХӨГЖЛИЙН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА 2023






Хөгжлийн банк нь 2023 онд холбогдох хууль тогтоомжийн дагуу нээлттэй, ил тод мэргэжлийн ёс зүйтэй байх зарчмыг баримтлан ажиллалаа. Тухайлбал, Хөгжлийн банк олон улсын зах зээлд арилжаалсан 500 сая ам.долларын Ди Би Эм 2023 Евробондын эх үүсвэрийг 2023 оны аравдугаар сарын 23-ны өдөр, 30 тэрбум иенийн Самурай бондын эх үүсвэрийг арванхоёрдугаар сарын 25-ны өдөр бүрэн төлж барагдуулан 2023 оны том зорилтоо хэрэгжүүллээ. Олон улсаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийг ийнхүү хугацаанд нь эргэн төлснөөр хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэн, олон улсын зах зээлд байр сууриа хадгалж чадсан юм.

Хөгжлийн банк 2023 онд БНХАУ-ын Хөгжлийн банкнаас 156.4 сая юанийн эх үүсвэр татан төвлөрүүлж “Дорнод бусийн эрчим хүчний систем” ТӨХК-д санхүүжилтийг гэрээний дагуу олгов. Түүнчлэн чанаргүй активыг барагдуулах асуудлаар хууль, шүүхийн байгууллага болон хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласнаас гадна шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд шаардлагатай бодлого, журмыг боловсруулаад байна. Хөгжлийн банкны зээлжих зэрэглэлийг “Стандард энд Пүүрс“ болон “Мүүдис” агентлаг B (тогтвортой), B3 (тогтвортой) түвшинд буюу Засгийн газартай ижил түвшинд үнэлсэн төдийгүй “Мүүдис” агентлаг зээлийн суурь үнэлгээг CAA2 түвшнээс CAA1 болгон нэмэгдүүллээ.

# БОНДУУДЫН ТӨЛБӨРИЙГ БҮРЭН ТӨЛЖ БАРАГДУУЛЛАА

### 500 САЯ АМ.ДОЛЛАРЫН ДҮНТЭЙ ЕВРОБОНДЫГ ӨӨРИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР ТӨЛЛӨӨ

**$500** САЯ



Хөгжлийн банк 2018 оны аравдугаар сарын 23-ны өдөр олон улсын зах зээлд арилжаалсан Ди Би Эм 2023 Евробондын төлбөрийг өөрийн эх үүсвэрээр, хугацаанд нь бүрэн төллөө. Нийт 500 сая ам.долларын дүнтэй тус бондыг 7.25%-ийн хүүтэй, 5 жилийн хугацаатайгаар олон улсын зах зээлд арилжаалж байсан юм.




### САМУРАЙ БОНДЫН ТӨЛБӨРИЙГ БҮРЭН ТӨЛЖ, БАРАГДУУЛЛАА

**¥30** ТЭРБУМ

Анх 2013 онд Засгийн газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны банкны баталгаатай, 10 жилийн хугацаатай, 1.52%-ийн хүүтэй, 30 тэрбум иенийн дүн бүхий Самурай бондыг Япон Улсын хөрөнгийн зах зээлд хаалттай хэлбэрээр арилжаалсан. Тус бондын эргэн төлөлтийг 2023 оны арванхоёрдугаар сард буюу хугацаанд нь хийж, бүрэн төлж барагдууллаа.

### ДОТООДЫН БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛД 100 САЯ АМ.ДОЛЛАРЫН ҮНЭТ ЦААСЫГ АРИЛЖЛАА

Хөгжлийн банк дотоодын Биржийн бус зах зээлд хамгийн өндөр дүн бүхий үнэт цаас гаргав. Шаардлагатай эх үүсвэрийг татан төвлөрүүлэх хүрээнд ийнхүү дотоодын биржийн бус зах зээлд 2023 оны хоёрдугаар улиралд **100 сая ам.доллартой тэнцэх төгрөгийн үнэт цаас арилжиж,** валютын нөөцийг нэмэгдүүлсэн.

# ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮНЭЛГЭЭГЭЭ АХИУЛАВ

## ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮНЭЛГЭЭГ CAA2 ТҮВШНЭЭС CAA1 БОЛГОН АХИУЛАВ

Зээлжих зэрэглэл тогтоогч “Стандард энд Пүүрс”, “Мүүдис” болон “Фитч” агентлагуудаар зээлжих зэрэглэл тогтоолгож, Хөгжлийн банкны зээлжих зэрэглэлийг Монгол Улсын зээлжих зэрэглэлтэй ижил түвшинд хадгалав. Тодруулбал, **“Фитч” агентлагаас Хөгжлийн банкийг 2023 онд B (тогтвортой) түвшинд хэвээр, “Стандард энд Пүүрс” B (тогтвортой) түвшинд хэвээр, “Мүүдис” агентлаг B3 (тогтвортой) түвшинд тус тус үнэлэв. Түүнчлэн “Мүүдис” агентлаг зээлийн суурь үнэлгээг CAA2 түвшнээс CAA1 болгон ахиулаад байна.** Энэ нь цаашид дахин санхүүжилт авах, шинэ санхүүжилтийн эх үүсвэрүүд татан төвлөрүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.



FitchRatings

**2023.07.07** Хөгжлийн банк нь 2022-2023 онд активын чанарын асуудлаа шийдвэрлэхэд гол анхаарлаа хандуулан ажиллаж, томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх чухал үүрэг гүйцэтгэдэг цорын ганц бодлогын банкны хувьд Засгийн газрын дэмжлэгийг шаардлагатай тохиолдолд авах бүрэн боломжтойг онцлон B (тогтвортой) түвшинд хэвээр үлдээн үнэлсэн.

STANDARD &POOR'S

**2023.10.04** Хөгжлийн банк нь 100 хувь төрийн өмчит, Монгол Улсын хөгжлийн болон экспорт, импортын банкны үүргийг хэрэгжүүлэгч бодлогын цорын ганц банк тул “Стандард энд Пүүрс” агентлагийн Үнэлгээний хорооны хурлын шийдвэрээр зээлжих зэрэглэлийн үнэлгээг B (тогтвортой) түвшинд хэвээр үлдээсэн.

MOODY'S

**2023.12.28** Хөгжлийн банк нь 2023 онд эргэн төлөгдөх “Ди Би Эм 2023” 500 сая ам.долларын Евробонд болон 30 тэрбум иенийн Самурай бондыг өөрийн эх үүсвэрээр, цаг хугацаанд нь амжилттай төлж барагдуулан гадаад өрийн дарамтаас гарсан тул “Мүүдис” агентлаг зээлжих зэрэглэлийг B3 буюу тогтвортой түвшинд хэвээр үлдээж, банкны зээлийн суурь үнэлгээг CAA2 түвшнээс CAA1 болгон ахиулан үнэлэв.

## ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙГ МӨНГӨЖҮҮЛЭХ АЖИЛ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

Хөгжлийн банкны зээлийн өр төлбөрт тооцон хүлээн авсан үл хөдлөх эд хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, мөнгөжүүлэх үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод зохион байгуулан ажиллалаа.

Өмчлөх бусад үл хөдлөх эд хөрөнгө (ӨБҮХХ)-ийг худалдан борлуулах энэхүү ажлын хүрээнд Хөгжлийн банк өөрийн цахим хуудсаар дамжуулан санал авах системийг нэвтрүүлж, ирүүлсэн саналын мэдээллийг бодит цагийн горимоор харуулах, санал ирүүлэгчийн мэдээллийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын төлөөллүүдийн хамт, хөндлөнгийн хяналт дор зохион байгуулан ажиллав. Үүний үр дүнд нийт 62 үл хөдлөх хөрөнгийг 9.5 тэрбум төгрөгөөр худалдан борлууллаа.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Түрээсийн орон сууц хөтөлбөрийн тодорхой хэсгийг Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн. Энэ хүрээнд 2019-2020 онд



1,542 айлын орон сууц ашиглалтад орсон бөгөөд аймаг, нийслэлийн засаг даргатай байгуулсан гэрээгээр 2023 онд 12.9 тэрбум төгрөг эргэн төлөгдлөө.

# СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТӨСЛҮҮДЭД ₮79.6 ТЭРБУМЫН САНХҮҮЖИЛТ ОЛГОВ

## ЗЭЭЛ ОЛГОЛТ

Хөгжлийн банк 2023 онд зээлдэгчидтэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, стратегийн ач холбогдол бүхий газрын тос, эрчим хүчний салбарын төслүүдэд нийт 79.6 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний санхүүжилтийг төслийн гүйцэтгэлд үндэслэн олгов.

**САНХҮҮЖИЛТ**

**₮5,179,798,573**

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ДАГУУ

**МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХХК**



Түлш, шатахуунаа дотооддоо үйлдвэрлэж, газрын тосны эцсийн бүтээгдэхүүнийг дотоодоосоо хангах, цаашлаад шатахууны импортын хараат байдлыг бууруулж, гадаад валютын гарах урсгалыг бууруулах зэрэг олон талын ач холбогдолтой Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийн дэд бүтцийн ажлыг Хөгжлийн банкнаас санхүүжүүлж байгаа юм. Энэхүү санхүүжилтийн хүрээнд

- 27 км төмөр зам – 100%
- 17 км авто зам - 100%
- Дэд станц, 17 км цахилгаан хангамжийн ажил - 100%
- Үйлдвэрийн талбайн тэгшилгээ, усан хангамжийн худгийг хамгаалах хашаа - 100%
- Үйлдвэрийн ажилчдын 550 айлын орон сууц – 63%

бүтээн байгуулалтууд хийгдээд байна.

**₮74,373,557,534**

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ДАГУУ

**ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК**



Дорнод аймаг дахь Чойбалсангийн Дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50МВт-аар өргөтгөх 81.9 сая ам.долларын төсөвт өртөг бүхий төслийн санхүүжилтийн 75 орчим хувийг Хөгжлийн банк БНХАУ-ын Хөгжлийн банкнаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрээр санхүүжүүлж байна.

Уг төсөл хэрэгжсэнээр Дорнод, Сүхбаатар аймгийн 36 сумын айл өрх, 3,100 гаруй аж ахуйн нэгж болон тухайн бүс нутгийн өсөн нэмэгдэж буй уул уурхайн салбарын эрчим хүчний эрэлт хэрэгцээг тасралтгүй, найдвартай эрчим хүчээр хангах боломж бүрдэх юм. Түүнчлэн аймгийн төв болох Чойбалсан хотын 800 гаруй аж ахуйн нэгж, 6,000 гаруй өрхийг дулаанаар хангана.

**НИЙТ ДҮН ₮79,553,356,107**

Хөгжлийн банк 2023 онд шинээр зээл олгоогүй ч “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх боломжтой төсөл, хөтөлбөрийн анхан шатны судалгааг гүйцэтгэж байна.

## ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ

Хөгжлийн банк 2023 онд гэрээний үүргийг хангуулах ажлыг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгасан бөгөөд үнэт цаасны төлбөрт шаардлагатай нөөц хөрөнгө, гадаад валютын бэлэн байдлыг хангахад анхаарч ажиллав. Энэ хүрээнд зээлийн эргэн төлөлтөөс мөнгөн хөрөнгөөр 515.1 тэрбум төгрөг, ӨБҮХХ-өөр 1.4 тэрбум төгрөгтэй тэнцэх

хэмжээний хөрөнгө хүлээн авсан. Улмаар өнгөрсөн хугацаанд зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлд шилжүүлэн авсан ӨБҮХХ-ийн борлуулалтаас нийт 22.4 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө төвлөрүүлсэн. Өөрөөр хэлбэл, тайлант хугацаанд нийт 537.5 тэрбум төгрөгтэй тэнцэх зээлийн эргэн төлөлтийг төвлөрүүлэв.

| | |
|---|---|
| МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХКК | 0.1 |
| ЦЭЦЭНС МАЙНИНГ ЭНД ЭНЕРЖИ ХХК | 9.3 |
| ГОВЬ ХХК (хаагдсан) | 84.2 |
| МАК ЦЕМЕНТ ХХК (хаагдсан) | 119.6 |
| ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК (хаагдсан) | 45.9 |
| МОНПОЛИМЕТ ХХК (хаагдсан) | 87.1 |
| ВЕСТЕРН ХОЛД ХХК | 19.2 |
| АЧЛАЛ ТРЕЙД ХХК | 26.0 |
| НВЦ ХХК | 3.4 |
| ИМПЕРИАЛ ГОУЛД МАЙНИНГ ХХК | 0.6 |
| ДЦС-4 ТӨХК | 32.5 |
| МОНГЕМА ХХК | 0.0 |
| БУСАД (18 ЗЭЭЛДЭГЧ) | 87.3 |




+

**ӨБҮХХ МӨНГӨЖҮҮЛСЭН 22.4 ТЭРБУМ ТӨГРӨГ**

Тайлант жилд зээлийн үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор шилжүүлэн авсан 1.4 тэрбум төгрөгтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулав. Хөгжлийн банкны удирдлагын зүгээс нэн тэргүүнд зээлийн үүргийн гүйцэтгэлийг мөнгөн хөрөнгөөр хангуулах, зайлшгүй нөхцөлд богино хугацаанд худалдан борлуулах боломжтой хөрөнгө хүлээн авах зарчим баримтлан ажиллаж байна.

Тайлант хугацаанд нийт 12 зээлдэгчийн зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг мөнгөн хөрөнгөөр бүрэн хангуулж 358.5 тэрбум төгрөгийг төвлөрүүллээ.

### ХААГДСАН ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

| № | ЗЭЭЛДЭГЧИЙН НЭР | ЭРГЭН ТӨЛӨЛТ (тэрбум төгрөг) |
|---|---|---|
| 1 | МАК ЦЕМЕНТ ХХК | 119.6 |
| 2 | МОНПОЛИМЕТ ХХК | 87.1 |
| 3 | ГОВЬ ХК | 84.2 |
| 4 | ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК | 45.9 |
| 5 | МОН ЛАА ХХК | 7.6 |
| 6 | ХАТАНТ ИНТЕРНЭШНЛ ХХК | 4.8 |
| 7 | КОМПЛАНТ ХХК | 3.2 |
| 8 | ГАН ХҮДЭР ОРД ХХК | 2.4 |
| 9 | МОДУН ХХК | 1.5 |
| 10 | ЭЙЧ ЭНД ЭЙЧ РЕМИКОН ХХК | 0.9 |
| 11 | ДАРХАН МИНЖ ХХК | 0.8 |
| 12 | СТРОЙ-ИНВЕСТ ХХК | 0.6 |
| | **НИЙТ** | **358.5** |

### ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДАГУУ ТӨГРӨГТ ХӨРВҮҮЛСЭН ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

| № | ЗЭЭЛДЭГЧИЙН НЭР | ВАЛЮТ | ДҮН /ТӨГРӨГ/ (тэрбум төгрөг) |
|---|---|---|---|
| 1 | ЭРЭЛ ХХК | ам.доллар, евро | 173.9 |
| 2 | БЭРЭН ГРУПП ХХК | ам.доллар | 135.8 |
| 3 | МОНГОЛ ДРАЙ МИЛК ХХК | ам.доллар | 74.0 |
| 4 | АЧЛАЛ ТРЕЙД ХХК | ам.доллар | 66.9 |
| 5 | МОНПЕЛЛЕТС ХХК | евро | 2.6 |
| | **НИЙТ** | | **453.2** |

# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БАТАЛЛАА

Хөгжлийн банк нь өнгөрсөн 13 жилийн хугацаанд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, зээлийн бодлогоор Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээс гадна байгаль орчин, нийгмийн үр нөлөөллийн үнэлгээ бүхий төслүүдийг санхүүжүүлэх бодлогыг баримталж ирсэн.

2023 оны хувьд тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаанд банкны дотоод бэлэн байдлыг хангах, хүний нөөцийг чадавхжуулахыг зорин ажиллалаа. Энэ хүрээнд банкны тогтвортой санхүүжилтийн бэлэн байдлыг хангах ажлын хэсэг байгуулагдаж, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын санхүүгийн томоохон байгууллагуудаас туршлага судлан цаашид тогтвортой санхүүжилтийн чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны замын зургийг боловсруулав. Түүнчлэн банкны “Тогтвортой хөгжлийн бодлого” болон “Тогтвортой хөгжлийн тунхаг”-ийн баримт бичгийг баталлаа.

Хөгжлийн банк тогтвортой хөгжлийн чиглэлээр Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоотой идэвхтэй хамтран ажилладаг. Тус байгууллагатай 2023 онд хамтын ажиллагаагаа өргөжүүлж, олон улсын хүлэмжийн хийн тайлагналын стандарт боловсруулагч хамтын ажиллагааны байгууллага болох “Нүүрстөрөгчийн Нягтлан Бодох Бүртгэлийн Санхүүгийн Түншлэл (Partnership for Carbon Accounting Financials)-д нэгдсэн нь энэ оны онцлох ажлын нэг байлаа. Ингэснээрээ 2026 оноос эхлэн банкны санхүүжилтийн үйл ажиллагаатай холбоотой хүлэмжийн хийг тооцоолон, тайлагнах үүргийг Хөгжлийн банк хүлээж буй юм. Түүнчлэн олон улсад тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаагаараа нэр хүнд бүхий санхүүгийн томоохон байгууллага болох MUFG (Mitsubishi UFJ Financial Group) банкны дэмжлэгтэй “Тогтвортой санхүүжилтийн хүрээ” боловсруулах чиглэлээр дэмжлэг үзүүлэх баримт бичгийг үзэглэв.

## НОГООН ЗЭЭЛИЙН БАГЦ




**УСНЫ ХЭМНЭЛТТЭЙ ЭКО ЦЕМЕНТИЙН ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛҮҮД**
- Ховд, Дорноговь аймгуудад байрлах хуурай аргын үйлдвэр
- Усны зарцуулалт 38% бага

**ЦАХИЛГААН АВТОБУСНЫ ШИНЭЧЛЭЛ ХИЙХ ТӨСӨЛ**
- Улаанбаатар хотод явж буй автобуснаас ялгарах хүлэмжийн хийг бууруулах

**БУСАД**
- Амьтны гаралтай органик бүтээгдэхүүний үйлдвэрийн төсөл
- Хонины ноосон био бордооны үйлдвэрийн төсөл

**Хөгжлийн банк нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн 17 зорилтоос дараах зорилтуудыг тэргүүн ээлжид дэмжиж ажиллана.**



**Монгол Улсын “Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр”-ийн 8 зарчим**



## СУРГАЛТ, ХӨГЖИЛ

**Нийт ажилтнуудын 25 хувь нь тогтвортой хөгжлийн сургалтад хамрагдав.**

**2023.06.13 - 2023.06.16** — **“Тогтвортой санхүүжилтийн долоо хоног 2023”** арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан сургалт, хэлэлцүүлгүүд

**2023.05.29 - 2023.06.02** — ОХУ-ын ВЭБ.РФ банк, Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагын Банк Хоорондын Нийгэмлэгээс зохион байгуулсан ESG семинар

**2023.09.27** — PCAF Academy-ийн хүлэмжийн хийн тооцоолол, тайлагналын онлайн сургалт



## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАМЫН ЗУРАГ

Хөгжлийн банк цаашид тогтвортой хөгжил болон санхүүжилтийн чиглэлээр хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны төлөвлөгөө баталсан бөгөөд дараах гурван зорилтыг хангах юм. Үүнд:

**1. Тогтвортой хөгжлийн зорилт, стратегийг тодорхойлох**

**2. Зээл, санхүүжилтийн үйл ажиллагаанд ESG-ийн эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх**

**3. Дотоод үйл ажиллагаанд тогтвортой санхүүжилтийг нэвтрүүлэх**

Түүнчлэн энэхүү бодлогын хүрээнд ногоон болон нийгмийн шинж чанартай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээр зорьж, орлогод нийцсэн орон сууцны төсөл, сэргээгдэх эрчим хүчний төсөл хөтөлбөрийг дэмжин ажиллана.

# ТУСГАЙ АКТИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ₮181.2 ТЭРБУМЫГ ТӨЛҮҮЛЭВ






## ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛАН ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ АЖИЛЛАВ

Зээлийн багцын чанар, түүний төвлөрөл, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт, барьцаа хөрөнгийн хүрэлцээ, чанаргүй зээлийг бууруулах үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх зорилгоор зээлийн эрсдэлийн тайланг боловсруулан шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна. Тайлант онд зээлд авах арга хэмжээний санал, зээлийн нөхцөл өөрчлөх, барьцаа хөрөнгө хэсэгчлэн чөлөөлөх, зээлийн ангилал шилжүүлэх, ӨБҮХХ-д авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг асуудлаар зээлийн эрсдэлийн дүгнэлт боловсруулж, “Монгол Улсын Хөгжлийн банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”-ын дагуу зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцож, холбогдох арга хэмжээг авч ажиллав.

## ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛАВ

Зээлээс бусад активт эрсдэлийн сан байгуулах, хүү шимтгэлийн ерөнхий нөхцөлийн тооцооллыг хийж, 2023 оны хоёрдугаар хагас жилд зээлээс бусад активын үнэ цэнийн бууралтыг тооцоолоход шаардлагатай үндэслэл тайлбарын дагуу үнэ цэнийн бууралтыг тооцоолж, эрсдэлийн сан байгууллаа.




## ЧАНАРГҮЙ АКТИВЫГ БУУРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

2023 оны байдлаар тусгай активын үйл ажиллагаагаар нийт 181.2 тэрбум төгрөг төлүүлсэн. Үүнийг шүүхийн үйл ажиллагаагаар нь харуулбал:

**7 ЗЭЭЛ**
Шүүхэд нэхэмжлэл гаргаж, хэрэг хянан хэлэлцэж буй 7 зээлийн 25.95 тэрбум төгрөгийн эргэн төлөлт

**6 ЗЭЭЛ**
Шүүхийн шийдвэр эцэслэсэн 6 зээлийн 39.1 тэрбум төгрөг

**15 ЗЭЭЛ**
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжсэн 15 зээлийн 12.9 тэрбум төгрөг

**6 ЗЭЭЛ**
Эрүүгийн хэрэг үүссэн, прокурорт шилжсэн 22.7 тэрбум төгрөгийн 6 зээлийн эргэн төлөлт хийлгэсэн

**2023 ОНД НИЙТ 5 ЗЭЭЛДЭГЧИЙН 103.3 ТЭРБУМ ТӨГРӨГ ТӨЛӨГДӨЖ, БҮРЭН ХААГДСАН**

## ОЛОН УЛСЫН ISO:37001 СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЭХЭЭР АЖИЛЛАЖ БАЙНА

Хянан нийцүүлэлтийн чиглэлээр олон улсын стандарт шаардлага, хууль, дүрэм журмын хэрэгжилтийг хангах, бодлого, журмаар дамжуулж хяналт хариуцлагын тогтолцоог бий болгох, ажилтнуудыг сургалт мэдээллээр хангах, харилцагчийг таньж мэдэх магадлан шалгах ажиллагааг хэрэгжүүлэн ажиллалаа. Мөн улс төрийн нөлөө бүхий этгээдийн хамаарал болон эцсийн өмчлөгчийг тогтоож, үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр I хамгаалалтын бүсийн нэгжүүдийг мэдээллээр хангаж ажиллав. Түүнчлэн гүйлгээний хяналт хийх, олон улсын хориг арга хэмжээтэй тулган шалгах орчин үеийн автоматжсан программыг үйл ажиллагаандаа нэвтрүүллээ. Авлигын эрсдэлийг бууруулах хүрээнд олон улсын ISO:37001 стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор бодлого, журмуудаа шинэчлэх ажлыг эхлүүлэв.

## ОЛОН УЛСЫН ЧАНАРЫН БОЛОН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА, АВЛИГЫН ЭСРЭГ МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЭХЭЭР АЖИЛЛАЖ БАЙНА




Хөгжлийн банк нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг Олон улсын Базелийн хороо, Монголбанк болон бусад зохицуулагч байгууллагуудаас тогтоосон дүрэм, журам, заавар, зөвлөмж, стандартын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд Хөгжлийн банк нь тогтвортой үйл ажиллагаа явуулах, бизнес төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх, эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс, стратегийн чиглэлдээ хүрэхийн тулд эрсдэлийг тогтоосон түвшинд хүлээж авах чадвартай байх, эрсдэлд суурилсан оновчтой бодлого хэрэгжүүлэх, эрсдэлийн соёлын тогтолцоог нэвтрүүлэх үндсэн зорилтыг хангах зорилтын хүрээнд эрсдэлийн аппетитын тогтолцоог үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Түүнчлэн олон улсын ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO27001:2022 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, ISO37001:2016 Авлигын эсрэг менежментийн тогтолцооны стандартуудыг банкны үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр ажиллаж байгаа юм.

## САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭВ

Санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гадаад валютаар нээлттэй позицын хэмжээ, хөрвөх чадвар бүхий актив, пассив хөрөнгийн харьцааг хангуулж ажиллав. Хөрөнгийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх ажлын хүрээнд санхүүгийн эрсдэлийн дүгнэлтээр хангаж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэв. Түүнчлэн зах зээл дэх гэнэтийн өөрчлөлт, савлагаанаас учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор олон улсын болон дотоодын банк санхүүгийн байгууллагуудтай валютын арилжаа, хэлцэл хийж хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

# ЦАХИМ САНГУУДЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭВ

Хөгжлийн банк дотоод үйл ажиллагаагаа сайжруулах чиглэлээр ажиллалаа. Тухайлбал, үйл ажиллагаанд хууль тогтоомж, дүрэм, журмын нийцлийг хангуулах, хууль зүйн аливаа эрсдэл гарахаас урьдчилан сэргийлэх, Хөгжлийн банканд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бодлого, дүрэм, журмын нийцлийг хянаж, шинэчлэн батлагдсан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай журмуудыг боловсруулсан.

Мөн мэдээллийн систем, цахим баримт бичиг нууцлал, хамгаалалт, хүртээмжтэй, аюулгүй байдлыг ханган, дотоод үйл ажиллагааны процессыг автоматжуулах, мэдээллийн урсгалыг боловсронгуй болгох, тайлагналын бодитой, үнэн зөв, түргэн шуурхай байдлыг сайжруулан ажиллаж байна.

Түүнчлэн Хөгжлийн банкны хүний нөөцийн бодлогыг сайжруулж, байгууллагын хөдөлмөрийн харилцааг зохицуулах, ажилтнуудыг идэвхжүүлж, хөгжүүлэхийн зэрэгцээ архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлж, банкны өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн, жигд явуулж байна.

Тайлант хугацаанд дараах шийдвэрүүд батлагдсаныг тухай бүр цахим системд байршуулан цаасан болон цахимаар хадгалан архивын нэгж үүсгэн ажиллаж байна:

**1,280** АЛБАН БИЧИГ

**144** ӨРГӨДӨЛ

**1,419** ГАДАГШАА ЯВСАН АЛБАН БИЧИГ

Хүний нөөцтэй холбоотой: **166** ТУШААЛ

Үйл ажиллагаатай холбоотой: **157** АЛБАН БИЧИГ

Тайлант хугацаанд архивын нөхөн баяжилтаар 552 хадгаламжийн нэгж хүлээн авч, хамтран ажиллах, худалдах худалдан авах, хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх зэрэг чиглэлээр 147 гэрээ байгуулагдсаныг бүртгэн, дугаар олгож, цаасан болон цахим хэлбэрээр хадгалж ашиглуулж байна.

## ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Тайлант хугацаанд Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хууль тогтоомж, дүрэм, журмын нийцлийг хангуулан, хууль зүйн аливаа эрсдэл гарахаас урьдчилан сэргийлж, хууль, эрх зүйн дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



- Хөгжлийн банкнаас олон улсын хөрөнгийн зах зээлд арилжсан Самурай бонд болон Ди Би Эм 2023 Евробондын эргэн төлөлтийн эх үүсвэрийг хуулийн хүрээнд бүрдүүлж ажиллалаа.
- Чанаргүй активыг бууруулах ажлын хүрээнд хууль зүйн зөвлөмж, дүгнэлт болон гэрээ хэлцэл, баримт бичгийн төслөөр холбогдох газар, хэлтсүүдийг дэмжин ажиллаж, банкны хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хуулийн болон шүүхийн байгууллагад амжилттай хамгааллаа.
- Улсын Их Хурлаас Хөгжлийн банкны үйл ажиллагааны хүрээг өргөтгөн экспорт, импортын банкны чиг үүргийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэнтэй холбогдуулан бусад улс орны “Эксим” банкны хууль тогтоомжийг судалж, үр дүнг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөлд тусган ажиллалаа.

## ДОТООД ХЯНАЛТ

Дотоод хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор 2023 онд Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан удирдамжийн дагуу Хөгжлийн банкны 2022 оны дотоод шийдвэрүүд, баримт бичгийн бүрдэл, түүний хууль зүйн нийцэл, Хэвлэл мэдээлэл, хүний нөөцийн үйл ажиллагаа болон худалдан авах үйл ажиллагааны хяналтыг сайжруулж ажиллав.

## МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ, ЦАХИМЖУУЛАЛТ



Тайлант хугацаанд Хөгжлийн банкны Мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангах, сайжруулах, сүүлийн үеийн шинэ систем, программыг нэвтрүүлэх, механик ажиллагааг автоматжуулж ажилтнуудын цаг хугацааг хэмнэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хөгжлийн банкны өдөр тутмын үйл ажиллагаанд ашигладаг “НЭС” үндсэн бүртгэлийн систем, “Оракл датабэйс”, “Майкрософт 365”, “Тренд майкро апекс ван” программ хангамжуудын лицензийг сунгаж, системд тохируулах ажлуудыг тухай бүрд нь зохион байгуулж ажиллав. Мөн “Фортигэйт” галт хана төхөөрөмж, виртуал серверийн түрээс, нөөц интернэт, нөөц төвийн түрээсийн үйлчилгээний хугацааг сунгах ажлыг зохион байгуулсан. Түүнчлэн серверийн өрөөнд гал унтраах иж бүрэн автомат системийг ашиглалтад оруулж, гарч болзошгүй гэнэтийн галын аюулаас бүрэн сэргийлэх нөхцөлийг бүрдүүллээ.

Мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах ажлын хүрээнд дотоод, гадаад сүлжээний топологийг өөрчилж сайжруулах ажил хийж гүйцэтгэв. Үүнээс гадна Майкрософт 365 системд хөгжүүлж нэвтрүүлсэн чухал мэдээлэл бүхий цахим сангуудын аюулгүй байдлыг хангах зорилгоор автоматаар нөөц хувь бэлтгэх "Veeam Backup for Microsoft 365" системийг туршин нэвтрүүлж, ажиллагаанд орууллаа.

Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах үйл ажиллагааны хүрээнд борлуулах хөрөнгийн мэдээллийг банкны веб сайтад байршуулах, худалдан авагчийн санал авах веб программыг хөгжүүлэн, үндсэн үйл ажиллагаанд амжилттай нэвтрүүлэв.

“Майкрософт 365” системд тулгуурлан “Дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилт” программыг хөгжүүлэн нэвтрүүлж, дотоод аудитаас ирүүлсэн зөвлөмж, түүний биелэлтийг цаг тухай бүрд нь бүртгэн, тайлагнах, хэрэгжилтийг тогтмол хянах боломжийг бүрдүүллээ. Мөн гадаад, дотоод томилолтын бүртгэл, шат дараалсан зөвшөөрөл олгох процессыг автоматжуулав.

Ди Би Эм
Ассет Менежмент ҮЦК ХХК

ДИ БИ ЭМ
ЛИЗИНГ

# "ДИ БИ ЭМ ЛИЗИНГ" ХХК АШИГТ АЖИЛЛАГААГАА 60% НЭМЭГДҮҮЛЛЭЭ

"Ди Би Эм лизинг" ХХК-ийг Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдал, эдийн засгийн хөгжлийг дэмжих стратегийн төсөл хөтөлбөрүүдэд дунд болон урт хугацаатай санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх замаар үйлдвэржилтийг дэмжих, урт хугацаатай, өртөг багатай тоног төхөөрөмжийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэх зорилготойгоор 2017 онд байгуулсан.

"Ди Би Эм лизинг" ХХК нь Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу бүтэц, зохион байгуулалтаа шинэчилж, 2023 онд 15 ажилтны орон тоотойгоор ашигт ажиллагаагаа нэмэгдүүллээ.

## КОМПАНИЙН АКТИВ ХӨРӨНГӨ:

**2022** ОНД **115.1** ТЭРБУМ ТӨГРӨГ

**2023** ОНД **120.4** ТЭРБУМ ТӨГРӨГ

**+5%** Үүнээс санхүүгийн түрээсийн авлага **2023 онд 43.8 тэрбум** төгрөг болсон.

## ХУРИМТЛАГДСАН АШИГ:

**2022** ОНД ХУРИМТЛАГДСАН АШИГ **11.9** ТЭРБУМ ТӨГРӨГ

**2023** ОНД ХУРИМТЛАГДСАН АШИГ **19.1** ТЭРБУМ ТӨГРӨГ

ӨМНӨХ ОНООС **60.5%** ӨССӨН

## ТӨЛСӨН ТАТВАРЫН ДҮН:

**2022** ОНД **2.2** ТЭРБУМ ТӨГРӨГ

**2023** ОНД **0.9** ТЭРБУМ ТӨГРӨГ ТӨВЛӨРҮҮЛСЭН

## ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ:

**2022** ОНД **88%**

**2023** ОНД **247%**

ӨМНӨХ ОНООС **1.8** ДАХИН ӨССӨН

## САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ:

Компанийн **2023 оны** үйл ажиллагааны төлөвлөгөөнд **32.6** **ТЭРБУМ** төгрөгийн санхүүгийн түрээсийн эргэн төлөлтийг хангуулахаар төлөвлөсөн.

Жилийн эцсийн тайлант хугацаанд **43.3** **ТЭРБУМ** төгрөгийн эргэн төлөлтийг хангуулж, гүйцэтгэл **133 хувьтай** байлаа.

**ҮҮНД:**

- Санхүүгийн түрээсийн багцын чанарыг сайжруулах ажлын хүрээнд Хөгжлийн банктай Менежментийн гэрээг байгуулж, түрээслэгч "Баруун баян транс" ХХК-ийн санхүүгийн түрээсийн өр төлбөрт 1.0 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийг гүйцэтгүүлэв.

- Санхүүгийн түрээсийн гурван гэрээний үүргийн гүйцэтгэлийг бүрэн хангуулж, гэрээг дүгнэснээс гадна хоёр түрээслэгчийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийг бүрэн барагдуулж, хэвийн ангилалд шилжүүлсэн.

- Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Хөдөө аж ахуйг дэмжих сангаас олгосон санхүүгийн түрээсийн хугацаа хэтэрсэн төлбөрийг барагдуулах ажлын хүрээнд 2023 онд 26.1 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийг төлүүлсэн.

## АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫГ 116МВТ-ААР ӨРГӨТГӨХ ТӨСЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭВ











Улсын Их Хурлаас баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгасан төсөл хөтөлбөрт санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн хүчин чадлыг нэмэгдүүлэх өргөтгөлийн төсөлд 42.7 тэрбум төгрөгийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлсэн ба уг өргөтгөлийн төсөл 86.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

## ТӨСЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ:

**1.4-1.8**
САЯ

Станцын үйлдвэрлэлийн хэмжээ 1.4-1.8 сая Гкал хүртэл нэмэгдэнэ

**40**
ГАРУЙ

40 гаруй халаалтын зуухыг зогсоож, агаарын бохирдлын хэмжээг бууруулна

**+30**
АЖЛЫН БАЙР

Тогтмол 30 ажлын байр нэмэгдэнэ

ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ

Улаанбаатар хотын зүүн бүсийн гэр хорооллын дахин төлөвлөлт, барилгажуулалт нэмэгдэнэ

Тус компаниас хэрэгжүүлж буй “Амгалан дулааны станцын өргөтгөл” төсөл нь 2023 оны тавдугаар сард Казахстан улсын Алмати хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүсийн Хөгжлийн санхүүгийн байгууллагуудын холбооны 46 дахь чуулга уулзалтаар “Дэд бүтцийн бүтээн байгуулалт”-ын шагнал хүртсэн.

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГ ХАМТРАН УДИРДАХААР “ДЕЛФОС ИНТЕРНЭШНЛ”-ТЭЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАВ

“Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-ийг хөрөнгө оруулалтын менежментийн мэргэжлийн үйлчилгээг хөрөнгө оруулагчдад үзүүлэх замаар хөрөнгийн зах зээлийг бэхжүүлэх, Монгол Улсад хөгжлийн санхүүжилтийн тогтвортой механизмыг бий болгож, нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих төслүүдийг хөрөнгө оруулалтын сангаар дамжуулан санхүүжүүлэх зорилгоор 2017 онд байгуулсан.

## ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компани нь дараах хувийн хөрөнгө оруулалтын сангуудыг үүсгэн байгуулах зорилгоор холбогдох дүрэм, журам, баримт бичгийг боловсруулах, хүний нөөцийг бэхжүүлэх болон санд хөрөнгө оруулах боломжит хөрөнгө оруулагчидтай харилцаа холбоо тогтоох зэрэг шаардлагатай бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үүнд:

1. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих төслүүдийг хөрөнгө оруулалтын сан (ХОС)-гаар дамжуулан санхүүжүүлэх үндсэн зорилгын хүрээнд “Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл”-ийн дундын санхүүжилтийн механизмыг хэрэгжүүлэх “Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууц”;
2. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор “Үндэсний Стратегийн хөрөнгө оруулалтын сан”;
3. Монгол Улсын ногоон хөгжлийг дэмжих зорилгоор “Монголын Ногоон хөгжлийн сан”-г үүсгэн байгуулахаар ажиллаж байна.

## ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА




Байгал орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын нөлөөллийн стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, нөлөөлөл өндөр төслүүдэд хөрөнгө оруулалт татах, ноолуурын салбарт холимог санхүүжилтийн механизмыг нэвтрүүлэхэд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-тэй хамтран ажиллах гэрээ байгуулсан. Тус гэрээний дагуу ноолуурын үйлдвэрлэлийн утас ээрэх шатанд технологийн болон санхүүжилтийн хэрэгцээ шаардлагыг тооцоолох зорилгоор НҮБХХ-тэй хамтран салбарын яам, холбоо, санхүүжүүлэгч байгууллагууд болон 10 гаруй аж ахуйн нэгж байгууллагатай тогтмол харилцан холбогдох уулзалтуудыг зохион байгуулж, зах зээлийн судалгааг боловсруулсан.

Үүсгэн байгуулахаар ажиллаж буй хөрөнгө оруулалтын сангуудад 150 сая.ам доллар хүртэлх хөрөнгө оруулалт татах, санг хамтран удирдахаар Их Британийн “Делфос интернэшнл” байгууллагатай гэрээ байгуулсан бөгөөд гэрээний дагуу сангуудын танилцуулгыг хамтран боловсруулж, хөгжлийн санхүүжилтийн байгууллагуудад хүргүүлсэн.

# Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан болон
Хараат Бус Аудиторын Тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр
дуусгавар болсон тайлант жил

**ГАРЧИГ**

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД:
Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлан....1
Нэгтгэсэн Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан....2
Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан....3
Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан....4
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
1. БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН....6
2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН СУУРЬ БА ТАЙЛАНГ БЭЛТГЭХ, ТОЛИЛУУЛАХ ҮНДЭСЛЭЛ....7
3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД....8
4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНЭЛЭМЖ БА ТОДОРХОЙ БУС БАЙДЛЫН ТААМАГЛАЛ ТООЦООЛЛЫН ҮНДСЭН ЭХ СУРВАЛЖ....18
5. ШИНЭЭР ГАРСАН БОЛОН ӨӨРЧЛӨГДСӨН СТАНДАРТ, ТАЙЛБАРУУДЫН ХЭРЭГЖИЛТ....20
6. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ....22
7. БАНКУУДАД БАЙРШУУЛСАН МӨНГӨН ХАДГАЛАМЖ....23
8. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮД....24
9. БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР ХЭМЖСЭН БОРЛУУЛАХАД БЭЛЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ....24
10. АШИГ АЛДАГДЛААРХ ҮНЭ ЦЭНЭЭР ИЛЭРХИЙЛЭГДСЭН САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ....25
10.1 ДУУСГАВАР ХУГАЦАА ХҮРТЭЛ ЭЗЭМШИХ ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ....25
11. ЗЭЭЛ, УРЬДЧИЛГАА БА ТҮРЭЭСИЙН АВЛАГА....26
11.1 ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ....29
12. БУСАД ХӨРӨНГӨ....31
13. ҮНДСЭН ХӨРӨНГӨ БОЛОН БИЕТ БУС ХӨРӨНГӨ....32
14. ХАРИЛЦАГЧДЫН ХАРИЛЦАХ....33
14.1 ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖ....33
15. БУСАД ӨР ТӨЛБӨР....34
16. БУСАД БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ....34
17. ӨРИЙН БИЧИГ....35
18. БУСДААС АВСАН ЗЭЭЛ....36
18.1 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ҮҮССЭН ӨР ТӨЛБӨРИЙН ТОХИРУУЛГА....37
19. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ....38
20. ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ....41
21. ХҮҮГИЙН ОРЛОГО....41
22. ХҮҮГИЙН ЗАРДАЛ....42
23. БУСАД ОРЛОГО....42
24. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ТЭГШИТГЭЛИЙН ОЛЗ БОЛОН ГАРЗ, ЦЭВЭР....43
25. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН ОЛЗ БОЛОН ГАРЗ, НИЙТ....43
26. УДИРДЛАГЫН БОЛОН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ....44
27. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР....45
28. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА....48
29. ХЭМЖИЛТИЙН ТӨРЛӨӨРХ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛҮҮДИЙН ТОЛИЛУУЛГА....67
30. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ БА ӨР ТӨЛБӨРИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ....69
31. САНХҮҮГИЙН ҮҮРЭГ БА БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР....72
32. СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ....73
33. ТАЙЛАНТ ХУГАЦААНЫ ДАРААХ ҮЙЛ ЯВДЛУУД....73
34. МОНГОЛ ОРЧУУЛГА....73

***МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК***

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД: | Б.ДОРЖСЭМБЭД<br>Д.БАТБААТАР<br>Б.БОЛОРМАА<br>Г.ХОНГОР<br>Б.ЧОЙЖИЛ |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД: | Д.СУВДАА<br>Б.ЭНХТУЯА<br>Г. БУЯН<br>С.НАСАНЖАРГАЛ |
| НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: | Г.ОЮУНДАРЬ |
| АЛБАН ХАЯГ: | Монгол Улс, Улаанбаатар 14210, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, 19 байр, 12 дугаар давхар |
| АУДИТОР: | НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК<br>Монгол Улс, Улаанбаатар 13290, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо, Юби Тауэр Плас оффис, 609 тоот |

## УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК (цаашид "Банк" гэх) болон түүний охин компаниуд (цаашид "Групп" гэх)-ийн Гүйцэтгэх Захирал Жалсрай овогтой Батаа болон Тайлан Бүртгэлийн Хэлтэсийн Захирал Батсайхан овогтой Билэгтогтох бид энд хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Группийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад тулгуурлан Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн болохыг батламжилж байна.

Бид Группийн санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөв илэрхийлж чадах, нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Тодруулга 2 ба 3-т дурьдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах, мөн Группийг зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Бид Группийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Бид санхүүгийн тайланг тодруулгын хамт бэлтгэхдээ Групп нь тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгон, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Банкны удирдлагаас Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.

| | |
|---|---|
| ЖАЛСРАЙН БАТАА | БАТСАЙХАНЫ БИЛЭГТОГТОХ |
| Гүйцэтгэх Захирал | Тайлан Бүртгэлийн Хэлтэсийн Захирал |

Монгол Улс, Улаанбаатар хот

2024 оны 3 дугаар сарын 20-ны өдөр

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

*"Монгол Улсын Хөгжлийн Банк" ХХК-ийн Хувьцаа Эзэмшигч болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:*

### Аудиторын дүгнэлт

Бид "Монгол Улсын Хөгжлийн Банк" ХХК (цаашид "Банк" гэх) болон түүний охин компаниуд (цаашид хамтад нь "Групп" гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх сайн дурын үндсэн дээр бэлтгэгдсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, мөн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй болон тайлбар тодруулгуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан сайн дурын үндсэн дээр бэлтгэгдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Группийн нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн үр дүн болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-д тулгуурлан Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл ("НБЁЗОУСЗ")-ийн баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"–ийн дагуу Банкнаас хараат бус бөгөөд НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

### Асуудлыг Онцолсон Зүйл

Банк нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хөтөл ХХК-ийн 376 тэрбум төгрөгийн зээлийн төлбөрийн үлдэгдэлд 191 тэрбум төгрөгийн барьцаа хөрөнгийн 80 хувиар тооцсон талаарх санхүүгийн тайлангийн 11 дүгээр тодруулгад тусгасан асуудлыг онцолж байна. Барьцаа хөрөнгийн үнэлгээ нь Монгол Улсын хууль сахиулах байгууллагаас томилогдсон хараат бус хөндлөнгийн үнэлгээгээр тогтоогдсон болно. Мөн 2023 оны 12 дугаар сарын 24-өөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний хугацааны зөрүүгээс үүссэн зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн тооцооллын зөрүүг Банк нь санхүүгийн тайланд тохируулаагүй байна. Эдгээр аудитын онцлох асуудал нь хязгаарлалттай аудитын дүгнэлт өгөх үндэслэл болохгүй болно.

### Аудитын Гол Онцлох Зүйлс

Аудитын гол онцлох зүйлс гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн тусдаа санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал ач холбогдол бүхий зүйлс юм. Бид нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр аудитын гол онцлох зүйлсийг бүхэлд нь авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Зээлийн болзошгүй эрсдэлийн сан

| Аудитын гол онцлох зүйлс | Аудитын гол онцлох зүйлсийг хэрхэн шийдвэрлэсэн талаар |
|---|---|
| СТОУС-д тулгуурлан Монгол Банкнаас баталсан заавар, журмын дагуу зээлийн ангилал болон холбогдох болзошгүй эрсдэлийн сангийн хэмжээг тодорхойлохдоо чанарын хүчин зүйлс болон тэр дундаа үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг оршин байгаа эсэх, түүнчлэн ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг харгалзан үзэх шаардлагатай байдаг.<br><br>2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээлийн болзошгүй эрсдэлийн сан 825 тэрбум төгрөг байсан ба энэ нь нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг тул аудитад чухал ач холбогдолтой байсан.<br><br>Түүнчлэн, Группийн үнэлгээний үйл явц нь нарийн төвөгтэй, үнэлэмж их шаарддаг бөгөөд үнэ цэний бууралтын шинж тэмдэг болох зээлийн эргэн төлөлтийн хуваарийн зөрчил, зээлдэгчийн санхүүгийн болон эдийн засгийн нөхцөл байдал, барьцаа хөрөнгийн үнэ цэнийг авч үзсэн ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэний тооцоолол зэрэг хүчин зүйлст суурилсан байдаг. | Бид аудитын горимууд тэр дундаа дараах гол горимуудыг хийж гүйцэтгэсэн:<br><br>Зээлийн ангилал болон зээлийн эрсдэлийн чанарын зохистой байдлыг шалгах зорилгоор зээлийн хувийн хэргүүдээс түүвэрлэн шалгасан.<br><br>Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн зөрчлийн талаарх мэдээллийн найдвартай байдлыг шалгах зорилгоор мэдээллийн технологийн хяналтуудыг шалгасан.<br><br>Зээлийн нэгдсэн мэдээллийн сангийн өгөгдлийг зээлийн хувийн хэрэг болон зээлийн баримт бичигтэй харьцуулах байдлаар түүвэрлэн шалгасан.<br><br>Банкны ирээдүйн мөнгөн урсгалын үнэ цэний үнэлгээг Группийн дэвшүүлсэн гол таамаглалууд болох ашиглаж байгаа барьцаа хөрөнгийн үнэ цэнэ болон борлуулах хугацааны хэрэгжих боломжийг үнэлэх замаар мөн түүнчлэн Банкны тооцооллыг холбогдох бизнесийн орчин болон үнэ цэний бууралтын шинж тэмдэг илэрсэн зээлдэгчийн онцлог нөхцөл байдлын харьцуулах байдлаар шалгасан. |
| Тодруулга 3 "Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого", тодруулга 4 "Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдлын таамаглал тооцооллын үндсэн эх сурвалж" болон тодруулга 11 "Зээл ба Урьдчилгаа" харна уу. | |

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Өмчлөх Бусад Хөрөнгө

| Аудитын гол онцлох зүйлс | Аудитын гол онцлох зүйлсийг хэрхэн шийдвэрлэсэн талаар |
|---|---|
| Өмчлөх бусад хөрөнгийг санхүүгийн тайланд анх хүлээн зөвшөөрөх болон дараа үеийн хэмжилтээр бүртгэхдээ Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандартыг мөрдөнө. Өмчлөх бусад хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө холбогдох зээл болон зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн бүртгэлийг буцааж, борлуулахад бэлэн өмчлөх бусад хөрөнгийг бүртгэнэ.<br><br>2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Өмчлөх бусад хөрөнгийн үлдэгдэл 242 тэрбум төгрөг байсан ба энэ нь тусдаа санхүүгийн тайланд материаллаг дүнтэй тул аудитад чухал ач холбогдолтой байсан.<br><br>Түүнчлэн, Группийн үнэлгээний үйл явц нь нарийн төвөгтэй, үнэлэмж их шаарддаг бөгөөд үнэ цэний бууралтын шинж тэмдэг болох зээлийн эргэн төлөлтийн хуваарийн зөрчил, зээлдэгчийн санхүүгийн болон эдийн засгийн нөхцөл байдал, барьцаа хөрөнгийн үнэ цэнийг авч үзсэн ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэний тооцоолох зэрэг хүчин зүйлст суурилсан байдаг. | Бид аудитын горимууд тэр дундаа дараах гол горимуудыг хийж гүйцэтгэсэн:<br><br>Өмчлөх бусад хөрөнгийг анхлан тэдгээрийн бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн ба холбогдох зээлийн буцаан авалт хийгдсэн өдрөөрх үлдэгдэл дүнгийн аль багаар нь хүлээн зөвшөөрөх бөгөөд холбогдох зээл ба урьдчилгаа үнэ цэний бууралтын сангийнх нь хамт тайлан тэнцэлд үл хүлээн зөвшөөрсөн эсэхийг тус тус үнэлсэн.<br><br>Холбогдох зээлийн үлдэгдэл нь зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн хамт балансаас хасагдсан эсэхийг шалгасан.<br><br>Өмчлөх бусад хөрөнгийг борлуулах зорилгоор гарсан зардлуудыг тухайн хөрөнгийн өртөгт оруулан капиталжуулсан эсэхийг шалгасан.<br><br>Санхүү байдлын тайланд хүлээн зөвшөөрөгдсөн өмчлөх бусад хөрөнгийн дүнгийн зохистой эсэхийг шалгах зорилгоор Группийн хийсэн хөрөнгийн үнэлгээг түүвэрлэн шалгасан мөн мэдээллийн технологийн хяналтууд хийгдсэн.<br><br>Өмчлөх бусад хөрөнгийн мэдээллийн санд байгаа мэдээллийг түүвэрлэн шалгасан. |
| Тодруулга 3 "Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого", тодруулга 4 "Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдлын таамаглал тооцооллын үндсэн эх сурвалж" болон тодруулга 11.1 Өмчлөх Бусад Хөрөнгийг харна уу. | |

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Өрийн бичиг болон Бусдаас авсан зээл

| Аудитын гол онцлох зүйлс | Аудитын гол онцлох зүйлсийг хэрхэн шийдвэрлэсэн талаар |
|---|---|
| Банкнаас гаргасан өрийн үнэт цаасанд өрийн бичиг болон Бусдаас авсан зээл орно. Өрийн бичиг болон Бусдаас авсан зээлийг ангилах, анх хүлээн зөвшөөрөх болон дараа үеийн хэмжилтийн бүртгэлүүд нь нарийн төвөгтэй байдаг. Группээс гаргасан өрийн бичиг, бусдаас авсан зээл зэрэг өрийн үнэт цааснуудыг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Зээлээр авсан эх үүсвэрийн хорогдуулсан өртгийг тооцохдоо үр ашигт хүүгийн аргыг ашиглан гүйлгээтэй холбоотой гарсан аливаа зардлуудыг тооцно.<br><br>2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Өрийн бичиг болон Бусдаас авсан зээлийн үлдэгдэл 687 тэрбум болон 707 тэрбум төгрөг тус тус байгаа бөгөөд энэ нь тусдаа санхүүгийн тайланд материаллаг дүнтэй тул аудитад чухал ач холбогдолтой байсан. | Бид аудитын горимууд тэр дундаа дараах гол горимуудыг хийж гүйцэтгэсэн:<br><br>Аудитын ажлын хүрээнд Өрийн бичиг ба Бусдаас авсан зээлийн хорогдуулсан өртгийн хэмжилт болон хүлээн зөвшөөрөлттэй холбоотой мэдээллийг цуглуулж, үүнд хийгдэх гол хяналтын бүтэц, үр дүнтэй байдлыг үнэлж дүгнэсэн.<br><br>Зээлээр авсан эх үүсвэрийн хорогдуулсан өртгийг тооцохдоо үр ашигт хүүгийн аргыг ашиглан гүйлгээтэй холбоотой гарсан аливаа зардлуудыг тооцсон эсэхийг түүврийн аргаар шалгасан.<br><br>Групп өөрийн гаргасан өрийн бичгийг эргүүлэн худалдаж авсан тохиолдолд тэдгээрийг санхүүгийн тайлангаас хасаж, төлсөн дүн болон өр төлбөрийн дансны үнэ хоёрын зөрүүгээр өрийн хэрэгслийг данснаас хасахад үүссэн олз эсвэл гарзаар хүлээн зөвшөөрсөн эсэхийг шалгасан (Өр төлбөрийг данснаас хасах).<br><br>Гүйлгээтэй холбоотой гарсан зардлыг тухайн хугацаанд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн эсэхийг баталгаажуулсан.<br><br>Нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартууд болон Группийн мөрдөх журмын дагуу тодруулга болон толилуулгын зохистой байдлыг үнэлсэн. |
| Санхүүгийн Тайлангийн тодруулга 3 "Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, тодруулга 17 Өрийн бичиг, тодруулга 19 Бусдаас авсан зээл. | |

### Бусад Асуудал

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн тайланд Кэй Пи Эм Жи Аудит ХХК аудит хийсэн ба 2023 оны 3-р сарын 17-ны өдөр зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Бусад Мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээх юм. Бусад мэдээлэл гэдэгт жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба нэгтгэсэн санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлан үүнд хамаарахгүй болно. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлангийн өдрөөс хойш бидэнд танилцуулагдахаар хүлээгдэж байна.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Бусад мэдээллийг уншиж танилцан, уг мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг хэмжээгээр нийцэхгүй эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн зүйлс байгаа эсэхийг шалгах нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг, хариуцлага юм.

Жилийн тайлантай танилцах үед бусад мэдээлэлд материаллаг алдаа байна гэж үзвэл энэ талаар бид засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдэгдэх үүрэгтэй.

### Удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС-д тулгуурлан Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь Группийн удирдлагын үүрэг хариуцлага юм. Залилан эсвэл алдааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй тусдаа санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбоотой удирдлагын шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтууд нь мөн энэхүү хариуцлагад хамаарна.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Группийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг тусдаа санхүүгийн тайланд тодруулж, Группийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан тусдаа санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Группийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.

### Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох ба дангаараа эсвэл нэгдсэн дүнгээрээ уг тусдаа санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн ул итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Группийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Группийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Группийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангуудын (үүнд тодруулгууд багтана) ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад илрүүлсэн томоохон асуудлууд, тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Мөн бид засаглах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагыг биелүүлсэн тухай мэдэгдэл хийдэг бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц бүхий л харилцаа болон бусад асуудал, зарим тохиолдолд түүний эсрэг үзүүлсэн хариу үйлдлийн талаар мэдэгдэл хийдэг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас бид тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдолтой гэж үзсэн зүйлсийг аудитын гол онцлох зүйлс хэмээн тодотгосон болно. Бид аудитын гол онцлох зүйлсийг хууль тогтоомжоор нийтэд ил болгохыг хориглоогүй үед эсвэл маш ховор тохиолдолд тайланд тодруулахгүй байх нь тодруулснаас илүүтэйгээр нийтийн эрх ашигт нийцнэ гэж үзсэнээс уг онцлох зүйлсийг тайланд оруулахгүй хэмээн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд эдгээр зүйлсийг тайландаа оруулдаг.

Энэхүү хараат бус аудиторын тайлангийн аудитын гэрээт ажлын партнер нь **Э. Булган** болно.

**НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК**
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг

**Масуд Алам Чоудхори**
Партнер

Батлагдсан

**Э. Булган**
Партнер

Монгол Улс, Улаанбаатар хот
2024 оны 3 дугаар сарын 20-ны өдөр

*Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2023 оны 3 сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайлане хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүй болохыг анхаарна уу. Энэхүү тайлан нь зөвхөн Группийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.*

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн*
*Нэгтгэсэн Санхүү Байдлын Тайлан*

| *Мянган төгрөгөөр* | Тодруулга | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 6 | 144,557,617 | 890,417,205 |
| Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж | 7 | 32,792,377 | 28,931,618 |
| Үүсмэл санхүүгийн хөрөнгө | 8 | - | 21,753,965 |
| Бодит үнэ цэнээр хэмжсэн борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт | 9 | 212,183,194 | 312,472,007 |
| Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө | 10 | 11,807,750 | 19,248,584 |
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаасаарх хөрөнгө оруулалт | 10.1 | 180,962,377 | 568,788,930 |
| Зээл, урьдчилгаа ба түрээсийн авлага | 11 | 1,499,550,207 | 1,835,610,278 |
| Бусад татварын авлага | | 5,858,336 | 7,256,948 |
| Бусад хөрөнгө | 12 | 32,560,700 | 1,557,832 |
| Үндсэн хөрөнгө | 13 | 24,278,795 | 23,955,507 |
| Биет бус хөрөнгө | 13 | 249,670 | 313,785 |
| Өмчлөх бусад хөрөнгө | 11.1 | 241,529,319 | 257,073,386 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 27 | 46,069,491 | 47,331,743 |
| **Нийт хөрөнгө** | | **2,432,399,833** | **4,014,711,788** |
| **Өр төлбөр** | | | |
| Үүсмэл санхүүгийн өр төлбөр | 8 | 4,227,824 | 5,672,829 |
| Харилцагчдын харилцах | 14 | 8,815,342 | 4,798,957 |
| Хугацаат хадгаламж | 14.1 | 34,123,720 | - |
| Гэрээний өр төлбөр | 11.1 | 3,828,332 | 3,852,750 |
| Бусад өр төлбөр | 15 | 4,197,292 | 3,560,297 |
| Орлогын албан татварын өглөг | | 1,024,106 | 9,680,055 |
| Бусад татварын өглөг | | 118,285 | 21,967 |
| Бусад банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан хөрөнгө | 16 | 225,210,272 | 29,583,716 |
| Өрийн бичиг | 17 | 687,477,828 | 2,572,205,220 |
| Бусдаас авсан зээл | 18 | 707,401,712 | 582,540,605 |
| **Нийт өр төлбөр** | | **1,676,424,713** | **3,211,916,396** |
| **Өөрийн хөрөнгө** | | | |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 20 | 1,216,300,341 | 1,216,300,341 |
| Бодит үнэ цэнийн нөөц | | 38,817,504 | 23,816,452 |
| Хуримтлагдсан алдагдал | | (499,142,725) | (437,321,401) |
| **Нийт өөрийн хөрөнгө** | | **755,975,120** | **802,795,392** |
| **Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө** | | **2,432,399,833** | **4,014,711,788** |

Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
Хуудас 1

***Монгол Улсын Хөгжлийн Банк***
***2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн***
***Нэгтгэсэн Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан***

| *Мянган төгрөгөөр* | **Тодруулга** | **2023 оны 12 дугаар сарын 31** | **2022 оны 12 дугаар сарын 31** |
|---|---|---|---|
| Хүүгийн орлого | 21 | 185,367,992 | 265,871,431 |
| Хүүгийн зардал | 22 | (215,094,365) | (194,123,355) |
| **Хүүгийн цэвэр орлого** | | **(29,726,373)** | **71,748,076** |
| Зээл, урьдчилгаа ба түрээсийн авлагад тооцсон үнэ цэнийн бууралтын буцаалт / (алдагдал) | 11 | 70,589,421 | 129,878,157 |
| **Зээл, урьдчилгаа ба түрээсийн авлагад тооцсон үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн дараах хүүгийн цэвэр орлого** | | **40,863,048** | **201,626,233** |
| Шимтгэл ба хураамжийн орлого | | 55,090 | 116,771 |
| Шимтгэл ба хураамжийн зардал | | (136,779) | (133,975) |
| Бусад орлого | 23 | 5,406,290 | 8,905,850 |
| Арилжааны цэвэр олз/ (гарз) | | 17,013,443 | (2,370,809) |
| Үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс олсон цэвэр (гарз)/ олз | 25 | (14,119,787) | 88,723,450 |
| Банкуудад байршуулсан хадгаламж, өмчлөх бусад хөрөнгө болон бусад хөрөнгөнд тооцсон үнэ цэнийн бууралтын алдагдал | 7, 11.1,12 | (170,522) | (5,042,421) |
| Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэглүүрийн эрсдэлийн сан | | (10,930,826) | (852,227) |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн (гарз)/ олз, цэвэр | 24 | (74,545,686) | (135,018,991) |
| Удирдлагын болон бусад үйл ажиллагааны зардал | 26 | (13,837,468) | (11,740,894) |
| **Татварын өмнөх тайлант жилийн (алдагдал)/ ашиг** | | **(50,403,197)** | **144,212,987** |
| Орлогын албан татварын (зардал)/ хөнгөлөлт | 27 | (945,204) | (33,930,601) |
| **Тайлант жилийн (алдагдал)/ ашиг** | | **(51,348,401)** | **110,282,386** |
| *Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдалд дахин ангилах боломжтой зүйлс:* | | | |
| Бодит үнэ цэнээр хэмжсэн борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлт, татварын дараах | 27 | 24,607,464 | 9,165,838 |
| Ашиг эсвэл алдагдал руу дахин ангилсан цэвэр дүн | 27 | (9,606,412) | (5,081,197) |
| **Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого/ (алдагдал)** | | **15,001,052** | **4,084,641** |
| **Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого /(алдагдал)** | | **(36,347,349)** | **(321,647,114)** |

Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

2

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
***2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн***
***Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан***

| *Мянган төгрөгөөр* | Тодруулга | Хувь нийлүүлсэн хөрөнгө | Бодит үнэ цэнийн нөөц | Хуримтлагд-сан алдагдал | Нийт өөрийн хөрөнгө |
|---|---|---|---|---|---|
| **2022 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл** | | **1,216,300,341** | **19,731,811** | **(547,603,787)** | **688,428,365** |
| **Нийт дэлгэрэнгүй орлого** | | | | | |
| Тайлант жилийн ашиг | | - | - | 110,282,386 | **110,282,386** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | | | | | |
| Бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт | | - | 9,165,838 | - | **9,165,838** |
| Ашиг эсвэл алдагдал руу дахин ангилсан цэвэр дүн | | - | (5,081,197) | - | **(5,081,197)** |
| **Нийт дэлгэрэнгүй орлого** | | **-** | **4,084,641** | **110,282,386** | **114,367,027** |
| **2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | | **1,216,300,341** | **23,816,452** | **(437,321,401)** | **802,795,392** |
| **Өмнөх жилийн залруулга** | | **-** | **-** | (10,472,923) | **(10,472,923)** |
| **2023 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл** | | **1,216,300,341** | **23,816,452** | **(447,794,324)** | **792,322,469** |
| **Нийт дэлгэрэнгүй орлого** | | | | | |
| Тайлант жилийн алдагдал | | - | - | (51,348,401) | **(51,348,401)** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого (алдагдал)** | | | | | |
| Бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт | | - | 24,607,464 | - | **24,607,464** |
| Ашиг эсвэл алдагдал руу дахин ангилсан цэвэр дүн | | - | (9,606,412) | - | **(9,606,412)** |
| **Нийт дэлгэрэнгүй орлого** | | **-** | **15,001,052** | **(51,348,401)** | **(36,347,349)** |
| **2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | | **1,216,300,341** | **38,817,504** | **(499,142,725)** | **755,975,120** |

Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

3

***Монгол Улсын Хөгжлийн Банк***
***2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн***
***Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан***

| *Мянган төгрөгөөр* | Тодруулга | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Татварын өмнөх тайлант жилийн ашиг / (алдагдал) | | **(50,403,197)** | **144,212,987** |
| *Тохируулгууд:* | | | |
| Элэгдэл ба хорогдлын зардал | 26 | 1,055,461 | 1,234,915 |
| Зээл, урьдчилгаа ба түрээсийн авлагад тооцсон үнэ цэнийн бууралтын (буцаалт)/ алдагдал | 11 | (70,589,421) | (129,878,157) |
| Банкуудад байршуулсан хадгаламж, өмчлөх бусад хөрөнгө болон бусад хөрөнгөнд тооцсон үнэ цэнийн бууралтын алдагдал | 7, 11.1, 12 | 170,522 | 5,042,421 |
| Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн сан | | 10,930,826 | 852,227 |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй гарз/ (олз) | 24 | 2,741,608 | 143,484,220 |
| Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн хэрэгжээгүй гарз | 25 | 64,305,566 | 118,134,423 |
| Үндсэн хөрөнгө борлуулсны гарз | | - | 88,250 |
| Хүүгийн орлого | 21 | (185,367,992) | (265,871,431) |
| Хүүгийн зардал | 22 | 215,094,365 | 194,123,355 |
| **Үйл ажиллагааны хөрөнгө болон өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | **(12,062,262)** | **211,423,210** |
| Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжийн цэвэр бууралт/ (өсөлт) | | (1,709,418) | 438,869,291 |
| Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаасны цэвэр өсөлт | | 115,879,540 | (63,205,725) |
| Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгийн цэвэр бууралт | | (3,309,532) | 8,633,892 |
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын цэвэр өсөлт | | 383,860,000 | (383,860,000) |
| Охин компани дахь хөрөнгө оруулалтын цэвэр бууралт | | 5,015,459 | - |
| Зээл, урьдчилгаа ба түрээсийн авлагын цэвэр бууралт | | 306,994,966 | 526,097,545 |
| Бусад хөрөнгийн цэвэр бууралт/ (өсөлт) | | 28,266,572 | 34,965,265 |
| Харилцагчдын харилцах дансны цэвэр бууралт | | 4,034,938 | (2,408,801) |
| Хадгаламжийн цэвэр өсөлт | | 34,523,700 | - |
| Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан хөрөнгийн бууралт | | 192,964,499 | (14,503,456) |
| Гэрээний өр төлбөрийн цэвэр өсөлт/ (бууралт) | | (24,418) | 728,541 |
| Бусад өр төлбөрийн цэвэр бууралт | | (4,275,470) | (1,891,227) |
| **Хүү болон татварын өмнөх үйл ажиллагаанаас орж ирсэн цэвэр мөнгөн гүйлгээ** | | **1,050,158,574** | **754,848,535** |
| Төлсөн орлогын албан татвар | | (10,851,398) | (12,138,431) |
| Хүлээн авсан хүү | | 236,626,860 | 223,374,356 |
| Төлсөн хүү | | (268,978,996) | (139,040,980) |
| **Үйл ажиллагаанаас орж ирсэн/ (зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ** | | **1,006,955,040** | **827,043,480** |

Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МЕНЕЖМЕНТ ГРУПП МОНГОЛИА АУДИТ ХХК
ХҮЛЭЭН

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн*
*Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан (Үргэлжлэл)*

| *Мянган төгрөгөөр* | Тодруулга | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтаас хүлээн авсан мөнгө | | 1,208,000 | - |
| Үндсэн хөрөнгийн худалдан авалт | 13 | (1,314,634) | (21,064) |
| Биет бус хөрөнгийн худалдан авалт | 13 | - | (1,559) |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(106,634)** | **(22,623)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Өрийн бичгээс орж ирсэн мөнгө | 18.1 | 455,359,860 | 76,530,500 |
| Бусдаас авсан зээлээс орж ирсэн мөнгө | 18.1 | 503,373,558 | 393,913,277 |
| Өрийн бичгийн эргэн төлөлт | 18.1 | (2,327,858,348) | (221,541,653) |
| Бусдаас авсан зээлийн эргэн төлөлт | 18.1 | (383,576,833) | (465,495,472) |
| **Санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(1,752,701,763)** | **(216,593,348)** |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө дэх гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үзүүлсэн нөлөө | | (6,231) | (33,511,470) |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/ (бууралт)** | | **(745,859,588)** | **576,916,039** |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 890,417,205 | 313,501,166 |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 6 | **144,557,617** | **890,417,205** |

Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК ХУУЛАС

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
***Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31***
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

**1. БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН**

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Монгол Улсын Хөгжлийн Банк (цаашид "Банк" гэх) болон түүний охин компаниудын (хамтад нь "Групп" гэх) санхүүгийн тайлангуудын мэдээллээс бүрдсэн. Банк нь Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 195 дугаар тогтоолын дагуу 2011 оны 3 дугаар сарын 25-ны өдөр байгуулагдсан бөгөөд үйл ажиллагаагаа 2011 оны 5 дугаар сард эхлүүлсэн. Банкийг Монгол Улсын Засгийн газар 100% эзэмшдэг.

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хэлэлцэн баталсан ба уг хууль нь 2017 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Монгол Улсын Хөгжлийн банкны шинэчлэгдсэн хууль нь байгууллагын засаглалыг сайжруулж, зээлийн үйл ажиллагааны хяналт болон бие даасан байдлыг нэмэгдүүлэх боломжийг олгосон. Банк нь Төв банкны тухай хууль болон арилжааны банкуудад хамаарах Монголбанкны журмуудаас илүүтэйгээр шинэчилсэн Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулиар зохицуулагддаг хэдий ч Монголбанк нь хөрөнгийн зохистой байдал болон хөрөнгийн хөрвөх чадварыг хянах үүрэгтэй байдаг. Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 4 хараат бус гишүүн болон Монгол Улсын Засгийн Газраас томилдог 5 гишүүдээс бүрддэг. Санхүүжүүлсэн төслүүдийн 60-аас доошгүй хувь нь Монгол Улсын уул уурхайн салбараас бусад нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлох чадварыг дээшлүүлэх болон экспортыг дэмжсэн хөтөлбөрүүдийг дэмжих ёстой байдаг.

Банкны үйл ажиллагааны хүрээг өргөжүүлж төрөлжүүлэх зорилгоор дараах охин компаниудыг үүсгэн байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн. Эдгээр охин компаниуд нь Банкны бүрэн эзэмшилд байдаг. Үүнд:

1. Ди Би Эм Лизинг ХХК нь 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдал, эдийн засгийн хөгжлийг дэмжих уул уурхай, хөдөө аж ахуй, эрчим хүч, дэд бүтэц болон эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж буй стратегийн төсөл хөтөлбөрүүдэд тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлдэг. 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Засгийн Газар Ди Би Эм Лизинг ХХК-ийг татан буулгаж, үйл ажиллагаа, хөрөнгө болон өр төлбөрийг түүний толгой байгууллага болох Банкинд шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Монгол Улсын Засгийн Газар 2021 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Ди Би Эм Лизинг ХХК-ийн үйл ажиллагааг буцаан сэргээх шийдвэр гаргасан. Тиймээс компани үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байна.
2. Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК нь эдийн засгийн өсөлтийг дэмждэг дунд болон том хэмжээний төслүүдэд урт хугацааны санхүүжилт олгох зорилгоор төрөл бүрийн хөрөнгө оруулалтын сангууд бий болгох төлөвлөгөөтэй компани юм. Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК ХХК нь 2018 онд хувийн хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний стратегийн хөрөнгө оруулалт хувийн ХОС ТЗК ХХК-ийг үүсгэн байгуулсан. 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Засгийн Газар Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК ХХК-ийг татан буулгаж, үйл ажиллагаа, хөрөнгө болон өр төлбөрийг түүний толгой байгууллага болох Банкинд шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК ХХК-ийн үйл ажиллагааг буцаан сэргээх шийдвэр гаргасан. Тиймээс компани үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байна.
3. 2021 оны 4 дүгээр сард Үндэсний стратегийн хөрөнгө оруулалт хувийн ХОС ТЗК ХХК-ийг татан буулгаж, хөрөнгө болон өр төлбөрийг түүний толгой байгууллага болох Банкинд шилжүүлэхээр шийдвэрлэсэн.
4. Үндэсний Экспортын Даатгал ХХК-д Банк 4.96 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын 2.2 дугаар заалтад Үндэсний Экспортын Даатгал ХХК-ийг татан буулгахыг үүрэг болгосон. 2023 оны 5 дугаар сард Үндэсний Экспортын Даатгал ХХК -ийг татан буулгаж, хөрөнгө болон өр төлбөрийг түүний толгой байгууллага болох Банкинд шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Группийн ажилчдын тоо 135 (2022 оны 12 дугаар сарын 31: 132) байна.

Группийн албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот 14210, Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа Хөгжлийн Банкны Барилга, 11 болон 12 давхар болно. Эдгээр хоёр давхарыг Банк эзэмшдэг.

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг Банкны Гүйцэтгэх удирдлага 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдөр батлан гаргасан.

**Банкны эх үүсвэрийн орчин**

Банкны үндсэн зорилтын хүрээнд эдийн засгийн тогтвортой хөгжилд ач холбогдол бүхий салбарын өсөлтийг дэмжих зорилгоор зээл, санхүүжилт олгохын тулд урт хугацаатай, хямд өртөг бүхий эх үүсвэрийн багцыг бүрдүүлэх, багцыг төрөлжүүлэх болон бие даан эх үүсвэр татан төвлөрүүлэх чадварыг сайжруулах зорилго тавин ажиллаж байна.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 6

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 1. БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Банкны эх үүсвэрийн орчин (үргэлжлэл)

Банкны зээлжих зэрэглэлийг Монгол Улсын зээлжих зэрэглэлтэй ижил Олон улсын зээлжих зэрэглэл тогтоох агентлагууд болох Стандарт энд Пүүрс 2023 оны 10 сарын 04-ний өдөр B "тогтвортой", Мүүдийз 2023 оны 10 сарын 24-ны өдөр B3 "тогтвортой", Фитч 2023 оны 07 сарын 07-ны өдөр B "тогтвортой" гэж тус тус үнэлсэн. Мөн Мүүдийз банкны зээлийн суурь үнэлгээг CAA2 түвшнээс CAA1 болгон нэмэгдүүлсэн. Зээлжих зэрэглэл тогтоох агентлагууд нь Банкийг Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий салбарууд, томоохон төслүүдийг санхүүжүүлэх үндсэн бодлогын үүрэг гүйцэтгэдэг байгууллага бөгөөд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулиудын дагуу шаардлагатай тохиолдолд Засгийн Газрын бүрэн дэмжлэгт хамрагдах засгийн газрын өмчит, бодлогод чиглэсэн хууль ёсны санхүүгийн байгууллага гэж үздэг.

## 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН СУУРЬ БА ТАЙЛАНГ БЭЛТГЭХ, ТОЛИЛУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

### Санхүүгийн тайлан бэлтгэсэн болон толилуулсан суурь

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д тулгуурлан Монголбанк (МБ)-наас баталсан заавар, журмын дагуу бэлтгэсэн.

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бодит үнэ цэнээр хэмжсэн зарим санхүүгийн хэрэглүүрүүдээс (үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд, борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт) бусад зүйлсийн хувьд түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн. Групп нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаа хөрвөх чадварын дараалалаар толилуулдаг. Санхүүгийн байдлын тайлангийн өдрөөс хойш 12 сар хүртэлх хугацаанд (эргэлтийн) болон 12 сараас дээш хугацаанд (эргэлтийн бус) эргэн төлөгдөх эсвэл эргэн төлөх талаарх шинжилгээг Тодруулга 28-аас харна уу.

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд хэрэгжүүлсэн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг доор харуулав. Өөрөөр заагаагүй тохиолдолд эдгээр бодлогуудыг энд толилуулсан бүх тайлант хугацааны туршид тууштай баримталсан.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд нягтлан бодох бүртгэлийн тодорхой чухал тооцооллыг шаарддаг. Мөн Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд удирдлагын үнэлэмж, шийдвэр шаардлагатай байдаг. Нарийн төвөгтэй тооцоолол, эсвэл таамаглал, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг нөлөө бүхий хэсгүүдийг Тодруулга 4-т оруулсан.

Ирээдүйн үйл ажиллагаанаас хамааран болзошгүй байх үндэслэлгүй хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед буюу дараах бүх тохиолдолд цэвэр дүнгээр төлж барагдуулах зорилго бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг. Үүнд:

- Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед;
- Төлбөрийн чадваргүй болсон үед;
- Групп болон/эсвэл түүний хамтрагч талууд төлбөрийн чадваргүй болсон эсвэл дампуурсан үед

Цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрсөн позицод гол төлөв валютын арилжаа, буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцлүүд, клирингийн тооцоо болон брокерын үлдэгдлүүд багтана. Цэвэр дүнгээр илэрхийлэх мастер хэлцэлтэй үүсмэл хөрөнгө болон өр төлбөрийг зөвхөн төлбөрийн чадваргүй болсон үед бус дээрх бүх шалгууруудыг хангасан нөхцөлд цэвэр дүнгээр толилуулдаг.

### Тасралтгүй үйл ажиллагаа

Группийн удирдлага нь тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадамжийг үнэлсэн бөгөөд ойрын ирээдүйд бизнесээ тасралтгүй үргэлжлүүлэх хэмжээний нөөцтэй гэж дүгнэсэн. Түүнчлэн удирдлага нь Группийн үйл ажиллагаар тасралтгүй үргэлжлүүлэхэд эргэлзээ төрүүлэхүйц аливаа материаллаг тодорхой бус байдлын талаар тодорхой болсон зүйл байхгүй гэж үзсэн. Тиймээс, нэгтгэсэн санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэсэн.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 7

**2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН СУУРЬ БА ТАЙЛАНГ БЭЛТГЭХ, ТОЛИЛУУЛАХ ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)**

**Үйл ажиллагааны болон толилуулгын валют**

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Группийн үйл ажиллагаагаа явуулдаг эдийн засгийн анхдагч орчны мөнгөн тэмдэгт буюу үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлсэн. Тайланд өөрөөр заагаагүй тохиолдолд бүх дүнг мянган төгрөгөөр илэрхийлсэн.

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт**

*Нягтлан бодох бүртгэлийн суурь*

Групп 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр нягтлан бодох бүртгэлийн суурийг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартаас Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-д тулгуурлан МБ-наас баталсан заавар журам болгон өөрчилсөн.

СТОУС-аас ялгаатай МБ-наас баталсан заавар журмын дагуу Банкинд томоохон нөлөө үзүүлж буй дараах зүйлс байсан. Дэлгэрэнгүйг холбогдох тодруулгуудад тайлбарласан болно.

- СТОУС 9-ийн дагуу хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын (зээлийн хүлээгдэж буй алдагдал) хэрэгжилтийн хойшлуулалт;
- Өмчлөх бусад хөрөнгө

**3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД**

**Нэгтгэлийн суурь**

Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Банк болон түүний хяналтад байдаг компаниуд болох охин компаниудын санхүүгийн тайлангуудаас бүрдэнэ. Хяналт байгаа эсэхийг дараах элементүүдээр хэмжинэ:

- Хөрөнгө оруулагчид үзүүлэх нөлөө,
- Хөрөнгө оруулагчийн эгөөжөөс хүртэх эрх,
- Хөрөнгө оруулагчийн өгөөжөөс хүртэх дүнд нөлөөлөх чадвар.

Банк хөрөнгө оруулагчид хяналт тогтоож байгаа эсэхийг дээрх гурван элементүүдийн нэг болон түүнээс олон хяналтад өөрчлөлт гарсан эсэхээр дахин үнэлдэг.

Шаардлагатай тохиолдолд охин компаниудын санхүүгийн тайлангуудад тохируулгуудыг хийж тэдний нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Группийн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад нийцүүлэн бэлтгэдэг.

Нэгтгэсэн тайлангуудыг бэлтгэх явцад Групп дотор хийгдсэн хөрөнгө ба өр төлбөр, эздийн өмч, орлого, зардал мөн мөнгөн гүйлгээтэй холбоотой бүх ажил гүйлгээнүүдийг устгадаг.

***Санхүүгийн хэрэглүүрүүд – үндсэн хэмжилтийн нөхцөлүүд.*** Санхүүгийн хэрэглүүрүүдийн ангиллаас шалтгаалан тэдгээрийг бодит үнэ цэнэ эсвэл хорогдуулсан өртгөөр доор тайлбарласны дагуу бүртгэлд тусгадаг.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ҮҮДАС 8

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

***Бодит үнэ цэнэ.*** Бодит үнэ цэнэ гэдэг нь зах зээлд оролцогч талуудын хооронд хөрөнгийг худалдсанаас хүлээн авсан эсвэл хэлцлийн дагуу өр төлбөрийн шилжүүлэг хийсэн өдрөөрх үнийг хэлнэ.

Бодит үнэ цэнийг илэрхийлэх хамгийн чухал нотолгоо бол идэвхтэй зах зээл дээрх үнэ юм. Идэвхтэй зах зээл гэдэг нь тодорхой давтамж, тоо хэмжээтэйгээр хөрөнгө, өр төлбөрийн хэлцэл тогтмол хийгдэн үнийн мэдээллийг тасралтгүй өгч байх зах зээл юм. Идэвхтэй зах зээлд арилжаалагддаг санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг хэмжихдээ тухайн хөрөнгө, өр төлбөрийн зах зээл дээр худалдаалагдах нэг бүрийн үнийг тухайн этгээдийн эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрүүдийн нийт тоо ширхгээр үржүүлж тооцно.

Хэрэв зах зээлийн өдөр тутмын арилжааны хэмжээ тухайн этгээдийн эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрүүдийн тоо хэмжээнээс бага болон тухайн эзэмшиж буй позицийг нэг хэлцлээр худалдах захиалга өгөх нь зах зээлийн үнэд нөлөөлөх байсан ч идэвхтэй зах зээлд арилжаалагдаж буй санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг тооцохдоо дээр дурдсан аргачлалыг ашиглана. Тухайн нөхцөлд бодит үнэ цэнийг хамгийн бодитоор илэрхийлэх үнэ нь худалдах, худалдан авах ханшийн зөрүүгээр илэрхийлэгдэх бөгөөд Банкны удирдлага тайлагналын өдрөөрх хаалтын ханшаар бодит үнэ цэнийг хэмжсэн. Санхүүгийн хөрөнгийг үнэлэхэд ашигласан зах зээлийн үнэ нь тухайн зах зээлийн худалдан авах дээд үнэ, харин санхүүгийн өр төлбөрийг үнэлэх зах зээлийн үнэ нь тухайн зах зээлийн худалдах доод үнэ байна.

Зах зээлийн үнийн талаар хөндлөнгийн мэдээлэлгүй зарим санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг дискаунтчилсан мөнгөн урсгалын загвар зэрэг үнэлгээний аргачлал эсвэл гуравдагч талуудын хоорондох хэлцэл дээр суурилсан загварууд эсвэл санхүүжигч талын санхүүгийн мэдээлэл дээр үндэслэн тооцно. Бодит үнэ цэнийн хэмжилтийг бодит үнэ цэнийн түвшнүүдийн дагуу дараах байдлаар шинжилнэ:

- **Түвшин 1 санхүүгийн хэрэглүүрүүд** – Эдгээр нь хэмжилтийн өдрөөр Группийн олж авсан, үнэлгээнд ашигласан өгөгдлүүд бөгөөд бирж дээр бүртгэлтэй ижил төсөөтэй хөрөнгө болон өр төлбөрийн залруулаагүй, идэвхтэй зах зээл дээрх үнэ юм. Групп нь хэмжээ болон төлбөрийн чадварын хувьд ижил төсөөтэй хөрөнгө болон өр төлбөрийн санхүүгийн тайлангийн өдрөөр боломжтой, заавал болон хэрэгжих үнийн хангалттай арилжааны үйл ажиллагаатай байхыг идэвхтэй зах зээл гэж үзнэ.
- **Түвшин 2 санхүүгийн хэрэглүүрүүд** - Үнэлгээнд ашигласан өгөгдлүүд нь, санхүүгийн хэрэглүүрийн амьдралын мөчлөгийн туршид боломжтой байх зах зээлийн бүх өгөгдлүүдээс шууд болон шууд бусаар үнэлгээнд ашигласан өгөгдлүүд юм. Эдгээр өгөгдлүүдийн дотор идэвхтэй зах зээл дээрх ижил төстэй хөрөнгө болон өр төлбөрийн үнэ, идэвхгүй зах зээл дээрх адил төстэй хэрэглүүрийн үнэ болон үнэнээс өөр хүүгийн түвшин, өгөөжийн муруй, хэргэлзах хэлбэлзэл болон зээлийн эрсдлийн үнэ гэх зэрэг ажиглагдахуйц өгөгдлүүд орно. Мөн түүнчлэн, тухайн хөрөнгийн нөхцөл байдал болон байршил мөн харьцуулах зүйлсийн аль нь үнэлэгдсэн хэрэгсэлтэй холбогдох зэргээс залруулга шаардлагатай байж болно. Гэвч ажиглагдахуйц бус өгөгдөл дээр үндэслэн нийт хэмжилтэд чухал ач холбогдолтой дээрх залруулгыг хийсэн бол Групп нь хэрэглүүрүүдийг Түвшин 3-р ангилна.
- **Түвшин 3 санхүүгийн хэрэглүүрүүд** - Үүнд, хэмжилтийн бүхэлд нь чухал ач холбогдолтой, нэг болон түүнээс дээш ажиглагдахуйц бус өгөгдлүүд багтана.

Бодит үнэ цэнийн хэмжүүрүүдийн түвшин хоорондын шилжилт нь тайлант хугацааны эцэс бүрт хийгдэнэ.

***Гүйлгээний зардлууд.*** Гүйлгээний зардлууд нь санхүүгийн хэрэглүүрүүдийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь хэлцэл хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх зардал юм. Гүйлгээний зардалд агент (борлуулагч агентийн үүрэг гүйцэтгэж буй ажиллагсад үүнд хамаарна), зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж, шимтгэл, зохицуулагч байгууллага болон хөрөнгийн биржид төлөх төлбөрүүд, мөн татвар ба бусад төлбөрийн үүргийн шилжүүлгүүд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт буюу нэмэгдэл санхүүжилтийн зардлууд, дотоод удирдлагын буюу хадгалалтын зардлууд орохгүй.

***Хорогдуулсан өртөг.*** Хорогдуулсан өртөг нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс үндсэн төлбөрийн аливаа эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж гарсан дүнг хэлэх бол санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүнд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон гүйлгээний зардлын хорогдуулалт ба эргэн төлөх хугацаанд төлөх үндсэн төлбөрийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон урамшуулал болон хямдруулалт багтана. Хуримтлагдсан хүү болон хорогдуулсан урамшуулал эсвэл хямдруулалт (хэрвээ хэлцэл үүсэх үед бий болсон хойшлогдсон хураамж, шимтгэл байдаг бол)-ыг багтаасан хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардлыг тусад нь бүртгэхгүй бөгөөд тэдгээрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн холбогдох хэсэгт бүртгэлийн үнээр тусгана.

КЕКСНА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 9

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

***Үр ашигт хүүгийн арга.*** Хүүгийн орлого болон зардлыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Үр ашигт хүүгийн түвшин нь санхүүгийн хэрэглүүрийн дуусах хугацаа хүртэл ирээдүйн мөнгөн орлого болон төлбөрийн дискаунтын хувь хэмжээ:

- Санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ; эсвэл
- Санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийн дүн.

Худалдаж авсан эсвэл анх үүссэн эрсдэлийн үнэ цэнийн бууралттай хөрөнгөөс бусад санхүүгийн хэрэглүүрт үр ашигт хүүгийн аргыг тооцохдоо Банк нь санхүүгийн хөрөнгийн гэрээний бүх нөхцөлийг харгалзан ирээдүйн мөнгөн урсгалыг тооцоолдог боловч хүлээгдэж буй болзошгүй эрсдэлийн зардлыг тооцдоггүй. Худалдаж авсан эсвэл анх үүссэн эрсдэлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд эрсдэлээр тохируулсан үр ашигт хүүгийн түвшинг хүлээгдэж буй зээлийн эрсдэлийн зардлыг багтаасан ирээдүйн мөнгөн урсгалыг тооцооллыг ашиглан тодорхойлдог.

Үр ашигт хүүгийн тооцоолол нь гүйлгээний өртөг, шимтгэл болон төлбөр болон орлогыг багтаана. Гүйлгээний өртөг нь санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг худалдан авах болон зарцуулахад хамааралгдах өсөн нэмэгдүүлэх өртгийг шингээнэ.

***Санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрөх.*** Арилжааны үнэт цаас, үүсмэл санхүүгийн хэрэглүүр болон ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн бусад санхүүгийн хэрэглүүрүүдийг анх бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Бусад бүх санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнэ дээр хэлцлийн зардлыг нэмсэн дүнгээр анх бүртгэдэг. Анх бүртгэх бодит үнэ цэнийн хувьд хэлцэл хийгдсэн үнэ хамгийн баталгаатай үнэ болно. Хэрвээ бодит үнэ цэнэ ба хэлцлийн үнийн хооронд зөрүү нь ижил төрлийн хэрэглүүрийн зах зээл дээрх ажиглаж болохуйц бусад хэлцэл эсвэл ажиглаж болохуйц зах зээлийн мэдээллийн өгөгдлүүдийг багтаасан үнэлгээний аргачлалын дагуу тооцооллоор нотлогдсон тохиолдолд зөвхөн анх бүртгэх үеийн олз эсвэл гарзыг бүртгэдэг. Бүх худалдан авалт болон санхүүгийн хөрөнгийн борлуулалтыг хэлцлийн өдөр бүртгэнэ. Тухайлбал, Банк санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон тохиолдолд хүлээн зөвшөөрнө.

***Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх.*** Групп нь санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө: хөрөнгийн төлбөр хийгдсэн эсвэл хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ Групп бусдад шилжүүлсэн эсвэл хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг үндсэндээ нь шилжүүлсэн, хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг шилжүүлээгүй ба хадгалаагүй боловч хяналт тавих эрхээ хадгалж үлдээгүй. Хэрэв Групп нь гагцхүү шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийг өмчлөх бүх эрсдэл, өгөөжийг хадгалж үлдэх юм бол Групп санхүүгийн хөрөнгийг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрч, хүлээн авсан орлогоор барьцаат зээлийг мөн хүлээн зөвшөөрнө.

***Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.*** Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд түргэн хөрвөх боломжтой, үнэ цэнээ алдах эрсдэл багатай хэрэгслүүд хамаарна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд засгийн газрын хөрөнгө оруулалт, Монголбанкны гурван сараас доош хугацаанд дуусгавар болох хөрөнгө оруулалтын үнэт цаасыг хамруулсан болно. 3 сараас дээш хугацаатай ашиглалтад нь хязгаарлалт хийсэн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд оруулахгүй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

***Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж.*** Мөнгөн хадгаламжийг Групп бусад банкуудад арилжааны бус зорилгоор 3 сараас дээш хугацаатай мөнгө шилжүүлснээр зах зээлд бүртгэлгүй санхүүгийн үүсмэл бус хэрэглүүрүүд ба тодорхой эсвэл тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх авлага үүсэх үед бүртгэдэг. Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

***Дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаасаарх хөрөнгө оруулалт.*** Группийн дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших зорилготой тогтмол эсвэл ирээдүйд тодорхой болох төлбөрийн дүнтэй, тогтмол дуусах хугацаатай үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаасаарх хөрөнгө оруулалт гэж үзнэ. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үеүдэд үр ашигт хүүгийн аргыг ашиглан санхүүгийн хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртгөөр бүртгэж, үнэ цэнийн бууралтыг хасаж тооцно. Хэрэв Групп нь бага хэмжээний гэж үзсэнээс өндөр дүнтэй дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг дуусгавар хугацаанаас өмнө зарах эсвэл дахин ангилсан тохиолдолд (тодорхой заасан нөхцөл байдлуудаас бусад тохиолдолд) уг ангиллыг бүхлээр нь хүчингүй болгох бөгөөд уг ангилалд байсан хөрөнгө оруулалтуудыг борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтаар дахин ангилна. Цаашлаад Группийг дараагийн 2 жилд санхүүгийн хөрөнгөө дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаасаарх хөрөнгө оруулалт гэсэн ангилалд ангилахыг хориглоно.

НЕКСИА ГРОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 10

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

### 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

***Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө.*** Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө гэж дараах нөхцөлүүдийн аль нэгийг хангасан санхүүгийн хөрөнгийг хэлнэ.

а. Арилжаалах зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан. Хэрэв санхүүгийн хөрөнгө дараах нөхцөлүүдийг хангасан бол арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө гэж ангилна:

- Ойрын хугацаанд борлуулах эсвэл буцаан худалдаж авах зорилгоор худалдан авсан эсвэл уг үндсэн дээр үүссэн;
- Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хамтад нь удирдахаар тодорхойлсон санхүүгийн хэрэглүүрүүдийн багцын нэг хэсэг байсан ба богино хугацаанд өгөөж хүртэх боломжтой нь ойрын хугацаанд нотлогдсон; эсвэл
- Энэ нь дериватив (санхүүгийн баталгааны гэрээ эсвэл зориулалтын ба үр дүнтэй хейджийн хэрэгсэл болох деривативаас бусад).

б. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа Групп нь уг хөрөнгийг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө гэж тодорхойлсон.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгийг анх бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгийн хувьд шууд хамаарах ажил гүйлгээний өртгийг үүссэн үед нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед арилжаалах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө зэрэг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн бүх санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Арилжааны хэрэглүүрүүд болон бусад ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч, шууд өмчид тусгана.

***Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт.*** Энэ ангилалд борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтаар хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгүүд эсвэл дараах ангилалд багтаагүй санхүүгийн хөрөнгүүд орно. Эдгээр нь (а) зээл ба урьдчилгаа, (б) дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтууд эсвэл (в) ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрдөг санхүүгийн хөрөнгүүд байна.

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр бүртгэнэ. Групп төлбөр хүлээн авах эрх үүссэн болон ногдол ашиг цуглуулах боломж бий болсон тайлант хугацаанд борлуулахад бэлэн өмчийн хэрэгсэлд ногдол ашиг хүлээн зөвшөөрч ашиг алдагдалд ангилна. Хөрөнгө оруулалтыг дахин хүлээн зөвшөөрөгдөх эсвэл үнэ цэнийн бууралтад орох хүртэлх бодит үнэ цэнийн өөрчлөлтүүд нь бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөгдөх ба дахин хүлээн зөвшөөрөгдсөн эсвэл үнэ цэнийн бууралтад орсон нөхцөлд бусад дэлгэрэнгүй орлогоос тайлант үеийн ашиг, алдагдлаар дахин ангилна. Борлуулахад бэлэн үнэт цаасны анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үеүдэд нэг болон хэд хэдэн үйл явдлын (алдагдал үүсэх үйл явдлууд) үр дүнд үүссэн бүх үнэ цэнийн бууралтыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг. Томоохон хэмжээний эсвэл удаан хугацааны бодит үнэ цэнийн бууралт нь үнэт цаас үнэ цэнийн бууралтад орсныг илэрхийлдэг. Тайлант хугацаанд ногдох нийт үнэ цэнийн алдагдал нь тус хөрөнгийн хувьд худалдан авалтын өртөг болон бодит үнэ цэнийн зөрүүнээс өмнөх тайланд хугацаанд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын ашиг, алдагдлаа хассан дүнгээр тооцогддог ба нэгтгэсэн ашиг алдагдал болон бусад орлогын дэлгэрэнгүй тайланд ашиг алдагдлаар тусгана.

Өмчийн хэрэгслүүдийн үнэ цэнийн бууралтыг буцаахгүй ба дараа үеийн олзыг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө. Хэрэв, тайлангийн дараа үеүдэд борлуулахад бэлэн хэмээн ангилагдсан өрийн хэрэгслийн бодит үнэ цэнэ нь ихсэх, мөн тухайн өсөлт нь үнэ цэнийн бууралтын дараа тохиолдсон үйл явдалтай холбогдож байвал ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх ба тухайн тайлант хугацааны ашиг, алдагдалд үнэ цэнийн бууралтыг буцааж бүртгэнэ.

***Үүсмэл санхүүгийн хэрэглүүр.*** Групп нь өдөр тутмын санхүүгийн үйл ажиллагааны явцад төрөл бүрийн үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэлэлцээрт оролцдог. Группийн үндсэн үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэлэлцээрүүд нь хүүгийн түвшний своп, гадаад валютын своп хэлцэл болон гадаад валютын ханшийн өөрчлөлтийн форвард хэлцэл байна. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдэд валют солилцооны своп болон форвард арилжаа багтах бөгөөд бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнэ нь эерэг үед үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг хөрөнгөөр бүртгэх бөгөөд сөрөг үед өр төлбөрөөр бүртгэнэ. Бодит үнэ цэнэд гарах өөрчлөлтийг тайлант үеийн ашиг, алдагдлаар (үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс хүлээсэн ашиг, алдагдал) хүлээн зөвшөөрдөг. Групп нь хейджийн бүртгэл хөтөлдөггүй.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 11

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

***Үүсмэл санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл).***

Бусад санхүүгийн хэрэгслүүдэд агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг тусдаа үүсмэл хэрэглүүр гэж авч үзэх ёстой ба хэрэв тэдгээр нь үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтын шалгуурыг хангасан бол (дээр дурдсанчлан) бодит үнэ цэнээр нь хэмждэг. Тэдгээрийн эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдэлүүд нь агуулагч гэрээний эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдэлүүдтэй нягт холбоотой биш, мөн агуулагч гэрээг худалдах зорилгоор эзэмшээгүй ба анх хүлээн зөвшөөрөхдөө ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилаагүй бөгөөд тэдгээр нь үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн тодорхойлолт (дээр тодорхойлсон)-нд нийцэж байвал бодит үнэ цэнээр нь бүртгэдэг. Агуулагч гэрээнээс нь салгасан үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийг арилжааны багц дахь бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр нь бүртгэх ба уг өөрчлөлтийг нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

***Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа.*** Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа нь Групп харилцагчдаасаа биржид арилжаалдаггүй санхүүгийн үүсмэл бус хэрэглүүрүүд бөгөөд тодорхой эсвэл тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх авлагыг харилцагчаас худалдан авах буюу үүсгэхээр мөнгө шилжүүлсэн тохиолдолд бүртгэх ба уг авлагыг арилжих зорилгогүй байна. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын санг хассан дүнгээр хэмжинэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцно. Монголбанкнаас баталсан заавар журмын дагуу нийт зээлийн үлдэгдэлтэй харьцуулахад 5 болон түүнээс бага хувийн үнэ цэнийн бууралт үүссэн зээлүүдийг хэвийн зээл гэж тодорхойлдог.

***Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт.*** Санхүүгийн хөрөнгийг анх бүртгэснээс хойш тохиосон санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн бүлэг хөрөнгөөс ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын хэмжээ болон цаг хугацаанд нөлөөлөх нэг буюу олон үйл явдал ("гарз учруулсан үйл явдлууд")-ын үр дүнд үүссэн үнэ цэнийн алдагдлыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Үнэ цэнийн бууралт үүссэн талаарх бодитой нотолгоо байгаа эсэхийг тодорхойлоход дараах нэмэлт шалгууруудыг авч үзнэ:

- Хуваарьт төлбөрүүдийн аль нэг нь хугацаа хэтэрсэн бөгөөд хугацаа хэтрэлт нь төлбөр тооцооны системээс үүссэн сааталтай хамааралгүй;
- Группийн олж авсан санхүүгийн мэдээллээр зээлдэгч санхүүгийн хүндрэлд орсон нь нотлогдсон;
- Зээлдэгч дампуурлаа зарлах буюу санхүүгийн бүтцийн өөрчлөлт хийхээр төлөвлөж байгаа;
- Улсын буюу орон нутгийн эдийн засгийн нөхцөл, байдлын өөрчлөлт зээлдэгчид нөлөөлсний үр дүнд түүний төлбөр төлөлтийн байдалд сөрөг өөрчлөлт гарсан;
- Зах зээлийн нөхцөл байдал муудсанаас барьцаа хөрөнгийн үнэ цэнэ мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан.

Групп нь хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгөө дангаараа их хэмжээний үнэ цэнийн бууралтад орсон эсэх, эсвэл дангаараа их хэмжээний үнэ цэнийн бууралтад ороогүй хөрөнгүүдийн хувьд багцаараа үнэ цэнийн бууралтад орсон эсэхийг үнэлдэг. Хэрэв Групп нь тухайн санхүүгийн хөрөнгөнд үнэ цэнийн бууралтад орох аливаа үйл явдал тохиолдоогүй гэж үзвэл төстэй зээлийн эрсдэлтэй хөрөнгүүдийг багцад нэгтгэн үнэ цэнийн бууралтыг тооцоолдог. Дангаараа үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгүүд нь багцын үнэ цэнийн бууралтад орохгүй.

Багцаар нь үнэ цэнийн бууралтыг тооцохдоо санхүүгийн хөрөнгүүдийг эрсдэлийн ойролцоо түвшинээр нь ангилах бөгөөд уг ангиллыг бий болгохдоо хөрөнгийн төрөл, үйл ажиллагаа явуулж буй салбар, газарзүйн байршил, барьцаа хөрөнгийн төрөл, зээлийн эргэн төлөгдөх хугацааны хэтрэлт болон бусад хүчин зүйлсийг авч үзнэ. Эрсдэлийн бүлэг тус бүр дээр түүхэн дундаж алдагдлыг харгалзах зээлийн үлдэгдэлд нь хуваах үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцох аргачлалыг сонгосон.

Өнөө үед үгүй болсон түүхэн нөхцөл байдлын нөлөөг арилгах, түүхэн алдагдлын суурилж буй жилүүдэд хамааралгүй өнөөгийн нөхцөл байдлын нөлөөг харуулах үүднээс түүхэн алдагдлын мэдээнд өнөө үед ажиглагдахуйц өгөгдлүүдэд үндэслэн тохируулга хийдэг. Үнэ цэнийн алдагдлыг үргэлж нөөцийн сангийн дансанд хүлээн зөвшөөрөх ба хөрөнгийн бүртгэлийн үнийг өнөөгийн үнэ цэнэ рүү бууруулахдаа хүлээгдэж буй мөнгөн урсгал (зээлийн хэрэгжээгүй ирээдүйн алдагдлыг үүнд оруулахгүй)-ыг анхны бодит хүүгээр хямдруулан тооцно. Барьцаат хөрөнгөөр баталгаажсан санхүүгийн хөрөнгийн ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын өнөөгийн өртгийг тооцохдоо эргэн төлөлтийг хугацаанаас нь өмнө төлөх магадлалтай эсэхээс үл хамааран хугацаанаас нь өмнө эргэн төлөх мөнгөн урсгал болон барьцаа хөрөнгийг олж авах болон худалдах зардлын зөрүү дээр үндэслэн тооцно. Үнэ цэнийн бууралтад орж болох зээл ба урьдчилгаанд тогтмол хяналт тавьж, тэдгээрийг ангилсны дагуу сан байгуулах замаар нөхөгдөх өртөг хүртэл нь бууруулна.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
БУУДАС

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

***Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл).***

Хэрэв үнэ цэнийн алдагдал дараах үеүдэд буурсан бөгөөд уг бууралт нь үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш тохиосон бодит үйл явдал (зээлдэгчийн төлбөрийн чадвар сайжирсан)-тай холбоотой бол өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн алдагдлыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд тооцон эрсдэлийн сангийн дансанд залруулан бичих замаар бүртгэнэ. Эргэн төлөгдөх боломжгүй болсон хөрөнгийг данснаас хасахдаа хөрөнгийг нөхөн төлүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч дууссан байх бөгөөд алдагдлын хэмжээ тодорхой болсон үед холбогдох үнэ цэнийн бууралтын нөөц данснаас хасна. Өмнө нь данснаас хассан хөрөнгө дараа нь нөхөн төлөгдсөн тохиолдолд нөхөн төлөгдсөн дүнг тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд тооцон үнэ цэнийн алдагдлын сангийн дансыг бууруулна.

***Санхүүгийн хэрэглүүрүүдийг хооронд нь хаах.*** Зөвхөн хүлээн зөвшөөрсөн дүнг хооронд нь хаах хууль ёсны эрх үүссэн, цэвэр дүнгээр төлбөр хийх эсвэл хөрөнгийг бодитой хэрэгжсэн гэж үзэн өр төлбөрийг шууд барагдуулах зорилготой бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хааж нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тайлагнана.

***Урьдчилж төлсөн төлбөрүүд.*** Урьдчилж төлсөн төлбөр нь урьдчилж бэлэн мөнгө төлсөн боловч бодитоор гараагүй байгаа зардлуудыг хэлнэ. Урьдчилж төлсөн төлбөрүүд нь эхлээд хөрөнгө хэсэгт бүртгэгдэх ба төлсөн бэлэн мөнгөний дүнгээр хэмжигдэнэ. Үүний дараа үйл ажиллагаанд хэрэглэсэн буюу хугацаа нь дуусахад ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

***Үндсэн хөрөнгө.*** Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Тайлант хугацаа бүрийн эцэст үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хорогдол болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тусгадаг. Хөрөнгийг олж эзэмшихтэй холбоотой гарсан зардлыг өртөгт шингээнэ.

Хөрөнгийн өртгийг дор хүлээгдэж буй ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргаар элэгдүүлнэ:

| | |
|---|---|
| - Барилга, байгууламж | 40 жил |
| - Тоног төхөөрөмж | 3 жил |
| - Тавилга, эд хогшил | 10 жил |
| - Тээврийн хэрэгсэл | 10 жил |

***Үндсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх.*** Үндсэн хөрөнгийг зарж борлуулсан эсвэл ирээдүйд тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашиглахад эдийн засгийн өгөөж хүртэхгүй гэж үзсэн тохиолдолд үл хүлээн зөвшөөрдөг. Үндсэн хөрөнгийг данснаас хассан эсвэл борлуулснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн дансны үнэ ба борлуулалтын үнийн зөрүүгээр тооцож, ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдүүлэх аргыг тайлант хугацаа бүрийн эцэст хянаж үздэг ба шаардлагатай үед залруулж тохируулдаг.

***Биет бус хөрөнгө.*** Группийн худалдан авсан ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Тайлант хугацаа бүрийн эцэст анхны өртгөөс хуримтлуулсан хорогдуулалт ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр биет бус хөрөнгийг хэмждэг. Биет бус хөрөнгийн өртөгт худалдан авалтын үнэ, гаалийн татвар хураамж, бусад нөхөн олгогдохгүй татвараас худалдааны хөнгөлөлт, хямдралыг хассан цэвэр дүн ба биет бус хөрөнгийг зориулалтаар нь ашиглах бэлтгэлийг хангахтай холбоотой шууд гарах аливаа зардлаас бүрддэг.

Хэрвээ дараагийн зардлууд нь тухайн хөрөнгийн ирээдүйн өгөөжийг нэмэгдүүлэхээр бол анхны өртөг дээр нэмж капиталжуулна. Бусад бүх зардлуудыг гарсан үед нь ашиг алдагдлаар тусгана.

Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгийг хорогдуулахдаа хөрөнгийн өртөг эсвэл өртгийг орлох дүнгээс үлдэх өртгийг хассан дүнгээр тооцно. Биет бус хөрөнгийг ашиглаж эхэлсэн өдрөөс эхлэн нийт хүлээгдэж буй ашиглах жилд үндэслэн шулуун шугамын аргаар хорогдуулах ба хорогдуулгын зардлыг тухайн тайлант хугацаан дахь ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Энэ нь уг хөрөнгийн ирээдүйд авчрах өгөөжийг зарцуулах төлөв байдлыг хамгийн дөхөмтэй байдлаар тусгана. Биет бус хөрөнгийг ашиглах жил дараах байдалтай байна:

| | |
|---|---|
| - Программ хангамж болон лиценз | 10 жил |

***Биет бус хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх.*** Биет бус хөрөнгийг зарж борлуулах эсвэл ирээдүйд орж ирэх эдийн засгийн өгөөж нь байхгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Бүртгэлээс хасахтай холбоотой гарах олз, гарзыг тодорхойлохдоо бүртгэлээс хассан эсвэл борлуулснаас орж ирэх мөнгө болон хөрөнгийн дансны үнийн зөрүүгээр тооцох ба түүнийг тайлант үеийн нэгтгэсэн ашиг, алдагдалд тусгана.

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

***Биет болон биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт.*** Удирдлага тайлант хугацаа бүрийн эцэст үл хөдлөх хөрөнгө, биет ба биет бус хөрөнгөнд үнэ цэнийн бууралт үүссэн шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлнэ. Хэрвээ үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрвэл, удирдлага тухайн хөрөнгийн нөхөн төлөгдөх боломжит хэмжээг тогтоох ба ингэхдээ тухайн хөрөнгийн бодит үнэ цэнээс худалдан борлуулахтай холбоотой зардлыг хассан дүн болон ашиглалтын үнэ цэнийн аль ихээр тооцдог. Дансны үнийг нөхөн төлөгдөх дүн хүртэл бууруулах ба үнэ цэнэ бууралтын зардлыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд тусгана. Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс худалдах зардлыг хассан дүнг тодорхойлоход ашигласан тооцоололд өөрчлөлт орсон тохиолдолд, өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн байсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардлыг буцаана.

***Харилцагчдын харилцах данс.*** Харилцагчдын харилцах данс нь улсын, байгууллагын болон хувь хүмүүсийн үүсмэл бус өр төлбөр бөгөөд хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Эдгээр дансуудыг харилцагчийн төлбөр тооцоог хийхэд ашигладаг бөгөөд хүү боддоггүй.

***Худалдах болон буцаан худалдан авах хэлцлүүд.*** Худалдах болон буцаан худалдан авах хэлцэл ("репо хэлцэл") нь зээлдэгчийн эргэн төлөлтийг үр дүнтэйгээр хангах бөгөөд ийм хэлцлүүдийг баталгаа бүхий санхүүгийн гүйлгээ гэж үздэг. Репо хэлцлээр худалдсан үнэт цаасыг бүртгэлээс хасдаггүй. Үнэт цаасны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан дахь ангиллыг ерөнхийдөө өөрчилдөггүй боловч үнэт цаасаа шилжүүлж буй тал гэрээний дагуу эсвэл тогтсон хэвшлийн дагуу үнэт цаасыг зарах эсвэл барьцаанд өгөх эрхтэй тохиолдолд үнэт цаасыг буцаан худалдан авах авлага гэж ангилна. Холбогдох өглөгийг банкуудаас байршуулсан хөрөнгө эсвэл бусдаас авсан зээл гэж тайлагнадаг. Худалдан авсан ба буцаан худалдах үнийн зөрүүг хүүгийн зардал гэж бүртгэх ба үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

Эсрэгээрээ, тодорхойлсон ирээдүйн өдөр дахин худалдахаар тохиролцон худалдан авсан үнэт цаасыг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Ажил гүйлгээний эдийн засгийн мөн чанар нь Банкнаас олгосон зээлийн гүйлгээтэй ижил тул төлсөн төлбөрийг хуримтлагдсан хүүгийн хамтаар санхүүгийн байдлын тайланд "Урвуу буцаан худалдан авах хэлцэл"-ээр бүртгэнэ. Худалдан авсан ба дахин худалдах үнийн зөрүүг 'хүүгийн орлого' гэж бүртгэх ба үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны туршид хуримтлуулна.

***Өрийн бичиг болон бусдаас авсан зээл.*** Группээс гаргасан өрийн бичиг, бусдаас авсан зээл зэрэг өрийн үнэт цааснуудыг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Зээлээр авсан эх үүсвэрийн хорогдуулсан өртгийг тооцохдоо үр ашигт хүүгийн арыг ашиглан гүйлгээтэй холбоотой гарсан аливаа зардлуудыг тооцно. Хэрэв Групп өөрийн гаргасан өрийн бичгийг эргүүлэн худалдаж авбал эсвэл бусдаас авсан зээлээрээ төлбөл тэдгээрийг санхүүгийн тайлангаас хасаж, төлсөн дүн болон өр төлбөрийн дансны үнэ хоёрын зөрүүгээр өрийн хэрэгслийг данснаас хасахад үүссэн олз эсвэл гарзаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

***Өмчлөх бусад хөрөнгө.*** Өмчлөх бусад хөрөнгийг анхлан тэдгээрийн бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн ба холбогдох зээлийн буцаан авалт хийгдсэн өдрөөрх үлдэгдэл дүнгийн аль багаар нь хүлээн зөвшөөрөх ба холбогдох зээл ба урьдчилгааг үнэ цэнийн бууралтын сангийнх нь хамт тайлан тэнцэлд үл хүлээн зөвшөөрнө. Өмчлөх бусад хөрөнгийг борлуулахад бэлэн болгох зорилгоор гарсан зардлуудыг тухайн хөрөнгийн өртөгт оруулан тооцно. Дараагийн тайлант хугацаанд өмчлөх бусад хөрөнгийг өртөг ба бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн хоёрын аль багаар нь хэмжинэ.

***Хувь нийлүүлсэн хөрөнгө.*** Хувь нийлүүлсэн хөрөнгө нь банкны өмчлөгчөөс мөнгөн хөрөнгө оруулах, хуримтлагдсан ашгийг капиталжуулах эсвэл өмчлөгчийн бусад хэлбэрээр оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлдэг.

***Орлогын албан татвар.*** Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст батлагдсан хууль тогтоомжийн дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө. Орлогын албан татварын зардал нь тухайн тайлант үеийн болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл өмчид шууд бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн тайлант үеийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрнө.Тайлант хугацааны татвар нь тухайн болон өмнөх хугацаанд үүссэн татвар ногдуулах ашиг, алдагдалтай холбоотой татварын байгууллагад төлөх эсвэл түүнээс нөхөн авах дүн болно. Санхүүгийн тайланг холбогдох татварын албанд тушаахаас өмнө батлаж амжаагүй тохиолдолд татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилан тооцно. Орлогын албан татвараас бусад татваруудыг үйл ажиллагааны зардалд бүртгэдэг.

***Хойшлогдсон орлогын албан татвар.*** Хойшлогдсон орлогын татварыг Балансын өглөгийн аргыг ашиглан дараагийн тайлант үед шилжүүлсэн татварын алдагдал, хөрөнгө өр төлбөрийн татварын суурь болон санхүүгийн тайлангийн зорилгоорх бүртгэлийн суурийн зөрүүнд үндэслэн хүлээн зөвшөөрнө. Бизнесийн нэгдлээс бусад тохиолдолд, хэрэв ажил гүйлгээг анхны удаа хүлээн зөвшөөрөх үед татвар эсвэл бүртгэлийн ашиг алдагдлын алинд ч нөлөөлөхгүй байвал хөрөнгө, өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон татвар үүсэхгүй. Хойшлогдсон татварын үлдэгдлийг ирээдүйд түр зөрүүг буцаах эсвэл шилжүүлсэн татварын алдагдлыг ашиглах үед хэрэглэгдэх балансын өдрөөр хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувиар тооцоолж гаргана.

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

***Хойшлогдсон орлогын албан татвар (үргэлжлэл).***

Хасагдах түр зөрүү болон ирээдүйд шилжүүлсэн татварын алдагдлаас үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийг хасагдах түр зөрүүг ашиглах хангалттай хэмжээний ашиг олох магадлал өндөр байгаа тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна.

Борлуулахад бэлэн хөрөнгийн бодит үнэ цэнийн дахин хэмжилттэй холбоотой бусад дэлгэрэнгүй орлогод тусгагдсан татвараас бусад хойшлогдсон татвар ба орлогын албан татвар нь орлогын тайланд орлогын албан татварын буцаан авалт эсвэл зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө. Энэ нь дараагийн тайлант үед бусад дэлгэрэнгүй орлогоос орлогын тайлан руу холбогдох хойшлуулсан ашиг алдагдлын хамт дахин ангилна. Мөн Банк нь өөрийн хөрөнгө гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрүүдтэй холбоотой зардал, төлбөрийн татварын үр дагаврыг өөрийн хөрөнгөөр шууд хүлээн зөвшөөрнө.

**Нөөцийн Сан, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө**

***Нөөцийн сан.*** Групп өнгөрсөнд болсон үйл явдлаас үүссэн хуулийн хариуцлага хүлээх үед Групп эдийн засгийн хувьд үр өгөөжтэй байдлаар шаардлагыг биелүүлэх бөгөөд энэ үед нөөцийн санг хүлээн зөвшөөрч дүнг бодитоор тооцоолно. Хүлээн зөвшөөрсөн нөөцийн сангийн хэмжээ, дүнг тухайн үүрэгтэй холбоотой бүх эрсдэл ба тодорхойгүй байдлыг харгалзаж бий болсон үүргийн гүйцэтгэлийг тайлант хугацааны эцэст хангуулахаар төсөөлж тооцоолно. Нөөцийн санг хэмжихдээ одоо бий болсон үүргийг хангуулахаар төсөөлсөн бэлэн мөнгөний урсгалыг ашиглах ба түүний бүртгэлийн үнэ нь энэхүү бэлэн мөнгөний урсгалын өнөөгийн үнэ байна.

Нөөцийн санг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн өгөөжийг бүгдийг нь эсвэл заримыг нь гуравдагч тал нөхөн төлөх магадлалтай ба хэрэв нөхөн төлөх нь тодорхой болсон бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг найдвартай хэмжих боломжтой үед уг авлагыг хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө.

Нөөцийн санг тайлант хугацаа бүрийн эцэст хянах ба ингэхдээ хамгийн сайн төсөөллийг тусгаж залруулдаг. Эдийн засгийн өгөөжийг шилжүүлж өр төлбөрийг барагдуулах шаардлагагүй болсон үед нөөцийн санг буцаана.

***Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө.*** Аж ахуйн нэгжийн бүрэн хяналтаас гадуурх нэг болон түүнээс дээш ирээдүйн үйл явдал тохиолдох, эс тохиолдохоос хамаарч үүсэх эсэх нь тодорхойлогддог тул болзошгүй өр ба болзошгүй хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэхгүй. Эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгалыг гадагшлуулах магадлал өндөр бол болзошгүй өр төлбөрийн мэдээллийг толилуулна. Эдийн засгийн өгөөж орж ирэх өндөр магадлалтай үед болзошгүй хөрөнгийн талаарх мэдээллийг толилуулна.

***Эрсдэлтэй холбогдсон хүлээх үүрэг.*** Групп нь хуулиар аккеридитив болон санхүүгийн батлан даалт гаргах зэргээр эрсдэлтэй холбогдсон үүрэг хүлээсэн хэлцэл хийж болно. Санхүүгийн батлан даалт нь харилцагч гуравдагч талд төлөх төлбөрийн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Групп харилцагчийн өмнөөс төлбөр төлөхөөр эргэж буцалтгүй баталгаа гаргах бөгөөд зээлтэй нэгэн адил эрсдэлийг бий болгодог.

Санхүүгийн батлан даалт болон зээл олгохтой холбоотой үүргийг анх бүртгэлд тусгахдаа бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх ба энэ нь хүлээн авсан үйлчилгээний хөлсөөр нотлогдоно. Энэхүү дүн нь зээл олгохтой холбоотой үүргэт хугацааны турш шулуун шугамын аргаар хорогдуулах ба энэ нь Банк тусгайлан зээл олгох үүрэг хүлээсэн болон уг зээлийн гэрээг богино хугацааны дараа худалдах зорилгогүй тохиолдолд шулуун шугамын аргаар хорогдуулахгүй бөгөөд энэ тохиолдолд ийм төрлийн зээл гаргах үүргийн төлөө авсан төлбөрийг хойшлуулж, зээлийн анх хүлээн зөвшөөрсөн дүнд оруулж бүртгэдэг.

Тайлант хугацаа бүрийн эцэст зээлийн үүргийг (i) анх хүлээн зөвшөөрсөн дүнгийн хорогдуулаагүй үлдэгдэл дүн (ii) тайлант хугацаа бүрийн эцсийн байдлаарх тухайн үүргийг барагдуулахад шаардагдах хөрөнгийн төсөөлж тооцсон дүнгийн аль их̲ээр хэмжинэ. Хэрэгжиж буй зээлийн үүргийн үйлчилгээний төлбөрийг зохих хугацаанд хүлээн авч байгаа бол холбогдох хугацаанд хуваарилан орлогоор хүлээн зөвшөөрч үүрэг хүлээсэн нийт хугацааны турш бүртгэнэ.

НЭХСНАТГЛОЕАП МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 15

### 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

***Ажилчдын цалин хөлстэй холбоотой зардал***

(i) Богино хугацааны тэтгэвэр, тэтгэмж

Тайлант хугацаанд ажилтнуудад төлсөн цалин, цалин хөлстэй холбоотой бусад зардал нь Группийн ажилчидтай холбогдон гарах үйлчилгээний зардал юм. Богино хугацаанд хамаарагдах хуримтлагдсан нөхөн олговор нь жил бүрийн ээлжийн амралтын олговор бөгөөд ирээдүйд авах нөхөн олговрын хэмжээг нэмэгдүүлж байдаг ажилчдын үйлчилгээгээр тайлбарлана. Ажилтнуудын богино хугацаат цалин хөлс, тэтгэмж, урамшууллын өр төлбөрийг тухай бүрт нь бүртгэх бөгөөд холбогдох үйлчилгээ үзүүлсний дараа зарлагадна.

(ii) Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд хуульд заасны дагуу Засгийн газрын тэтгэвэр, тэтгэмжийн тогтолцоо болох Нийгмийн даатгалын санд шимтгэл төлөх ёстой. Энэхүү шимтгэл нь тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө. Групп нь тогтоосон тэтгэвэр, тэтгэмжийн шимтгэлийн төлөвлөгөөнд мөн шимтгэл төлдөг. Төлсөн шимтгэлийг "тэтгэврийн сангийн зардал"- д ажилчдын Группд үзүүлсэн үйлчилгээний харьцуулалтаар тооцон зардалд бүртгэнэ.

(iii) Урт хугацаат тэтгэвэр, тэтгэмж

Групп нь өөрсдийн ажилтнуудаа хямд өртөгтэй цалингийн болон орон сууцны зээл олгох зорилгоор гуравдагч банкинд эх үүсвэр байршуулсан. Энэхүү хөтөлбөрийн өртгийг анх урьдчилж төлсөн зардлаар тусгасан бөгөөд зээлийн хугацааны турш нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад орлогын дэлгэрэнгүй тайланд тусган зарлагадна.

***Орлого болон зардлыг хүлээн зөвшөөрөх.*** Бүх өрийн хэрэгслийн хувьд хүүгийн орлого ба хүүгийн зардлыг бодит хүүгийн хувийг ашиглан тооцож аккруэл сууриар бүртгэнэ. Энэ аргачлал нь хүүгийн орлого ба зарлагын бүрэлдэхүүн болох гэрээний талуудын хүлээн авсан ба төлсөн шимтгэл, хураамжийг хамруулан тооцох ба энэ шимтгэл хураамж нь бодит хүү, гүйлгээний зардал ба бусад нэмэгдэл, хямдруулалтын салшгүй хэсэг байна.

Санхүүгийн хөрөнгийг бий болгох эсвэл олж авах эсвэл санхүүгийн өр төлбөр гаргахтай холбоотойгоор Группийн хүлээн авсан болон төлсөн шимтгэл зэрэг шимтгэл хураамжууд нь бодит хүүгийн хувийн салшгүй хэсэг байна. Жишээлбэл: зээлжих чадварыг үнэлэх, баталгаа, барьцаа үнэлэх, бүртгэх, санхүүгийн хэрэгслийн нөхцөлийг хэлэлцэн тохирох болон хэлцлийн бичиг баримтыг боловсруулахтай холбоотой бүх шимтгэл хураамжууд. Хэрэв Групп тусгайлан зээл олгох үүрэг хүлээсэн бөгөөд уг зээлийн гэрээг богино хугацааны дараа худалдах зорилгогүй тохиолдолд Группийн зах зээлийн хүүгээр олгосон зээлээс хүлээн авсан шимтгэл, хувь нь бодит хүүгийн хувийн салшгүй хэсэг болно. Групп зээлтэй холбоотой үүргийг ашиг, алдагдлаар дамжуулах бодит үнэ бүхий санхүүгийн өр төлбөр хэмээн үзэхгүй.

Зээл болон өрийн бусад хэрэгслүүд эргэн төлөгдөх нь эргэлзээтэй болоход тэдгээрээс хүлээгдэж буй орох мөнгөн урсгалыг өнөөгийн үнэ цэнэ хүртэл нь бууруулж, харин хүүгийн орлогыг үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжихэд ашигласан хөрөнгийн бодит хүүгийн хувиар тооцсон хямдруулалтын өнөөгийн үнэ цэнээр салган бүртгэнэ.

Тодорхой хугацааны туршид үйлчилгээг үзүүлж олох орлогыг тэр хугацааны туршид нь хуримтлуулна. Эдгээр хураамжид шимтгэлийн орлого, хөрөнгийн удирдлага, хамгаалалтын болон бусад удирдлага, зөвлөгөөний хураамжууд орно.

Гуравдагч талтай гүйлгээний талаар хэлэлцээр хийх эсхүл гүйлгээнд оролцохтой холбоотойгоор үүссэн хураамжууд (хувьцаа эсхүл бусад үнэт цаасыг худалдан авах, бизнес худалдан авах, худалдах зохицуулалт гэх мэт)-ыг холбогдох гүйлгээ дууссан үед хүлээн зөвшөөрнө. Тодорхой нэг гүйцэтгэлтэй уягдсан хураамж эсхүл хураамжийн бүрэлдэхүүн хэсгийг холбогдох шалгуурууд хангагдсаны дараа хүлээн зөвшөөрнө.

***Гадаад валютын ажил гүйлгээ.*** Группийн ажил гүйлгээ бүртгэдэг валют нь үйл ажиллагаагаа явуулдаг эдийн засгийн орчны анхдагч валют бөгөөд Группийн тайлагналын болон бүртгэлийн валют нь төгрөгөөр илэрхийлэгддэг.

Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ хийгдсэн өдрийн холбогдох валютын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлж, ханшийн тэгшитгэлийг тооцно.

ДЕЛОЙТ ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ЗҮҮДАС 16

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

***Гадаад валютын ажил гүйлгээ (үргэлжлэл).***

Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлсэн хөрөнгө ба өр төлбөрийг тухайн тайлант хугацааны эцэс дэх холбогдох валютын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлж ханшийн тэгшитгэлийг тооцно. Ханшийн тэгшитгэлийн хөрвүүлгээс үүссэн олз, гарзыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд тусгана. Түүхэн өртгөөр хэмжигддэг гадаад валютын мөнгөн бус хөрөнгө ба өр төлбөрийг хөрвүүлж ханшийн тэгшитгэл хийхгүй. Мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийн хөрвүүлэлтийн ханшийн зөрүүг ашиг, алдагдлаар тухайн тайлант жилд хүлээн зөвшөөрнө.

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх ам.доллар, иен, евро болон юанийн валют хөрвүүлэлтийн албан ханш дараах байдалтай байна:

| *Валют* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---:|---:|
| Ам.доллар | 3,410.69 | 3444.60 |
| Иен | 24.22 | 26.07 |
| Евро | 3,791.66 | 3669.02 |
| Юань | 480.01 | 495.40 |

***Үндсэн үүрэг гүйцэтгэгч ба агентын гэрээ.*** Групп нь тусгайлсан зээлдэгчдэд тусгай зээлийн багцыг олгох зорилгоор санхүүжилт авдаг. Энэ төрлийн хэлцэлд, санхүүжилт олгогч талын хувьд Групп нь үндсэн үүрэг гүйцэтгэгч, эсвэл агентын үүрэг гүйцэтгэх эсэхийг дараах шаардлагуудыг хангасан эсэхээр тодорхойлно, а) Групп нь олгосон хөрөнгийн хэмжээтэй ижил хэмжээгээр эргүүлэн цуглуулж чадаагүй бол боломжит хүлээн авагчид төлөх үүрэг хүлээгээгүй, б) дамжуулах гэрээний нөхцөлөөр боломжит хүлээн авагчид төлөх үүргийн дагуу хөрөнгийг худалдах болон барьцаалахыг Группэд хориглосон, в) хүлээн авагчийн өмнөөс цуглуулсан мөнгөн урсгалыг Банк удаан хугацаагаар хойшлуулалгүй шилжүүлэх үүрэгтэй. Хэрэв дээрх шалгуурууд хангагдаж чадахгүй байвал, Банк үндсэн үүрэг гүйцэтгэгч ба нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд хөрөнгө ба өр төлбөрөөр тусгагдах олгох санхүүжилт болон хүлээн авах санхүүжилтийг, нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад орлогын дэлгэрэнгүй тайланд тусгагдах холбогдох хүүгийн орлого болон хүүгийн зарлагын хамтаар хүлээн зөвшөөрнө.

Хэрэв дээрх шалгуурууд хангагдаж байвал, Групп нь агентын үүргийг гүйцэтгэх ба гэрээний төлбөрийг нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад орлогын дэлгэрэнгүй тайланд бүртгэнэ. Олгосон санхүүжилт болон хүлээн авсан санхүүжилт нь хөрөнгө, өр төлбөрөөр тодорхойлогдохгүй бөгөөд нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд тусгагдахгүй.

***Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ.*** Групп, түүний холбоотой этгээдийн хооронд хөрөнгө, ажил үйлчилгээ эсвэл үүргийг нөхөн төлбөртэй, төлбөргүй нөхцөлөөр шилжүүлэг хийхийг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ.

Дараах нөхцөлийг хангасан этгээд эсвэл түүний гэр бүлийн ойрын гишүүн нь Группийн хувьд холбоотой тал болно:

- Группийг шууд эсвэл хамтран хянадаг;
- Группийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөө үзүүлдэг;
- Групп, түүний толгой компанийн удирдах гол албан тушаалтнууд.

Дараах нөхцөлийг хангасан аж ахуйн нэгж, байгууллага нь Группийн холбоотой талууд болно:

- Тухайн аж ахуйн нэгж болон Групп нь нэг Группийн гишүүн байх ба энэ тохиолдолд толгой компани, охин компаниуд нь хоорондоо холбоотой талууд болно;
- Тухайн аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийнхээ хараат компани эсвэл хамтарсан хөрөнгө оруулалттай байх эсвэл нөгөө аж ахуйн нэгжийнхээ харьяалагддаг Группийн гишүүн компанийн хамтарсан хөрөнгө оруулалттай эсвэл хараат компани байх;
- Хоёр компани хоёулаа нэг гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани байх;
- Нэг компани нь гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бөгөөд нөгөө компани нь тухайн гуравдагч этгээдийн хараат компани байх;
- Тухайн аж ахуйн нэгж нь Групп, түүний холбоотой талын ажиллагсдын тэтгэврийн санг хариуцдаг байх;
- Тухайн аж ахуйн нэгж нь дээр дурдсан холбоотой этгээдийн шууд эсвэл хамтарсан хяналтын дор байх;
- Группийг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний толгой компанийн удирдах гол албан тушаалтан байх.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
17
ХУУДАС

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

***Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ (үргэлжлэл).***

Банкны үйл ажиллагааны чиглэлээс хамаарахаас гадна бодлого хэрэгжүүлэгч банкны хувьд олон зээл болон ажил гүйлгээнүүд нь холбоотой талуудтай хийгдсэн байдаг. Групп нь НББОУС 24-ийн 25-д заасны дагуу Засгийн газартай холбоотой этгээдтэй хийсэн материаллаг бус ажил гүйлгээг толилуулах үүргээс чөлөөлөх заалтыг хэрэгжүүлсэн.

***Санхүүгийн байдлын тайланг хөрвөх чадвараар эрэмбэлэн тайлагнах.*** Групп нь тодорхой заасан үйл ажиллагааны давтамжгүй бөгөөд эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд тусад нь ангилж тайлагнадаггүй. Харин хөрөнгө, өр төлбөр нь хөрвөх чадвараар эрэмбэлэгдэн тайлагнадаг. Тодруулга 28-д хөрвөх чадварын удирдлагын зорилгоор толилуулсан санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн шинжилгээний дүнгээр санхүүгийн хөрөнгө, өр төлбөр нь тайлангийн хугацааны дараа ойролцоогоор 12 сарын өмнө болон хойно баргагдаж эсвэл төлөгдөж дуусна гэсэн хүлээлттэй байдаг. Санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрийн хувьд удирдлага эдгээр хөрөнгө, өр төлбөртэй холбоотой тодруулгуудад нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд хүргэх хангалттай мэдээлэл агуулагдсан гэж үзэж байна.

## 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНЭЛЭМЖ БА ТОДОРХОЙ БУС БАЙДЛЫН ТААМАГЛАЛ ТООЦООЛЛЫН ҮНДСЭН ЭХ СУРВАЛЖ

Үнэлэмж болон таамаглал, тооцооллыг өмнөх жилүүдийн туршлага ба холбогдох бусад хүчин зүйлсэд үндэслэн гүйцэтгэдэг. Үүнд бодит үр дүн нь зөрүүтэй байж болох тул таамаглал, тооцооллыг байнга хянадаг. Таамаглал тооцоололд гарсан өөрчлөлт нь зөвхөн тайлант жилд нөлөөлөх бол өөрчлөлтийг тухайн тайлант хугацаанд, хэрэв өөрчлөлтийн нөлөө тайлант жил болон ирээдүйн тайлант жилүүдэд гарвал тухайн тайлант хугацаа болон өөрчлөлт гарах ирээдүйн тайлант жилүүдэд бүртгэлд тусгана.

***Тооцооллын тодорхой бус байдлыг бий болгож буй гол хүчин зүйлс.*** Тайлант хугацаа бүрийн эцэст дараагийн санхүүгийн 12 сарын хугацаанд хөрөнгө ба өр төлбөрийн бүртгэлийн үнэд материаллаг залруулга хийгдэх эрсдэлтэй дор дурдсан нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдлууд байна.

**Зээл ба урьдчилгаанд тооцсон үнэ цэнийн бууралтын сан**

Банк нь үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг харилцагчийн зээлд илэрсэн эсэхийг үнэлж, эрсдэлийн санг хүлээн зөвшөөрөх үгүйг тодорхойлдог. Үнэ цэнийн бууралтын илэрсэн харилцагч байгаа үед, удирдлага нь харилцагчдын төлбөрийн хоцролтоос бий болсон үнэ цэнийн бууралтын санг хүлээн зөвшөөрөх шаардлага гарах бөгөөд харилцагчийн эргэн төлөлтийн хүсэлтийг хүлээн авах магадлалыг үнэлнэ. Удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайланг батлах үед байгаа бүх мэдээллийг энэхүү үнэлгээнд тооцож үздэг.

Удирдлага нь уг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан зээлийн үнэ цэнийн бууралтын сангийн хэмжээ нь үнэ цэнийн бууралт үүссэн, зээлийн төлбөр хойшлогдох магадлалтай харилцагчдын зээлд хангалттай хэмжээний үнэ цэнийн бууралтын сан байгуулсан гэж үзсэн.

Банк зээлийн багцын үнэ цэнийн бууралтыг тогтмол хянадаг. Харилцагчийн төлөх зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг тухайн тайлант үеийн ашиг алдагдлаар бүртгэх эсэхийг тодорхойлохдоо зээлийн багц дахь тухайлсан зээлийн үнэ цэнийн бууралтыг үнэлэхээс өмнө зээлийн багцын хүлээгдэж буй мөнгөн урсгалд хэмжигдэхүйц үнэ цэнийн бууралт ажиглагдаж байгаа эсэхийг тогтоодог. Үүнд Банкны зээлдэгчдийн эргэн төлөлтөд сөргөөр гарсан өөрчлөлтүүд эсвэл Банкны хөрөнгөнд шууд нөлөө үзүүлэхүйц үндэсний болон бүс нутгийн эдийн засгийн нөхцөл байдалд үүссэн сөрөг өөрчлөлт зэрэг ажиглагдахуйц мэдээлэл орно. Удирдлага нь ирээдүйн мөнгөн урсгалыг төвлөхдөө ижил төрлийн зээлийн эрсдэлийн шинж чанартай хөрөнгийн үзүүлэлтүүдийн хувьд хохирол учирсан түүхэн мэдээлэл, мөн багц доторх хөрөнгийн үнэ цэнийн бууралтын талаарх бодит нотолгоон дээр үндэслэн тооцоолол хийдэг. Ирээдүйн мөнгөн урсгалын хэмжээ ба хугацааг төсөөлөхөд ашиглагдсан энэ аргачлал ба таамаглалыг тооцоолсон алдагдал болон бодит алдагдлын зөрүүг багасгах зорилгоор байнга хянадаг. Тусгайлсан зээлүүдэд байгуулсан үнэ цэнийн бууралтын зардлыг тухайн зээл бүрийн ирээдүйн мөнгөн урсгалыг хямдруулсан дүнд аливаа эргэн төлөлт болон зээлийн барьцаа хөрөнгийг борлуулснаас орж ирэх орлого зэргийг харгалзан үзэж тооцоолдог.

Түүнчлэн, удирдлага нь үнэ цэнийн бууралтын үзүүлэлтгүй зээлүүдэд зээлийн багц дээр нь үндэслэн үнэ цэнийн бууралтын нөөц сан байгуулах шаардлагатай эсэх эсвэл тусгайлан үнэ цэнийн бууралтын нөөц сан байгуулаагүй зээлүүдэд одоогийн үйл ажиллагааны орчин, санхүүгийн нөхцөл, харилцагчийн үйл ажиллагаагаа явуулж буй салбарын хөрвөх чадвар, барьцааны түвшин болон барьцааг практик дээр нөхөн төлбөрт авах боломж, Банкны санхүүжүүлсэн ижил төстэй төслүүдийн эргэн төлөлтийн чадварыг харгалзан үзнэ. Багц зээлийн үнэлгээнд харилцагчаас эргэн төлөгдөхөөр хүлээгдэж буй зээлүүд хамрагдсан.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХЯНАВ

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

**4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНЭЛЭМЖ БА ТОДОРХОЙ БУС БАЙДЛЫН ТААМАГЛАЛ ТООЦООЛЛЫН ҮНДСЭН ЭХ СУРВАЛЖ (ҮРГЭЛЖЛЭЛ)**

***Зээл ба урьдчилгаанд тооцсон үнэ цэнийн бууралтын сан (үргэлжлэл)***

Бодитоор үүссэн зардлын хэмжээ нь тооцоолж үнэлсэн зардлын хэмжээнээс 10%-иар ихэсгэх буюу бууруулахад зээлийн үнэ цэнийн бууралтын зардалд 82,524 сая төгрөгийн өсөлт, бууралтын нөлөө бий болно (2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр: 10%-ийн өсөлт, бууралт нь 89,002 сая төгрөг). Тодруулга 11-ээс харна уу.

**Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ**

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилтийн өдөр зах зээлд оролцогчид хөрөнгийг худалдахад хүлээн авах үнэ, өр төлбөрийг шилжүүлэхэд төлөх үнэ байна. Хөрөнгийг борлуулах болон өр төлбөрийг шилжүүлэх гүйлгээ нь (эсвэл хамгийн ашигтай) зах зээлд (жишээ нь: эцсийн үнэ) тухайн үед тодорхойлсон үнэ бөгөөд тухайн үнэ нь шууд ажиглагдахуйц эсвэл үнэлгээний бусад арга техник ашиглаж тооцсон эсэхээс үл хамаарна. Санхүүгийн байдлын тайланд бүртгэсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг идэвхтэй үйл ажиллагаатай зах зээл дээрээс олж мэдэх боломжгүй байгаа үед тэдгээрийг математик аргачлалуудыг ашиглах гэх мэт төрөл бүрийн үнэлгээний техникүүдийг ашиглан тодорхойлно.

Тэдгээр аргачлалд хэрэглэх өгөгдлүүдийг зах зээлийн боломжит өгөгдлүүдээс гарган авах ба ашиглах боломжтой зах зээлийн өгөгдөл байхгүй тохиолдолд бодит үнэ цэнийг тодорхойлохдоо үнэлгээг хийх шаардлагатай болно. Үнэлгээ хийх болон тооцоолол хийхдээ төлбөрийн чадвар болон зээлийн эрсдэл (өөрийн болон харилцагч талын), санхүүжилтийн үнэ цэнийн тохируулгууд тэдгээрийн хамаарал болон хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл хийн загварын өгөгдлүүдийг авч үзнэ.

Бодит үнэ цэнээр бүртгэсэн үндсэн санхүүгийн хэрэглүүрүүд нь ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө, зах зээлийн үнэд үндэслэн тооцсон борлуулах боломжтой хөрөнгө оруулалтууд, деривативт санхүүгийн хэрэглүүрүүдээс бүрдэж байна. Бодит үнэ цэнийг тооцоход ашигласан зах зээлийн үнэ 10 хувиар өсөх эсвэл буурахад ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө нь 1,181 сая төгрөгөөр (2022 оны 12 дугаар сарын 31: 10 хувийн өсөлт, бууралт 1,594 сая төгрөг) нэмэгдэж эсвэл буурна. Бодит үнэ цэнийг тооцоход ашигласан зах зээлийн үнэ 10 хувиар өсөх эсвэл буурахад борлуулах боломжтой хөрөнгө оруулалт нь 21,218 сая төгрөгөөр (2022 оны 12 дугаар сарын 31: 10 хувийн өсөлт, бууралт 31,247 сая төгрөг) нэмэгдэж эсвэл буурна. Бодит үнэ цэнийг тооцоход ашигласан загваруудад дахь утгууд 10 хувиар өсөх эсвэл буурахад санхүүгийн деривативууд 423 сая төгрөгөөр (2022 оны 12 дугаар сарын 31: 10 хувийн өсөлт, бууралт 1,608 сая төгрөг) нэмэгдэж эсвэл буурна.

Бодит үнэ цэнийг тодорхойлох талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 30-аас харна уу.

**Хойшлогдсон орлогын татварын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт**

Хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татварын хөрөнгө нь ирээдүйн татвар ногдох ашгаас хасагдах журмаар нөхөгдөх орлогын татвар бөгөөд нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд бүртгэгдэнэ. Холбогдох татварын буцаалтыг эдлэх боломжтой хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгөнд бүртгэнэ. Ирээдүйд татвар ногдох орлого болон татварын буцаалтыг удирдлагын боловсруулсан дунд хугацааны бизнес төлөвлөгөө болон холбогдох тооцоолол дээр үндэслэн гаргана. Бизнес төлөвлөгөөг Банкны тайлант хугацааны бодит ашиг болон бусад нөхцөл байдлын хүрээнд үндэслэлтэй хэмээн үзсэн удирдлагын хүлээлт дээр суурилан хийсэн. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Банк 46,069 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгө (2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 47,332 сая төгрөг) хүлээн зөвшөөрсөн (Тодруулга 27) ба энэ нь голдуу Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу гадаад валютаарх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй алдагдлаас үүссэн татварын түр зөрүүтэй холбоотой. Банкны удирдлага гадаад валютаарх өр төлбөрийг (бусдаас авсан зээл болон өрийн бичгийг) эргэн төлөх үед хойшлогдсон татварын хөрөнгө нь татварын 25 хувиар хэрэгжинэ гэж үзсэн.

Үүний үр дүнд, удирдлага нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх 46,069 сая төгрөгийн хойшлогдсон татварын цэвэр хөрөнгийг бүрэн хэрэгжинэ гэж үзсэн ба уг дүгнэлтэд хүрэхийн тулд нэгтгэсэн санхүүгийн тайланг батлан гаргах өдрөөрх холбогдох дүрэм журам, нөхөн төлөлтийн шинж чанар болон холбогдох татварын хөнгөлөлт, уг нөхцөл байдалтай холбоотой урьд тохиолдсон жишгүүд болон бусад боломжит бүх мэдээллийг харгалзан үзсэн.

***Монгол Улсын татварын систем.*** Монгол Улсын Засгийн газар нь зах зээлийн эдийн засагт бүрэн шилжихийн тулд шинэчлэлүүдийг хийсээр байна. Үүний үр дүнд үйл ажиллагаанд шууд нөлөөлдөг хууль тогтоомжууд хурдтай өөрчлөгдсөөр байна. Групп нь татварын өр төлбөрөө одоогийн татварын хууль тогтоомжийн дагуу тогтоосон бөгөөд хууль тогтоомжид гарах аливаа өөрчлөлт нь Группийн хэмжээнд татварын эрсдэл дагуулж болзошгүй.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 19

## 5. ШИНЭЭР ГАРСАН БОЛОН ӨӨРЧЛӨГДСӨН СТАНДАРТ, ТАЙЛБАРУУДЫН ХЭРЭГЖИЛТ

Доорх шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд нь ирэх тайлант жилүүдэд хүчин төгөлдөр үйлчилж эхлэх бөгөөд Групп эдгээрийг хараахан хэрэгжүүлээгүй байна. Групп эдгээр стандартуудыг хэрэгжих үед, хэрвээ эдгээр нь хамааралтай гэж үзвэл дагаж мөрдөх болно.

**СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр (СТОУС 9)**

2015 оны 12 дугаар сард хэвлэгдсэн СТОУС 9 нь одоо мөрдөгдөж байгаа НББОУС 39 Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилтийг орлох болно. СТОУС 9 нь санхүүгийн хэрэглүүрийн ангилал, хэмжилтийн талаарх шинэчилсэн удирдамжийг агуулсан ба үүнд санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцоход хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварыг ашиглаж, мөн хейджийн нягтлан бодох бүртгэлийн ерөнхий шинэ шаардлагууд багтсан. Мөн санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх болон үл хүлээн зөвшөөрөх СТОУС 9-ийн удирдамжийг уг стандартад оруулсан.

*Санхүүгийн хөрөнгийн ангилал*

СТОУС 9 нь санхүүгийн хөрөнгийг мөнгөн урсгалын үзүүлэлтэд үндэслэн ангилах болон хэмжих шинэ бизнесийн загварт суурилсан шинэчилсэн аргачлалыг багтаасан.

СТОУС 9 нь санхүүгийн хөрөнгийн үндсэн гурван ангилалтай: хорогдуулсан өртгөөр хэмжсэн, бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлсэн (БДОБҮЦ) болон ашиг, алдагдлаар бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө (ААБҮЦСХ) зэрэг үүнд багтана. Уг стандарт нь одоогийн НББОУС 39-ийн хөрөнгийн ангилал болох дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө (ДХХЭСХ), зээл ба авлага, борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө (ББСХ) гэх ангиллуудыг байхгүй болгосон.

*Санхүүгийн ба гэрээний хөрөнгийн үнэ цэнийн бууралт*

СТОУС 9 нь НББОУС 39-ийн "алдагдал хүлээх үйл явдал тохиолдсон байх" гэсэн загварыг "хүлээгдэж буй алдагдал" (ХБА) загвараар орлох болсон. Ингэснээр эдийн засгийн үзүүлэлтүүд хэрхэн хүлээгдэж буй алдагдлын тооцоололд нөлөөлөх тухай жигнэсэн дундаж аргыг ашиглан дүгнэлт хийх болох юм.

Шинэ үнэ цэнийн бууралтын загварыг өмчийн хэрэглүүр дэх хөрөнгө оруулалтаас бусад хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, БДОБҮЦ-ээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө болон гэрээний хөрөнгөнд ашиглана.

СТОУС 9-ийн дагуу эрсдэлийн санг дараах хоёр суурийн аль нэгээр хэмжинэ:

- 12 сарын хүлээгдэж буй зээлийн алдагдал. Энэ нь тайлагналын өдрөөс хойш 12 сарын хугацаанд үүсэж болох төлбөрийн чадваргүй болох үйл явцаас ХБА юм.
- Ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал. Энэ нь санхүүгийн хөрөнгийг ашиглалтын хугацаанд үүсэж болох төлбөрийн чадваргүй болох үйл явцаас ХБА юм.

Ашиглалтын хугацаанд үргэлжлэх хүлээгдэж буй зээлийн алдагдлыг санхүүгийн хөрөнгийн анх хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн үнэ цэнэ их хэмжээгээр буурсан тохиолдолд ашиглах бөгөөд бусад тохиолдолд 12 сарын ХБА-г ашиглах юм. Хэрэв хөрөнгийн зээлийн алдагдал тайлагнах өдрөөр бага байвал Банк нь санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл томоохон хэмжээгээр өсөхгүй гэж тооцож болно.

*Санхүүгийн өр төлбөрийн ангилал*

СТОУС 9 нь санхүүгийн өр төлбөрийн ангиллын хувьд НББОУС 39-ийн одоо мөрдөгдөж буй ихэнх шаардлагуудыг хэвээр үлдээсэн.

СТОУС 39-ийн дагуу санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдал руу хаадаг байсан бол СТОУС 9-ийн дагуу бодит үнэ цэнийг дараах байдлаар толилуулдаг:

- Санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүн нь зээлийн эрсдэлээс шалтгаалсан бол бусад дэлгэрэнгүй орлогод тайлагнана.

- Санхүүгийн өр төлбөрийн үнэ цэнийн өөрчлөлт бусад эрсдэлээс шалтгаалсан бол бусад ашиг, алдагдлаар тайлагнана.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

**5. ШИНЭЭР ГАРСАН БОЛОН ӨӨРЧЛӨГДСӨН СТАНДАРТ, ТАЙЛБАРУУДЫН ХЭРЭГЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)**

***СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр (СТОУС 9) (үргэлжлэл)***

*СТОУС 9-ийн хэрэгжилт*

2018 онд Монголбанкнаас арилжааны банкуудыг СТОУС 9-ийг хэрэгжүүлэхийг 2020 он хүртэл хойшлуулах шийдвэр гаргасан. 2020 онд Монголбанкнаас СТОУС 9-ийг хэрэгжүүлэх хугацааг үргэлжлүүлэн хойшлуулсан ба эцсийн хугацааг хараахан шийдээгүй байгаа тухай Банкинд мэдэгдсэн.

Одоогийн байдлаар Групп нь СТОУС 9-ийн хэрэгжилтийг хойшлуулснаас үүсэх санхүүгийн тайлан дахь нөлөөллийг үнэлж байна. Иймд Групп нь СТОУС 9-ийн хэрэгжилтийн үр нөлөөг хараахан бүрэн үнэлээгүй байна.

**Тайлант жилд хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс шинээр гаргасан бусад стандартууд**

Дараах стандартын нэмэлт өөрчлөлтүүд болон тайлбар тодруулгууд нь Группийн санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй байх төлөвтэй байна.

| Хүчин төгөлдөр болох хугацаа | Шинэ стандарт болон нэмэлт өөрчлөлтүүд |
|---|---|
| 2023 оны 1 дүгээр сарын 1 | Өр төлбөрийг Богино болон Урт хугацаат гэж ангилах талаар (НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт) * |
| | СТОУС 17 Даатгалын гэрээнүүд** болон түүнд орсон нэмэлт өөрчлөлт |
| | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга (НББОУС 1 ба СТОУС-ын практик мэдэгдэл 2-д оруулсан нэмэлт өөрчлөлт) |
| | Нэг удаагийн гүйлгээний үр дүнд бий болсон хөрөнгө, өр төлбөртэй холбоотой хойшлогдсон татвар (НББОУС 12-ын нэмэлт өөрчлөлт) |
| | Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт (НББОУС 8-ын нэмэлт өөрчлөлт) |
| Сонголт хийх боломжтой/ хүчин төгөлдөр болох хугацаар тодорхойгүй хугацаагаар хойшлуулах боломжтой*** | Хөрөнгө оруулагч болон түүний хараат компани, хамтарсан үйлдвэрийн хоорондох хөрөнгийн борлуулалт, хандив (СТОУС 10 болон НББОУС 28-д орох нэмэлт өөрчлөлт) |

*2020 оны 01 дүгээр сард гаргасан НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүд (2020 оны нэмэлт өөрчлөлтүүд) нь ирээдүйд сайжруулалт хийгдэх өөрчлөлтүүдэд хамаарна. СТОУС-ын Тайлбарын хороо 2020 оны нэмэлт өөрчлөлтүүдээс үүдэн гарсан тодорхой хэрэгжүүлэлтийн асуудлуудыг НББОУСЗ-д танилцуулсан. 2021 оны 6 дугаар сард НББОУСЗ нь урьдчилсан байдлаар НББОУС 1-д нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэж, 2020 оны нэмэлт өөрчлөлтүүдийн хүчин төгөлдөр болох хугацаар 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл буюу түүнээс өмнө байх боломжгүйгээр хойшлуулах шийдвэр гаргасан.
**СТОУС 17-ын эрт хэрэгжүүлэлтийг зөвхөн СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл болон СТОУС 15 Харилцагчидтай байгуулсан гэрээний орлого стандартыг мөрдөг компаниудад хүлээн зөвшөөрдөг.
***Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийн хүчин төгөлдөр болох хугацааг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан. Эрт хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрсөн.

**Тайлант жилд шинээр гарсан эсвэл тодотгол хийгдсэн стандартууд болон тайлбаруудын хэрэгжилт**

Тайлант жилд Групп нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд хүчин төгөлдөр, заавал дагаж мөрдөх хэд хэдэн СТОУС-ын нэмэлт өөрчлөлтүүд болон шинэ тайлбаруудыг хэрэгжүүлсэн. Дараах стандартын нэмэлт өөрчлөлтүүд нь 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон боловч Группийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлээгүй.

- Алдагдалтай гэрээ – Гэрээний гүйцэтгэлийн зардал (НББОУС 37-ийн нэмэлт өөрчлөлт)
- 2018-2020 оны СТОУС-ын сайжруулалт
- Үндсэн хөрөнгө: зориулалтаар нь ашиглахаас өмнөх орлого (НББОУС 16-ийн нэмэлт өөрчлөлт)
- Санхүүгийн Тайлагналын Суурь Үзэл Баримтлалын Зөвлөмж (СТОУС 3-ын нэмэлт өөрчлөлт)
- 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс хойших КОВИД-19-тэй холбоотой түрээсийн зөвшилцөлүүд (СТОУС 16-ын нэмэлт өөрчлөлт)

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК ХУУДАС

**6. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ**

| *Мянган төгрөгөөр* | **2023 оны 12 дугаар сарын 31** | **2022 оны 12 дугаар сарын 31** |
|---|---|---|
| Касс дахь бэлэн мөнгө | 513 | 2,090 |
| Монголбанк дахь харилцах | 104,397,326 | 57,588,066 |
| Сангийн Яам дахь харилцах | 1,592,551 | 794,694,877 |
| Бусад банкуудад байршуулсан харилцах: | | |
| - Дотоод | 4,343,499 | 5,493,107 |
| - Гадаад | 33,923,368 | 32,639,065 |
| Дотоодын арилжааны банкуудад байршуулсан богино хугацаат хадгаламж | 300,360 | - |
| **Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө** | **144,557,617** | **890,417,205** |
| Хасах нь: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан | - | - |
| **Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр дүн** | **144,557,617** | **890,417,205** |

Мөнгө ба түүнтэй адилтгах мөнгөн хөрөнгийн эрсдэлийн чанарыг Мүүдийз, Стандарт энд Пүүрс болон Фитчийн тогтоосон зэрэглэлээр үнэлсэн. 2023 болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээлжих зэрэглэл дараах байдалтай байна:

| *Мянган төгрөгөөр* | **2023 оны 12 дугаар сарын 31** | **2022 оны 12 дугаар сарын 31** |
|---|---|---|
| А1 | 19,475,444 | 4,329,274 |
| Монголбанк-В3 зэрэглэлтэй | 104,397,326 | 57,588,066 |
| Сангийн яам-В3 зэрэглэлтэй | 1,592,551 | 794,694,877 |
| В3 | 19,091,604 | 5,491,853 |
| Зэрэглэлгүй | 179 | 28,311,045 |
| **Нийт мөнгө ба түүнтэй адилтгах мөнгөн хөрөнгө, касс дахь бэлэн мөнгө ороогүй** | **144,557,104** | **890,415,115** |

МЭЙСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 7. БАНКУУДАД БАЙРШУУЛСАН МӨНГӨН ХАДГАЛАМЖ

Группийн банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжууд нь тухайн хадгаламжийг авснаас хойш гурван сараас дээш хугацаатай хадгаламжууд байна.

Мөнгөн хадгаламжийн эрсдэлийн чанарыг Мүүдийз, Стандарт энд Пүүрс болон Фитчийн зэрэглэлээр үнэлсэн. 2023 болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээлжих зэрэглэл дараах байдалтай байна:

| *Мянган төгрөгөөр* | 2022 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| B3 | 15,274,576 | 13,981,965 |
| Зэрэглэлгүй | 40,129,061 | 49,904,551 |
| **Нийт банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж** | **55,403,637** | **63,886,516** |
| Хасах нь: Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжийн үнэ цэнийн бууралтын сан | (22,611,260) | (34,954,898) |
| **Нийт банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжийн цэвэр дүн** | **32,792,377** | **28,931,618** |

**Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан**

Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжид байгуулсан үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн хөдөлгөөнийг харуулав:

| *Мянган төгрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Эхний үлдэгдэл | 34,954,898 | 31,886,821 |
| Тайлант жилд байгуулсан | 424,913 | 3,150,202 |
| Тайлант жилд буцаасан | (3,486,343) | (151,600) |
| Бусад хөрөнгө рүү дахин ангилсан | (9,126,022) | - |
| Гадаад валютын ханшийн зөрүү | (156,186) | 69,475 |
| **Эцсийн үлдэгдэл** | **22,611,260** | **34,954,898** |

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 23

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 8. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮД

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | | 2022 оны 12 дугаар сарын 31 | |
|---|---|---|---|---|
| | Дансны үнэ | Дансны үнэ | Дансны үнэ | Нэрлэсэн үнэ ам.доллар |
| Дотоодын банкнаас ам.доллараар авах авлага | - | - | 21,753,965 | 325,000,000 |
| **Нийт үүсмэл санхүүгийн хөрөнгө** | **-** | | **21,753,965** | |
| Гадаадын банканд ам.доллараар төлөх өр төлбөр | - | - | (787,036) | 17,000,000 |
| Гадаадын банканд еврогоор төлөх өр төлбөр | (3,598,694) | 32,275,000 | (4,885,793) | 42,400,000 |
| Гадаадын банканд иенээр төлөх өр төлбөр | (577,630) | 14,500,000 | - | - |
| Гадаадын банканд юаниар төлөх өр төлбөр | (51,500) | 4,600,000 | - | - |
| **Нийт үүсмэл санхүүгийн өр төлбөр** | **(4,227,824)** | | **(5,672,829)** | |

Групп нь нийлүүлэх боломжтой болон нийлүүлэх боломжгүй санхүүгийн үүсмэл хэрэглүүрүүдийн хэлцлүүдэд оролцдог. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Групп нь нийт 51 сая ам.долларын (2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр: 387 сая ам.доллар) нэлттэй валютын форвард хэлцлүүдтэй. Групп хэлцлүүдийн дуусгавар хугацаа хүртэл үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр хэмждэг.

## 9. БОДИТ ҮНЭ ЦЭНЭЭР ХЭМЖСЭН БОРЛУУЛАХАД БЭЛЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| **Өрийн үнэт цаас** | | |
| Монгол Улсын Засгийн Газрын үнэт цаас | - | 4,901,671 |
| Гадаадын засгийн газрын үнэт цаас | - | 3,462,264 |
| Байгууллагын өрийн бичиг | 144,380,184 | 241,667,664 |
| **Өмчийн үнэт цаас** | | |
| МИК Холдинг ХК (Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй) | 67,803,010 | 62,440,408 |
| **Нийт бодит үнэ цэнээр хэмжсэн борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт** | **212,183,194** | **312,472,007** |

Өрийн үнэт цаас нь дотоодын болон олон улсын зах зээлд төгрөг болон ам.доллараар гаргасан Монгол Улсын Засгийн Газрын, бусад улсын болон хувийн компаниудын өрийн бичиг юм.

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын валютын ханш болон дуусах хугацааны шинжилгээг Тодруулга 28-аас харна уу.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 24

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 10. АШИГ АЛДАГДЛААРХ ҮНЭ ЦЭНЭЭР ИЛЭРХИЙЛЭГДСЭН САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн байгууллагын өрийн бичиг | 11,807,750 | 19,248,584 |

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгийн валютын ханш болон дуусах хугацааны шинжилгээг Тодруулга 28-аас харна уу.

### 10.1 ДУУСГАВАР ХУГАЦАА ХҮРТЭЛ ЭЗЭМШИХ ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| Монгол Улсын Засгийн Газрын үнэт цаас | - | 387,826,553 |
| Байгууллагын өрийн бичиг | 180,962,377 | 180,962,377 |
| **Нийт дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаасаарх хөрөнгө оруулалт** | **180,962,377** | **568,788,930** |

Дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаасаарх хөрөнгө оруулалтад Төрийн Орон Сууцны Корпораци ТӨҮГ-аас 2013 болон 2015 онуудад олгосон зээлийн үүргийн оронд төлөх 2027 оны 12 дугаар сард дуусгавар болох нийт 180,500 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий хаалттай бонд багтана.

Дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын валютын ханш болон дуусах хугацааны шинжилгээг Тодруулга 28-аас харна уу.

МЕКСИКА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 25

## 11. ЗЭЭЛ, УРЬДЧИЛГАА БА ТҮРЭЭСИЙН АВЛАГА

Зээл, урьдчилгаа ба түрээсийн авлага дараах бүтэцтэй байна:

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| Зээл ба урьдчилгаа | 2,262,376,007 | 2,641,774,744 |
| Түрээсийн авлага | 62,413,108 | 83,853,959 |
| **Нийт зээл, урьдчилгаа ба түрээсийн авлага** | **2,324,789,115** | **2,725,628,703** |
| Хасах нь: Зээл ба түрээсийн авлагын үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан | (825,238,908) | (890,018,425) |
| **Нийт зээл, урьдчилгаа ба түрээсийн авлагын цэвэр дүн** | **1,499,550,207** | **1,835,610,278** |

Зээлдэгчдэд Группээс шууд санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж буй компаниуд болон Группийн зээлийг дамжуулан зээлдүүлдэг арилжааны банкнууд орно.

Групп нь Монгол Улсын Засгийн Газрын эдийн засгийн хөгжлийн бодлогод тулгуурласан гол стратегийн салбарууд болох дэд бүтэц, зам, эрчим хүч, үйлдвэрлэл, агаарын тээвэр болон барилгын салбаруудад голчлон санхүүжилт олгодог. Групп нь эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, эдийн засгийг төрөлжүүлэх, нэмүү өртөг шингэсэн, экспортыг дэмжих, импортыг орлоход чиглэсэн хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг дунд болон урт хугацаанд санхүүжүүлэхээр зорьж байна.

Монгол Улсын Хөгжлийн банк (ХБ)-ны активын ангилал тогтоох журмын 3-р бүлэг, 2.1.1-д заасны дагуу Хөгжлийн банк нь хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хэмжээг тооцож, хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хувийг нийт хөрөнгийн үлдэгдэлтэй харьцуулан хөрөнгийн ангиллыг тогтооно. 2023 оны 12 сарын 31-ний байдлаар дээрх журмын дагуу банк хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хэмжээг тооцож, үнэ цэнийн бууралтын хувийг тодорхойлсон. Нийт 376.23 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй Хөтөл ХХК-ын зээлээс бусад дээр нь зээлдэгчдийн мөнгөн урсгал дээр дүн шинжилгээ хийж эсвэл МУХБ-аас томилогдсон хараат бус гуравдагч этгээдийн тооцоолсон барьцааны хамгийн сүүлийн үнийн дүн дээр үндэслэн үнэ цэнийн бууралтын тооцооллыг хийсэн болно. "Хөтөл" ХХК-ийн хувьд Монгол Улсын хууль хяналтын байгууллагаас 2022 онд томилогдсон хараат бус гуравдагч этгээдийн үнэлгээгээр 190.8 тэрбум төгрөгийн 80 хувийг барьцаа хөрөнгө гэж үзжээ. Өмнөх зээлийн гэрээнд "Цемент шохой" ХХК-ийн шинэчилсэн үйлдвэрийг барьцаанд оруулан тооцож байсан ч одоо "Цемент шохой" ХХК нь төрийн өмчид бүрэн шилжсэн болно.

Монгол Улсын Хөгжлийн банк (ХБ)-ны активын санг бүрдүүлэх, зарцуулах журмыг тодорхойлсон активын ангилал тогтоох удирдамжийн 2.1.2-т заасны дагуу хөрөнгийн ангиллыг, Хөгжлийн банкнаас журмын 2.1.1-д заасны дагуу Монголбанкны Зээлийн мэдээллийн санд илгээх шаардлагатай. 2023 оны 12-р сарын 24-өөс 2023 оны 12-р сарын 31-ний хоорондох хугацааны зөрүүгээс үүссэн үнэ цэнийн бууралтын дүн нь материаллаг бус мөн залруулахад чухал ач холбогдолтой биш тул МУХБ-ны удирдлагууд үнэ цэнийн бууралтын дүнгээр зохицуулалт хийхгүй байхаар шийдвэрлэсэн.

Групп нь Монгол Улсын эдийн засгийн бодлогод чиглэсэн төсөл, түүний дотор хөдөө аж ахуй, уул уурхай, тээвэр зэрэг тэргүүлэх салбаруудад санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлдэг. Төслүүд нь Группийн зорилготой уялдсан байх шаардлагатай бөгөөд нийгмийн үр ашгийг дээшлүүлж, стратегийн үр ашигтай салбарыг дэмжих зорилготой.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
Хуудас 26

## 11. ЗЭЭЛ, УРЬДЧИЛГАА БА ТҮРЭЭСИЙН АВЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зээлийн багцын эрсдэлийн чанарын шинжилгээг дараах байдлаар харуулав:

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| Хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралтад ороогүй: | | |
| - Улсын байгууллага | 669,013,212 | 319,045,752 |
| - Хувийн байгууллага | 175,785,164 | 304,686,564 |
| **Нийт хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралтад ороогүй зээлийн дүн** | **844,798,376** | **623,732,316** |
| Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтад ороогүй: | | |
| - 30 хүртэлх хоног хугацаа хэтэрсэн | 457,207 | - |
| - 30-аас 90 хоног хугацаа хэтэрсэн | - | 46,801,060 |
| - 90-ээс 180 хоног хугацаа хэтэрсэн | - | 3,205,168 |
| - 180-аас 360 хоног хугацаа хэтэрсэн | - | 35,665,364 |
| - 360 хоногоос дээш хугацаа хэтэрсэн | 187,886,382 | 519,841,031 |
| **Нийт хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтад ороогүй зээлийн дүн** | **188,343,589** | **605,512,623** |
| Үнэ цэнэ буурсан: | | |
| - 30 хүртэлх хоног хугацаа хэтэрсэн | 1,099,777 | 1,321,600 |
| - 360 хоногоос дээш хугацаа хэтэрсэн | 1,290,547,373 | 1,495,062,164 |
| **Нийт үнэ цэнэ буурсан зээл ба урьдчилгаа** | **1,291,647,150** | **1,496,383,764** |
| **Хасах нь: Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан** | **(825,238,908)** | **(890,018,425)** |
| **Нийт зээл, урьдчилгаа ба түрээсийн авлагын цэвэр дүн** | **1,499,550,207** | **1,835,610,278** |

Нийт зээлээс бүтцийн өөрчлөлт хийсний дараах нөхцөлийн дагуу хугацаа хэтрээгүй 310,406 сая төгрөгийн (2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 458,060 сая төгрөг) зээлүүдийг анхаарал хандуулах боловч үнэ цэнийн бууралтад ороогүй зээл буюу хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтад ороогүй гэж үзэж ангилсан. Монголбанкны журмын дагуу үнэ цэнийн бууралт нь нийт зээлийн үлдэгдлийнхээ 5 хувиас 25 хувьд тооцсон зээлүүдийг анхаарал хандуулах зээлүүд гэж үздэг. Толилуулгын хувьд уг зээлүүдийг хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнэ буураагүй ангилалд толилуулсан.

Групп нь зээлийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан нь нийт зээл болон хүүгийн үлдэгдэлтэй харьцуулахад 25 хувиас хэтэрсэн тохиолдолд үнэ цэнийн бууралтад орсон зээл гэж үздэг.

Группийн үйл ажиллагааны шинж чанар болон цөөн тооны зээлдэгчдээс шалтгаалан Группийн зээлийн эрсдэл тодорхой хэмжээнд төвлөрсөн байна. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх хамгийн том 5 зээлдэгчид олгосон зээлийн нийт дүн үнэ цэнийн бууралтаас өмнө 1,236,622 сая төгрөг (2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 1,273,099 сая төгрөг) буюу нийт зээл ба урьдчилгаа, түрээсийн авлагын 53.2 хувь (2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 46.7 хувь)-ийг эзэлж байна. Эдгээр том 5 зээлдэгчдийн зээлийн нийт дүн зээлийн үнэ цэнийн бууралтын дараа 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 769,508 сая төгрөг (2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 781,037 сая төгрөг) буюу нийт зээл ба урьдчилгаа, түрээсийн авлагын 51.3 хувийг (2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 42.5 хувь) эзэлж байна. Эдгээр хамгийн том 5 зээлдэгчийн зээлд орон нутгийн арилжааны банкаар дамжуулан олгосон зээлүүд багтаагүй.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК ХУУДАС

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 11. ЗЭЭЛ, УРЬДЧИЛГАА БА ТҮРЭЭСИЙН АВЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зээл урьдчилгаа ба түрээсийн авлагын үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

| *Мянган төгрөгөөр* | Зээл ба урьдчилгаа | Түрээсийн авлага | Нийт дүн |
|---|---|---|---|
| **2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөрх зээл, урьдчилгаа ба түрээсийн авлагын үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан** | **932,223,577** | **9,104,516** | **941,328,093** |
| **Тухайн жилийн цэвэр өөрчлөлт** | **(49,627,632)** | **(1,682,036)** | **(51,309,668)** |
| Тайлант жилд байгуулсан | 5,133,992 | 1,456,722 | 6,590,714 |
| Тайлант жилд буцаасан | (133,330,113) | (3,138,758) | (136,468,871) |
| Тайлант жилийн гадаад валютын ханшийн хөдөлгөөн | 78,568,489 | - | 78,568,489 |
| **2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээл, урьдчилгаа ба түрээсийн авлагын үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан** | **882,595,945** | **7,422,480** | **890,018,425** |
| **Тухайн жилийн цэвэр өөрчлөлт** | **(75,927,730)** | **11,148,213** | **(64,779,517)** |
| Өмнөх жилийн залруулга | - | 9,273,952 | 9,273,952 |
| Тайлант жилд байгуулсан | 65,206,385 | 3,288,900 | 68,495,285 |
| Тайлант жилд буцаасан | (138,681,255) | (403,451) | (139,084,706) |
| Тайлант жилийн гадаад валютын ханшийн хөдөлгөөн | (2,452,860) | (1,011,188) | (3,464,048) |
| **2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээл, урьдчилгаа ба түрээсийн авлагын үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан** | **806,668,215** | **18,570,693** | **825,238,908** |

Барьцаа хөрөнгийн санхүүгийн нөлөөг барьцаа хөрөнгийн үнэ цэнийг тусад нь тодруулан дараах байдлаар толилуулсан ба үүнд (i) барьцаа хөрөнгө болон эрсдэлийн сайжруулалт нь зээлийн дансны үнээс тэнцүү буюу илүү ("барьцаа хөрөнгө хангалттай зээл"); болон (ii) барьцаа хөрөнгө болон эрсдэлийн сайжруулалт нь зээлийн дансны үнээс бага ("барьцаа хөрөнгө хангалтгүй зээл") багтана.

Барьцаа хөрөнгийн санхүүгийн нөлөө дараах байдалтай байна:

| | **2023 оны 12 дугаар сарын 31** | | **2022 оны 12 дугаар сарын 31** | |
|---|---|---|---|---|
| *Мянган төгрөгөөр* | Зээл ба урьдчилгааны дансны үнэ | Барьцаа хөрөнгийн бодит үнэ | Зээл ба урьдчилгааны дансны үнэ | Барьцаа хөрөнгийн бодит үнэ |
| Барьцаа хөрөнгө хангалттай зээл | 1,024,668,882 | 1,599,674,800 | 1,319,700,283 | 1,994,603,110 |
| Барьцаа хөрөнгө хангалтгүй зээл | 474,881,325 | 460,874,351 | 515,909,995 | 399,775,249 |
| **Нийт зээл, урьдчилгаа ба түрээсийн авлагын цэвэр дүн** | **1,499,550,207** | **2,060,549,151** | **1,835,610,278** | **2,394,378,359** |

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 28

## 11. ЗЭЭЛ, УРЬДЧИЛГАА БА ТҮРЭЭСИЙН АВЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Нөхцөл өөрчилсөн санхүүгийн зээлийн дансны үнэ дараах байдалтай байна:

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| **Нийт нөхцөл өөрчилсөн зээл ба урьдчилгаа** | **1,935,274,138** | **1,910,083,359** |

Зээлдэгч төлбөрийн шинэчилсэн хуваарийн дагуу төлж буй нөхцөл өөрчилсөн зээлийг хэвийн зээл гэж үздэг.

Үнэ цэнийн бууралтын өмнөх зээлийн багц дахь эдийн засгийн салбарын эрсдэлийн төвлөрөл дараах байдалтай байна:

| | 2023 оны 12 дугаар сарын 31 | | 2022 оны 12 дугаар сарын 31 | |
|---|---|---|---|---|
| *Мянган төгрөгөөр* | Дүн | % | Дүн | % |
| - Үйлдвэрлэл | 1,292,464,691 | 56% | 1,602,377,074 | 59% |
| - Цахилгаан, эрчим хүч | 532,941,553 | 23% | 433,080,082 | 16% |
| - Уул уурхай, олборлолт | 283,760,764 | 12% | 310,593,255 | 11% |
| - Барилга | 122,012,384 | 5% | 192,136,726 | 7% |
| - Эрүүл мэнд, нийгмийн ажил | 40,900,000 | 2% | 68,067,045 | 3% |
| - Тээвэр, логистикийн үйл ажиллагаа | 36,048,592 | 2% | 47,104,822 | 2% |
| - Хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон загас агнуур | 8,490,903 | 0% | 63,540,379 | 2% |
| - Санхүү, даатгалын үйл ажиллагаа | 850,663 | 0% | 850,663 | 0% |
| - Бусад | 7,319,565 | 0% | 7,878,657 | 0% |
| **Үнэ цэнийн бууралтын өмнөх зээл, урьдчилгаа ба түрээсийн авлагын нийт дүн** | **2,324,789,115** | **100%** | **2,725,628,703** | **100%** |

### 11.1 ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ

Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 81 тоот тогтоол болон "Түрээсийн Орон Сууцны Хөтөлбөр"-ийн хүрээнд Банк нь 2013 онд санхүүжилт олгож байсан "Төрийн Орон Сууцны Корпораци" ТӨҮГ (ТОСК), Барилга, Хот Байгуулалтын Яам болон хэд хэдэн барилгын компаниудтай дөрвөн талт гэрээг байгуулсан. Уг гэрээний гол зорилго нь ТОСК-ийн өмнө нь эзэмшиж байсан бөгөөд үргэлжлүүлэн удирдаж буй дуусаагүй барилгын төслүүдийг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулах явдал юм. Уг гэрээний хүрээнд Банк нь 2018 оны 6 дугаар сард ТОСК-с өмчлөх бусад хөрөнгүүдийн өмчлөх эрхийг авч, эдгээр дуусаагүй барилгуудыг барьж дуусгахаар тохиролцсон. Эдгээр өмчлөх бусад хөрөнгүүдийн өмчлөлийг авах үеийн дансны үнэ нь 35,477 сая төгрөг байсан бөгөөд үүнээс хойш Банк нийт 62,342 сая төгрөгийн санхүүжилтийг барилгын ажлыг дуусгахад зориулан хөрөнгө оруулсан байна.

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх өмчлөх бусад хөрөнгийн нийт дансны үнэ 241,529 сая төгрөг байна. (2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр: 257,073 сая төгрөг)

Говь-Алтай аймагт 120 айлын 2 орон сууцны барилга, Хөвсгөл аймагт 135 айлын 3 орон сууцны барилга, Улаанбаатар хотод 972 айлын 18 орон сууцны барилгыг дуусган, 2019 онд ашиглалтад оруулсан. Орхон аймагт 315 айлын 5 орон сууцны барилгыг дуусган, 2020 онд ашиглалтад оруулсан.

Монгол Улсын Засгийн Газрын 223 тоот тогтоол болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 23 тоот тогтоолоор эдгээр орон сууцыг худалдан борлуулах ерөнхий удирдамжийг гаргасан ба Банк уг удирдамжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Удирдлагаас эдгээр хөрөнгүүдийг орон нутгийн засаг даргын тамгын газруудад (ЗДТГ) шилжүүлэх ажлыг эхлүүлээд байна. 2020 онд Банк нь Улаанбаатар хот, Говь-Алтай аймаг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-тай эдгээр өмчлөх бусад хөрөнгүүдийг шилжүүлэх гэрээ байгуулсан. 2021 оны 6 дугаар сард Банк Орхон аймгийн ЗДТГ-тай гэрээ байгуулсан. 2023 онд эдгээр гэрээнүүдийн хүрээнд Банк нь орон сууцуудыг худалдан авах урьдчилгаа төлбөрийг эдгээр зохицуулагч байгууллагуудаас хүлээн авсан ба 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 3.8 тэрбум төгрөг (2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр: 3.9 тэрбум төгрөг) хүлээн авсан. Тодруулга 19-ийг харна уу.

***Монгол Улсын Хөгжлийн Банк***
***Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31***
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

**11.1 ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)**

2023 онд Групп нь Улаанбаатар хотын албанд 6,148 сая болон Орхон аймагт 670 сая төгрөгийн дүнтэй тэнцэх хэмжээний орон сууцыг (2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөр: Улаанбаатар хотын албанд 2,749 сая төгрөг, Говь-Алтай аймагт 199 сая төгрөг) тус тус шилжүүлээд байна. Шилжүүлсэн барьцаа хөрөнгөтэй холбоотойгоор хүлээн зөвшөөрсөн олзын дүнг Тодруулга 23-аас харна уу.

2022 онд Групп нь Монгол Мах Экспо ХХК-ын чанаргүй зээлийн үлдэгдэл болон Капитал Банк ХХК-аас авах дамжуулан зээлийн өр төлбөрт тооцон Хан-Уул дүүрэгт байрлах Гантиг Вилла төслийн барилга болон орон сууцыг нийт 86,779 сая төгрөгөөр тооцон банкны өмчлөлд 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр шилжүүлсэн ба тухайн хөрөнгийн дансны үнэ 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өөрчлөгдөөгүй байна.

Групп нь Хан-Уул дүүрэгт байрлах ("Шинэ Яармаг орон сууцны төсөл") 84,337 сая төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг "Төрийн Орон Сууцны Корпораци" ТӨҮГ (ТОСК)-ын чанаргүй зээлийн үлдэгдэлд Групп-д шилжүүлсэн өдрийн байдлаар дүйцүүлэн шилжүүлэн авсан. 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар эдгээр өмчлөх бусад хөрөнгийн дансны үнэ 82,024 сая төгрөг байна.

2023 онд Групп нь нийт 6,657.1 сая төгрөгийн дансны үнэ бүхий 23 орон сууц, 6 үйлчилгээний талбай, 15 авто зогсоол бүхий өмчлөх бусад үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулсан байна. Шилжүүлсэн барьцаа хөрөнгөтэй холбоотойгоор хүлээн зөвшөөрсөн олзын дүнг Тодруулга 23-аас харна уу.

Өмчлөх бусад хөрөнгө дараах байдалтай байна:

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| Дуусаагүй орон сууцны барилгууд | 59,961,874 | 59,961,874 |
| Ашиглахад бэлэн орон сууцны барилгууд | 189,931,837 | 202,085,730 |
| **Нийт өмчлөх бусад хөрөнгө** | **249,893,711** | **262,047,604** |
| Хасах: Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан | (8,364,392) | (4,974,218) |
| **Өмчлөх бусад хөрөнгийн цэвэр дүн** | **241,529,319** | **257,073,386** |

**Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан**

Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн хөдөлгөөнийг харуулав:

| *Мянган төгрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Эхний үлдэгдэл | 4,974,218 | 903,643 |
| Тайлант жилд байгуулсан | 5,925,665 | 4,070,575 |
| Тайлант жилд буцаасан | (2,535,491) | - |
| **Эцсийн үлдэгдэл** | **8,364,392** | **4,974,218** |

НЭГДСЭН ГҮЙЦЭТГЭЛ МОНГОЛИЯ ХХК
ХУУДАС 30

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 12. БУСАД ХӨРӨНГӨ

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| Бусад авлага | 32,694,115 | 1,368,267 |
| Бусад урьдчилгаа төлбөрүүд | 956,222 | 604,801 |
| Дампуурсан компанийн авлага | 9,351,175 | - |
| Хангамжийн материал | 12,669 | 18,570 |
| **Нийт бусад хөрөнгө** | **43,014,181** | **1,991,638** |
| Хасах: Бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан | (10,453,481) | (433,806) |
| **Цэвэр бусад хөрөнгө** | **32,560,700** | **1,557,832** |

**Бусад авлагын үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан**

Бусад авлагад байгуулсан үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн хөдөлгөөнийг харуулав:

| *Мянган төгрөгөөр* | 2023 | 2022 |
|---|---|---|
| Эхний үлдэгдэл | 433,806 | 2,454,176 |
| Тайлант жилд байгуулсан | 1,011,720 | 34,785 |
| Тайлант жилд буцаасан | (158,757) | (2,061,541) |
| Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжаас дахин ангилсан | 9,165,090 | - |
| Гадаад валютын ханшийн зөрүү | 1,622 | 6,386 |
| **Эцсийн үлдэгдэл** | **10,453,481** | **433,806** |

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 31

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 13. ҮНДСЭН ХӨРӨНГӨ БОЛОН БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Группийн үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн дансны үнийн хөдөлгөөн нь дараах байдалтай байна:

| *Мянган төгрөгөөр* | Барилга, байгууламж | Тоног төхөөрөмж | Тавилга, эд хогшил | Тээврийн хэрэгсэл | Нийт үндсэн хөрөнгө | Программ хангамж, лиценз | Нийт хөрөнгө |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдөрөөрх өртөг | 27,731,006 | 1,714,263 | 812,742 | 1,326,763 | **31,584,774** | 1,870,813 | **33,455,587** |
| Хуримтлагдсан элэгдэл/ хорогдол | (3,926,633) | (1,267,101) | (432,315) | (823,990) | **(6,450,039)** | (1,435,713) | **(7,885,752)** |
| **2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдөрөөрх дансны үнэ** | **23,804,373** | **447,162** | **380,427** | **502,773** | **25,134,735** | **435,100** | **25,569,835** |
| Нэмэгдсэн | - | 21,064 | - | - | **21,064** | 1,559 | **22,623** |
| Элэгдэл/ хорогдуулгын зардал | (693,275) | (257,950) | (73,369) | (87,447) | **(1,112,041)** | (122,874) | **(1,234,915)** |
| Борлуулсан хөрөнгийн өртөг | - | (706) | (8,862) | (393,200) | **(402,768)** | - | **(402,768)** |
| Борлуулсан хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл | - | - | 6,536 | 308,747 | **315,283** | - | **315,283** |
| Данснаас хассан хөрөнгийн өртөг | - | (7,992) | - | - | **(7,992)** | (34,665) | **(42,657)** |
| Данснаас хассан хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл/ хорогдол | - | 7,226 | - | - | **7,226** | 34,665 | **41,891** |
| **2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөрх дансны үнэ** | **23,111,098** | **208,804** | **304,732** | **330,873** | **23,955,507** | **313,785** | **24,269,292** |
| 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөрх өртөг | 27,731,006 | 1,726,629 | 803,880 | 933,563 | **31,195,078** | 1,837,707 | **33,032,785** |
| Хуримтлагдсан элэгдэл/ хорогдол | (4,619,908) | (1,517,825) | (499,148) | (602,690) | **(7,239,571)** | (1,523,922) | **(8,763,493)** |
| **2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөрх дансны үнэ** | **23,111,098** | **208,804** | **304,732** | **330,873** | **23,955,507** | **313,785** | **24,269,292** |
| Нэмэгдсэн | 1,208,000 | 92,499 | 14,135 | - | **1,314,634** | - | **1,314,634** |
| Элэгдэл/ хорогдуулгын зардал | (692,023) | (170,831) | (69,731) | (58,761) | **(991,346)** | (64,115) | **(1,055,461)** |
| Шилжүүлсэн хөрөнгийн өртөг | - | - | (2,739) | (46,843) | **(49,582)** | - | **(49,582)** |
| Шилжүүлсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл | - | - | 2,739 | 46,843 | **49,582** | - | **49,582** |
| **2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөрх дансны үнэ** | **23,627,075** | **130,472** | **249,136** | **272,112** | **24,278,795** | **249,670** | **24,528,465** |
| 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөрх өртөг | 28,939,006 | 1,819,128 | 815,276 | 886,720 | **32,460,130** | 1,837,707 | **34,297,837** |
| Хуримтлагдсан элэгдэл/ хорогдол | (5,311,931) | (1,688,656) | (566,140) | (614,608) | **(8,181,335)** | (1,588,037) | **(9,769,372)** |
| **2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөрх дансны үнэ** | **23,627,075** | **130,472** | **249,136** | **272,112** | **24,278,795** | **249,670** | **24,528,465** |

Групп нь 2023 болон 2022 онд Засгийн газрын Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу төрийн өмчит компаниудад автомашин шилжүүлсэн.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 32

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 14. ХАРИЛЦАГЧДЫН ХАРИЛЦАХ

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| Харилцагчдын харилцах данс | 8,815,342 | 4,798,957 |

Харилцагчдын харилцах дансыг Банкны харилцагчдад зээл олгох болон зээлийн эргэн төлөлтийн төлбөр тооцоонд голлон ашигладаг. Эдгээр харилцах дансанд хүү төлдөггүй. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх харилцагчдын харилцах нь 10 данснаас бүрдсэн (2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр: 48 данс).

Харилцах дансуудыг эдийн засгийн салбараар нь харуулбал:

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| - Цахилгаан, эрчим хүч | 4,973,859 | 675,790 |
| - Үйлдвэрлэл | 3,834,307 | 4,075,484 |
| - Барилга | 6,736 | 7,120 |
| - Уул уурхай, олборлолт | 439 | 289 |
| - Хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон загас агнуур | 1 | 40,001 |
| - Тээвэр, логистикийн үйл ажиллагаа | - | 181 |
| - Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | - | 92 |
| **Нийт харилцах дансны үлдэгдэл** | **8,815,342** | **4,798,957** |

## 14.1 ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖ

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| Хугацаатай хадгаламж | 34,123,720 | - |

Банк Евро бондын эргэн төлөлтийг төлөхийн тулд Эрдэнэс таван толгой ХК-аас 3 сар хүртэл хугацаатай хадгаламж татсан ба хүүгийн түвшин нь 6% байна.

КЕРСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
Хуудас

33

## 15. БУСАД ӨР ТӨЛБӨР

| *Мянган төгрөгөөр* | **2023 оны 12 дугаар сарын 31** | **2022 оны 12 дугаар сарын 31** |
|---|---|---|
| Бусад санхүүгийн өр төлбөр | | |
| Түрээслэх зорилгоор худалдан авсан хөрөнгийн өглөг | 5,172 | 5,568 |
| Баталгааны барьцаа | 1,067,480 | 1,095,074 |
| Банк хоорондын тооцоо | 789,505 | 140 |
| Өмчлөх бусад хөрөнгийн бусад өр төлбөр | 120,175 | 120,175 |
| Бусад | 1,468,729 | 874,542 |
| Техникийн туслалцааны гэрээний өр төлбөр | 734,955 | 1,464,781 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 11,276 | 17 |
| **Нийт бусад өр төлбөр** | **4,197,292** | **3,560,297** |

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх өмчлөх бусад хөрөнгөтэй холбоотой бусад өр төлбөрт өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн барилгын ажлыг дуусгахтай холбоотойгоор 120.2 сая төгрөгийн зардал багтсан, Тодруулга 11.1-ийг харна уу (2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр: 120.2 сая төгрөг).

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх техникийн туслалцааны гэрээний өр төлбөрт Ди Би Эм Ассет Менежмент ХХК-ийн Азийн Хөгжлийн Банкны "Улаанбаатар хотын орлогод нийцсэн орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл" төслийн хүрээнд "Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан" байгуулах, удирдах, ажилчдын чадавхыг бэхжүүлэх үйлчилгээ үзүүлэх 735 сая төгрөгийн (2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр: 1.5 тэрбум төгрөгийн) өр төлбөр багтаж байна.

## 16. БУСАД БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ

| *Мянган төгрөгөөр* | **2022 оны 12 дугаар сарын 31** | **2022 оны 12 дугаар сарын 31** |
|---|---|---|
| Бусад банкуудаас байршуулсан богино хугацаат хөрөнгө | 225,210,272 | 29,583,716 |

Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан хөрөнгөнд 3 сар хүртэл хугацаатай хадгаламжууд орсон бөгөөд хүүгийн түвшин нь 6%–15% байна (2022 онд: 2.9%-7.1%).

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 34

## 17. ӨРИЙН БИЧИГ

Өрийн бичиг нь дараах байдалтай байна:

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| **Монгол Улсын Засгийн Газрын баталгаатай:** | | |
| 2023 он хүртэлх, 30 тэрбум иений өрийн бичиг | - | 768,694,998 |
| **Баталгаагүй:** | | |
| 2023 он хүртэлх, 500 сая ам.долларын өрийн бичиг | - | 1,579,360,788 |
| 2024 он хүртэлх, 142.5 тэрбум төгрөгийн хаалттай өрийн бичиг | 145,231,182 | 145,231,182 |
| 2025 он хүртэлх, 76.5 тэрбум төгрөгийн хаалттай өрийн бичиг | 79,071,313 | 78,918,252 |
| 2027 он хүртэлх, 346 тэрбум төгрөгийн хаалттай өрийн бичиг | 353,710,744 | - |
| Монголбанк болон дотоодын арилжааны банкуудад гаргасан өрийн бичиг | 109,464,589 | - |
| **Нийт гаргасан өрийн бичиг** | **687,477,828** | **2,572,205,220** |

2021 оны 10 дугаар сард Групп 142,458 сая төгрөгийн хаалттай өрийн бичгийг Монголын биржийн бус зах зээлд гаргасан. Энэхүү өрийн бичиг нь Монгол Улсын зах зээлд гаргасан хамгийн том өрийн бичиг байсан. Групп нь 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр төгрөгийн үнэт цаасны 2 дахь транч болох 76,531 сая төгрөгийг 2025 оны 4 дүгээр сард төлөх нөхцөлтэйгээр, Монголын биржийн бус зах зээл дээр амжилттай гаргасан.

2023 оны 5 дугаар сард Групп 260,073 сая төгрөгийн хаалттай өрийн бичгийг гаргасан. 2023 оны 6 дугаар сард төгрөгийн үнэт цаасны 2 дахь транч болох 85,935 сая төгрөгийг 2027 оны 5 дугаар сард төлөх нөхцөлтэйгээр амжилттай арилжаалсан.

2023 оны 12 дугаар сард Групп дотоодын арилжааны банкнуудад нийт 32 сая ам.долларын үнэт цаасыг 2025 оны 12 сард төлөх нөхцөлтэйгээр арилжаалсан.

2023 онд Групп Олон улсын зах зээлд гаргасан 30 тэрбум иений өрийн бичиг болон 500 сая ам.долларын өрийн бичгийг бүрэн төлж барагдуулсан.

ДЕЛОЙТ ОНОН АУДИТ ХХК
ХУУДАС 35

***Монгол Улсын Хөгжлийн Банк***
***Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31***
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 18. БУСДААС АВСАН ЗЭЭЛ

Бусдаас авсан зээл нь дараах байдалтай байна:

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| Гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас авсан зээл: | | |
| **Баталгаагүй:** | | |
| ВЕБ.РФ | 170,819,236 | 163,345,620 |
| Хятадын Хөгжлийн Банк | 106,689,216 | 33,357,059 |
| Монголбанк | 429,893,260 | 385,837,926 |
| **Бусдаас авсан нийт зээлийн дүн** | **707,401,712** | **582,540,605** |

**ВЭБ.РФ.** Групп нь 2015 оны 6 дугаар сард Дулааны IV Цахилгаан Станц ТӨХК-ийн (ДЦС-4) өргөтгөлийн төслийг санхүүжүүлэх зорилгоор ОХУ-ын төрийн өмчит "Гадаад эдийн засаг болон хөгжлийн асуудал эрхэлсэн банк" (ВЭБ.РФ)-аас 20 сая ам.долларын эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн. 2017 оны 10 дугаар сард Групп нь ОХУ-аас хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж авах зорилгоор тус банкнаас хоёр дахь санхүүжилт болох 1.5 сая ам.доллар болон 8.5 сая ам.долларыг 5 жилийн хугацаатай, тогтмол хүүтэйгээр татан төвлөрүүлсэн.

2018 оны 10 дугаар сард Групп нь хоёр талын хэлэлцээрээр дахин 4 зээлийн гэрээг ВЭБ.РФ банктай байгуулсан. Эдгээр зээлүүдийн зорилго нь Дулааны IV Цахилгаан Станц ТӨХК-ийн (ДЦС-4) өргөтгөл болон хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж худалдан авахад шаардлагатай санхүүжилтийг дахин санхүүжүүлэх зорилготой. Эдгээр зээлүүдийн дуусах хугацаа нь 2024 оны 4 дүгээр сар болон 2026 оны 10 дугаар сар байна.

Групп нь 2019 оны 6 дугаар сард хоёр талын хэлэлцээрээр 16.4 сая евро болон 2.9 сая еврогийн 2 зээлийн гэрээг ВЭБ.РФ банктай байгуулсан. Эдгээр зээлийн дуусах хугацаа 2026 оны 7 дугаар сар болон 2025 оны 6 дугаар сар байна. Эдгээр зээлүүд нь Дулааны IV Цахилгаан Станц ТӨХК-ийн (ДЦС-4) өргөтгөлийн ажлын нэмэлт санхүүжилтийг дахин санхүүжүүлэх зорилготой.

**Хятадын Хөгжлийн Банк.** Групп нь 2020 онд Чойбалсангийн Дулааны Цахилгаан Станц төслийг санхүүжүүлэх зорилгоор Хятадын Хөгжлийн Банктай зээлийн гэрээ байгуулан нийт 420 сая юанийн санхүүжилтийг 10 жилийн хугацаатай, тогтмол хүүтэйгээр татан төвлөрүүлэх зээлийн гэрээг байгуулсан. Банк нь төслийн санхүүжилттэй уялдуулан зээлийн гэрээний хүрээнд 44.2 сая юанийг 2021 оны 10 дугаар сард, 25.6 сая юанийг 2022 оны 5 дугаар сард, 11.3 сая юанийг 2023 оны 3 дугаар сард, 145.1 сая юанийг 2023 оны 11 дүгээр сард тус тус татсан бөгөөд нийт 226.6 сая юанийн олголт авсан байна.

**Монголбанк.** Групп нь 2022 онд Монголбанктай тогтмол хүүтэй барьцаат зээлийн гэрээ байгуулсан бөгөөд барьцаа нь Монгол Улсын Засгийн газраас 2022 онд гаргасан 387.8 тэрбум төгрөгийн дансны үнэ бүхий үнэт цаас ба үүнийг дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаасаарх хөрөнгө оруулалт хэсэгт тодруулсан (Тодруулга 10.1-г харна уу). Уг зээлийг 2023 онд бүрэн хаасан.

Групп нь 2023 оны 12 дугаар сард Монголбанктай хэвийн зээлийн багцаа барьцаалан 429.0 тэрбум төгрөгийн 3 сарын хугацаатай барьцаат зээлийн гэрээ байгуулсан.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 36

## 18. БУСДААС АВСАН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Зээлийн шалгуур үзүүлэлтүүд.** ВЭБ.РФ банк болон Хятадын Хөгжлийн банктай байгуулсан зээлийн гэрээ нь Группийн санхүүгийн тайлан болон бусад мэдээлэлтэй холбоотой хэд хэдэн санхүүгийн шалгуур үзүүлэлтийг агуулсан байдаг ба эдгээрт дараах зүйлс орно:

- Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч агентлагаас гаргасан зээлжих зэрэглэл
- Хөрөнгийн зохистой харьцаа
- Тогтвортой эх үүсвэрийн харьцаа
- Чанаргүй зээлийн харьцаа
- Цэвэр нээлттэй позиц
- Нээлттэй зээлийн харьцаа

2023 болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дээр дурдсан зарим гэрээнүүдэд заагдсан харьцаа үзүүлэлт хангагдаагүй байна.

Одоогийн байгаа зээлийн гэрээнүүдийн дагуу шалгуур үзүүлэлт хангаагүй шалтгаанаар нэг зээлдэгч торгуулийн хүү ногдуулж, хоёр зээлдэгч зээлийн дефолт үүссэн гэж нэхэмжлэл гаргаж болох нөхцөл үүссэн байна. Гэсэн хэдий ч уг тайлан гарах өдрөөр зээлдэгчид торгуулийн хүү ногдуулсан эсвэл зээлийн дефолт үүссэн гэж нэхэмжлэл гаргаагүй байна.

### 18.1 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ҮҮССЭН ӨР ТӨЛБӨРИЙН ТОХИРУУЛГА

Доорх хүснэгт нь Группийн санхүүгийн мөнгөн болон мөнгөн бус үйл ажиллагааны өөрчлөлтөөс үүссэн өр төлбөрийн тохируулгыг харуулж байна. Өнгөрсөн мөнгөн урсгал болон ирээдүйн мөнгөн урсгалын санхүүгийн үйл ажиллагаанаас үүсэх өр төлбөрийг Группийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд тусгана.

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн өр төлбөрийн хөдөлгөөнийг харуулав:

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр | Санхүүгийн мөнгөн гүйлгээ: Орох урсгал | Санхүүгийн мөнгөн гүйлгээ: Гарах урсгал | Ханшийн зөрүү Ханшийн зөрүү | Бусад өөрчлөлт (i) Бусад өөрчлөлт (i) | 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр |
|---|---|---|---|---|---|---|
| Өрийн бичиг | 2,572,205,220 | 455,359,860 | (2,327,858,348) | (209,280) | (12,019,624) | 687,477,828 |
| Бусдаас авсан зээл | 582,540,605 | 503,373,558 | (383,576,833) | 4,016,772 | 1,047,610 | 707,401,712 |

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн өр төлбөрийн хөдөлгөөнийг харуулав:

| *Мянган төгрөгөөр* | 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр | Санхүүгийн мөнгөн гүйлгээ: Орох урсгал | Санхүүгийн мөнгөн гүйлгээ: Гарах урсгал | Ханшийн зөрүү Ханшийн зөрүү | Бусад өөрчлөлт (i) | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр |
|---|---|---|---|---|---|---|
| Өрийн бичиг | 2,339,648,455 | 76,530,500 | (221,541,653) | 337,800,000 | 39,767,918 | 2,572,205,220 |
| Бусдаас авсан зээл | 619,349,154 | 393,913,277 | (465,495,472) | 23,658,814 | 11,114,832 | 582,540,605 |

(i) Бусад өөрчлөлтүүд нь хуримтлагдсан хүүгийн хөдөлгөөн болно.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 37

## 19. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Холбоотой талууд болон холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээг НББОУС 24 "Холбоотой талуудын тодруулга" стандартад заасны дагуу үнэлдэг. Тодруулга 1-д дурдсанаар Группийг Монгол Улсын Засгийн газар 100% эзэмшдэг бөгөөд үндсэн үйл ажиллагаа нь Монгол Улс дахь төслүүдийг санхүүжүүлэх юм. Тиймээс Групп нь Монгол Улсын Засгийн Газрын эзэмшлийн үр дүнд холбоотой талуудтай ажил гүйлгээнүүдийг хийдэг. НББОУС 24 "Холбоотой талуудын тодруулга"-ын дагуу Группийн бусад холбоотой талуудад Монгол Улсын Засгийн газар хяналттай, хамтарсан хяналттай болон мэдэгдэхүйц нөлөө бүхий төрийн өмчийн компаниуд болон бусад байгууллагууд багтдаг.

Үйл ажиллагааны онцлогоос хамаараад Групп нь Монгол Улсын Засгийн газар болон бусад холбоотой талуудтай материаллаг хэмжээний ажил гүйлгээнүүдийг хийдэг бөгөөд үүнд Монгол Улсын Засгийн Газрын гаргасан баталгаа хамаарна. Группийн үйл ажиллагааны орчны мэдээллийг Тодруулга 1-д толилуулсан. Зээлийн үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн түвшинг тодорхойлох удирдлагын үнэлэмжийг Тодруулга 4-өөс харна уу.

Холбоотой талуудын ажил гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доор нэгтгэв.

**Холбоотой талуудад хамаарах хөрөнгө болон ажил гүйлгээ**

Групп дараах холбоотой талуудтай хийсэн гүйлгээнүүд болон үлдэгдлийг тодруулсан:

1. Монгол Улсын Засгийн газар (ЗГ-аас удирдлагыг томилдог Сангийн Яам болон бусад яамдууд багтана),
2. Монгол Улсын Засгийн Газрын хяналттай аж ахуйн нэгжүүд, үүнд төрийн байгууллагууд багтана (жишээ нь корпорацийн аж ахуйн нэгжүүд), дотоодын арилжааны банк (Төрийн Банк ХХК), Төв Банк буюу зохицуулагч байгууллага Монголбанк; эдгээр аж ахуйн нэгжүүд нь Групптэй нэгдсэн хяналтанд байдаг аж ахуйн нэгжүүд юм,
3. Бусад холбоотой талууд, Монголын Ипотекийн Корпораци ХХК (МИК, Монгол Улсын Засгийн газар их хэмжээний нөлөө үзүүлдэг байгууллага). Группийн МИК-тэй холбоотой дансны үлдэгдэл нь бодит үнэ цэнээр хэмжигдсэн борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас юм.

ЭРНСТ ЭНД ЯНГ
МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 38

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 19. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Группийн холбоотой талуудын эзэмшиж буй хөрөнгө болон өр төлбөр (зээл ба урьдчилгаа багтаагүй), тэдгээртэй хийсэн ажил гүйлгээний шинжилгээг доор толилуулав:

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31<br>Санхүүгийн байдлын тайлан | 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дууссавар болсон тайлант жил<br>Дэлгэрэнгүй орлогын тайлан | 2022 оны 12 дугаар сарын 31<br>Санхүүгийн байдлын тайлан | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил<br>Дэлгэрэнгүй орлогын тайлан |
|---|---|---|---|---|
| Сангийн яаманд байршуулсан харилцах (Тодруулга 6) | 1,592,551 | - | 794,694,877 | - |
| Монголбанкинд байршуулсан харилцах (Тодруулга 6) | 104,397,326 | 2,931,565 | 57,588,066 | 4,330,282 |
| Төрийн банкинд байршуулсан харилцах (Тодруулга 6) | 683,700 | 99,433 | 4,366,482 | 1,423,533 |
| Төрийн банкинд байршуулсан хугацаатай мөнгөн хадгаламж (Тодруулга 7) | 300,444 | 64,407 | 13,725,085 | 438 |
| Ажилтнуудын тэтгэмжид зориулсан Төрийн банк дахь харилцах данс | 2,774 | - | 120,554 | - |
| Монголбанктай хийсэн гэрээгээрх үүсмэл санхүүгийн хэрэглүүр (Тодруулга 8) | - | (49,916,571) | 21,753,965 | (120,225,048) |
| Бодит үнэ цэнээр хэмжсэн борлуулахад бэлэн хөрөнгө (Тодруулга 9)-ЗГ-ын үнэт цаас | - | 79,487 | 4,901,671 | 339,125 |
| Бодит үнэ цэнээр хэмжсэн борлуулахад бэлэн хөрөнгө (Тодруулга 9)-МИК Холдинг ХК | 67,803,010 | - | 62,440,408 | - |
| Борлуулахад бэлэн хөрөнгө (Тодруулга 9)-Эрдэнэс Таван толгой ХК | 144,380,184 | 24,080,438 | 222,139,635 | 22,096,109 |
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаасаарх хөрөнгө оруулалт (Тодруулга 9)- ЗГ-ын үнэт цаас | - | 26,449,247 | 387,826,553 | 3,966,553 |
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаасаарх хөрөнгө оруулалт (Тодруулга 9)- Улсын байгууллагууд | 180,962,377 | 15,342,500 | 180,962,377 | 462,377 |
| Тариалан Эрхлэлтийг Дэмжих Сан | 31,853,034 | - | - | - |
| Улсын байгууллагуудын харилцах данс (Тодруулга 14) | (8,746,735) | - | (4,679,121) | - |
| Хугацаат хадгаламж – Эрдэнэс Таван толгой ХК (Тодруулга 14.1) | (34,123,720) | (1,033,428) | - | - |
| Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанд өгөх гэрээний өр төлбөр (Тодруулга 11.1) | (8,293) | 2,714,192 | (72,647) | 5,025,264 |
| Хөвсгөл аймгийн ЗДТГ-т өгөх гэрээний өр төлбөр (Тодруулга 11.1) | (178,923) | 150,254 | (344,203) | - |
| Говь-Алтай аймгийн ЗДТГ-т өгөх гэрээний өр төлбөр (Тодруулга 11.1) | (2,310,185) | 1,338 | (1,110,185) | 869,197 |
| Орхон аймгийн ЗДТГ-т өгөх гэрээний өр төлбөр (Тодруулга 11.1) | (1,330,931) | 2,058,579 | (2,325,715) | 596,067 |
| Бусад банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан богино хугацаат хөрөнгө – Сангийн яам (Тодруулга 16) | (100,391,781) | (391,781) | - | - |
| Монголбанкнаас авсан зээл (Тодруулга 18) | (429,893,260) | (28,493,119) | (385,837,926) | (3,892,702) |

Өр төлбөр болон зардлын дансуудыг хаалтанд харуулав.

КЕРСНА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
39
ХУУЛАС

***Монгол Улсын Хөгжлийн Банк***
***Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31***
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 19. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Холбоотой талуудад олгосон зээл ба урьдчилгаа

Группийн холбоотой талуудад олгосон зээл ба урьдчилгааны дэлгэрэнгүй дараах байдалтай байна. Ямдаас бусад, доор харуулсан бүх байгууллагууд нь Групптэй нэгдсэн нэг хяналтад байдаг төрийн өмчит байгууллагууд юм.

| | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил | 2022 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил |
|---|---|---|---|---|
| *Мянган төгрөгөөр* | Санхүүгийн байдлын тайлан | Дэлгэрэнгүй орлогын тайлан | Санхүүгийн байдлын тайлан | Дэлгэрэнгүй орлогын тайлан |
| - Төрийн Орон Сууцны Корпораци | 25,649,932 | - | 25,649,932 | (5,714,715) |
| - "ДЦС-4" ТӨХК | 268,237,422 | 12,667,495 | 278,866,454 | 11,486,360 |
| - Монгол Газрын Тос Боловсруулах Үйлдвэр ТӨХК | 255,659,982 | 21,525,654 | 229,128,668 | 19,306,163 |
| - Эрдэнэс МГЛ ХХК | - | 2,984,683 | 42,871,586 | 11,376,410 |
| - Таван Толгойн Цахилгаан Станц | 60,919,705 | 3,188,736 | 58,356,011 | 2,888,901 |
| - Эгийн Голын Цахилгаан Станц | 59,986,141 | 4,297,689 | 56,310,945 | 3,893,580 |
| - Тариалан Эрхлэлтийг Дэмжих Сан | - | 2,418,877 | 54,940,959 | 2,080,834 |
| - Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем ТӨХК | 109,263,993 | 3,693,275 | 35,238,526 | 2,151,519 |
| - Зорчигч Тээвэр Гурав | 4,501,543 | 930,527 | 11,252,500 | 1,764,245 |
| - МИАТ ХК | - | - | - | 655,723 |
| - Цагдаагийн Ерөнхий Газар | 604,549 | 28,336 | 745,347 | 34,782 |
| - Шивээ Овоо ХК | 483,844 | 24,139 | 586,253 | 28,603 |
| - Батлан Хамгаалахын Яам | 234,217 | 14,419 | 367,318 | 17,907 |
| - Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар | 240,606 | 11,996 | 289,052 | 14,113 |
| - Ерөнхий Прокурорын Газар | 114,757 | 5,901 | 137,750 | 6,991 |
| - Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем ХК | 109,563 | 5,501 | 134,293 | 6,582 |
| - Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар | 103,388 | 5,562 | 131,127 | 6,768 |
| - Амгалан Дулааны Станц ТӨХК | 29,459,349 | 1,125,370 | - | - |
| **Холбоотой талуудад олгосон нийт зээл ба урьдчилгаа** | **815,568,991** | **52,928,160** | **795,006,721** | **50,004,766** |
| Холбоотой талуудад олгосон нийт зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан: | (65,063,227) | 2,627,283 | (67,690,510) | 125,321,138 |
| **Холбоотой талуудад олгосон цэвэр зээл ба урьдчилгаа** | **750,505,764** | | **727,316,211** | |

2023 болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх гол удирдлага (Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын баг)-ийн цалин хөлс ба урамшуулалд 1,116 сая төгрөг ба 1,202 сая төгрөгийг тус тус олгосон.

2018 онд Групп нь Төрийн Орон Сууцны Корпораци ТӨХК-аас зээлийн үүргийн оронд баригдаж буй барилгуудыг өмчлөх бусад хөрөнгө болгон хүлээн авсан, Тодруулга 11.1-ийг харна уу.

2022 онд Групп нь Хан-Уул дүүрэгт байрлах (Шинэ яармаг хаусинг төсөл)-ийн 84,437 сая төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгүүдийг Төрийн Орон Сууцны Корпораци ТӨХК-аас авах зээлийн үүрэгт хүлээн авсан бөгөөд дэлгэрэнгүйг Тодруулга 11.1-с харна уу.

2022 оны 12 сард Групп нь Төрийн Орон Сууцны Корпораци ТӨХК-иас гаргасан хаалттай бондыг зээлийн үүрэгт хүлээн авсан бөгөөд дэлгэрэнгүйг Тодруулга 10.1-с харна уу.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК ХУУДАС

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 19. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Хүлээн авсан баталгаа**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банканд хүлээн авсан баталгаа байхгүй. Монгол Улсын Засгийн Газрын батлан даалттай 30 тэрбум иенийн бондыг 2023 онд бүрэн төлж барагдуулсан. Дэлгэрэнгүйг Тодруулга 17 болон 18-аас харна уу.

**Гаргасан баталгаа**

2020 онд Групп нь Эрдэнэс МГЛ ХХК болон Эрдэнэс Силвер Ресурс ХХК-тай санхүүгийн баталгааны гэрээ байгуулсан ба эдгээр компаниудын гаргасан бондод 1,146 тэрбум төгрөгийн санхүүгийн баталгааг гаргасан. Тодруулга 31-с дэлгэрэнгүйг харна уу.

## 20. ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Группийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хуульд зааснаар Монгол Улсын Засгийн Газраас оруулсан хувь оролцооноос бүрдэнэ. Банкны эрх бүхий хувьцаа нь дор тодруулсан хувь нийлүүлсэн хөрөнгөтэй тэнцүү юм.

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| Батлагдсан: | | |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө, 12 дугаар сарын 31-ны өдрөөрх | 1,216,300,341 | 1,216,300,341 |
| Төлөгдсөн: | | |
| 01 дүгээр сарын 01-ний өдрөөр | 1,216,300,341 | 1,216,300,341 |
| Тайлант хугацаанд нэмэгдсэн | - | - |
| **Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө, 12 дугаар сарын 31-ны өдрөөрх** | **1,216,300,341** | **1,216,300,341** |

## 21. ХҮҮГИЙН ОРЛОГО

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил |
|---|---|---|
| Зээл, урьдчилгаа ба түрээсийн авлага | 104,418,185 | 219,662,119 |
| Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж | 3,951,142 | 7,472,074 |
| Хорогдуулсан өртгөөр хэмжсэн дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаасаарх хөрөнгө оруулалт | 41,791,747 | 4,428,930 |
| Бодит үнэ цэнээр хэмжсэн борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт | 32,777,635 | 31,540,591 |
| ААБҮЦ-ээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө | 2,349,796 | 2,428,593 |
| Засгийн газарт байршуулсан хөрөнгө | 79,487 | 339,124 |
| **Нийт хүүгийн орлого** | **185,367,992** | **265,871,431** |

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 41

***Монгол Улсын Хөгжлийн Банк***
***Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31***
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 22. ХҮҮГИЙН ЗАРДАЛ

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил |
|---|---|---|
| Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл | 6,044,417 | 23,908,295 |
| Монголбанкнаас авсан зээл | 28,493,119 | 3,892,702 |
| Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан хөрөнгө | 3,610,440 | 1,271,935 |
| Японы хөрөнгийн зах зээлд гаргасан 2023 онд дуусгавар болох өрийн бичиг | 24,764,231 | 23,880,107 |
| Олон улсын зах зээлд гаргасан 2023 онд дуусгавар болох өрийн бичиг | 89,815,706 | 119,838,372 |
| Дотоодын арилжааны банкуудад гаргасан өрийн бичиг | 341,730 | 203,288 |
| Хугацаат хадгаламж | 1,033,428 | - |
| Биржийн бус зах зээлд гаргасан 2024 онд дуусгавар болох өрийн бичиг | 13,865,912 | 13,865,912 |
| Биржийн бус зах зээлд гаргасан 2025 онд дуусгавар болох өрийн бичиг | 12,646,665 | 7,262,744 |
| Биржийн бус зах зээлд гаргасан 2027 онд дуусгавар болох өрийн бичиг | 34,477,898 | - |
| Бусад | 819 | - |
| **Нийт хүүгийн зардал** | **215,094,365** | **194,123,355** |

## 23. БУСАД ОРЛОГО

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил |
|---|---|---|
| Торгуулийн орлого | 215,148 | 2,360,797 |
| Буцалтгүй тусламжийн орлого (Тодруулга 12) | - | 33,799 |
| Өмчлөх бусад хөрөнгө борлуулсны олз | 5,099,949 | 6,495,483 |
| Биет хөрөнгө данснаас хассаны олз | 1,419 | 3,180 |
| Бусад | 89,774 | 12,591 |
| **Нийт бусад орлого** | **5,406,290** | **8,905,850** |

**Торгуулийн орлого:** Групп нь дотоодын арилжааны банкуудад байршуулсан байсан банкны хадгаламжуудаа дуусах хугацаанаас өмнө эргүүлэн татсан. Үүнтэй холбоотой арилжааны банкуудаас бэлэн мөнгө авах хугацаа хойшлогдсон тул торгуулийн орлогыг гэрээний нөхцөлийн дагуу эдгээр арилжааны банкуудаас авахаар тооцсон.

**Өмчлөх бусад хөрөнгөтэй холбоотой олз:** Групп нь өмчлөх бусад хөрөнгөтэй холбоотойгоор хэдөө орон нутгийн захирагчийн газруудаас олз хүлээн зөвшөөрсөн. Тодруулга 11.1-с дэлгэрэнгүйг харна уу.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК ХУУДАС

## 24. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ТЭГШИТГЭЛИЙН ОЛЗ БОЛОН ГАРЗ, ЦЭВЭР

Ашиг, алдагдлын тайланд тусгасан гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зөрүү дараах байдалтай байна.

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил |
|---|---|---|
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй цэвэр ашиг | 182,844,023 | 332,868,213 |
| Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй цэвэр (алдагдал) | (257,389,709) | (467,887,204) |
| **Ханшийн тэгшитгэлийн (гарз)/ олз, цэвэр** | **(74,545,686)** | **(135,018,991)** |

Групп нь гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө болон өр төлбөр эзэмшдэг ба эдгээр нь монгол төгрөгийн эсрэг гадаад валютын ханшийн хэлбэлзэлд өртдөг. Групп нь эх ээлийн эрсдэлийг бууруулахын тулд хосолсон стратегиудыг хэрэгжүүлдэг.

## 25. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН ОЛЗ БОЛОН ГАРЗ, НИЙТ

Ашиг, алдагдлын тайланд тусгасан нийт олз/ гарз дараах байдалтай байна.

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил |
|---|---|---|
| Монголбанктай байгуулсан своп хэлцэл | (155,507,455) | (224,077,302) |
| Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай байгуулсан своп хэлцэл | (4,100,484) | (61,523,056) |
| **Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн гарз, нийт** | **(159,607,939)** | **(285,600,358)** |
| Монголбанктай байгуулсан своп хэлцэл | 105,590,884 | 366,560,354 |
| Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай байгуулсан своп хэлцэл | 39,897,268 | 7,763,454 |
| **Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн олз, нийт** | **145,488,152** | **374,323,808** |

Групп нь үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн олз, гарзыг сар бүр хүлээн зөвшөөрдөг ба хийгдсэн своп хэлцлийн дуусгавар хугацаанаас өмнө хэрэгжсэн хэсгийг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг. Үнэлгээ нь санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээний цэвэр өөрчлөлтийг үүсгэж буй Монгол төгрөгтэй харьцах ханшийн өөрчлөлт, индекс, ханшийн хэлбэлзлээс хамаарч байна.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 43

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 25. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН ОЛЗ БОЛОН ГАРЗ, НИЙТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил |
|---|---|---|
| Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэрэгжсэн ашиг | 50,185,779 | 262,708,100 |
| Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэрэгжсэн (алдагдал) | - | (55,850,227) |
| Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэрэгжээгүй ашиг | 95,302,372 | 111,615,708 |
| Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэрэгжээгүй (алдагдал) | (159,607,938) | (229,750,131) |
| **Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн (гарз)/ олз, цэвэр** | **(14,119,787)** | **88,723,450** |

2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Монголбанктай байгуулсан дөрвөн урт хугацаат своп хэлцлийн дагуу нийт 325 сая ам.долларын своп хэлцлийн хугацаа дуусгавар болж, 15,834 сая төгрөгийн цэвэр олз олсон. Түүнчлэн Саксо Банктай байгуулсан арван нэгэн форвард хэлцлийн хугацаа 2023 онд дуусгавар болж, 34,352 сая төгрөгийн цэвэр олз хүлээсэн.

## 26. УДИРДЛАГЫН БОЛОН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Группийн удирдлагын болон үйл ажиллагааны бусад зардал дараах байдалтай байна.

| *Мянган төгрөгөөр* | Тод-руулга | 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил |
|---|---|---|---|
| Цалин хөлс, тэтгэмж | | 7,876,168 | 6,750,206 |
| Аудит, хууль, бусад мэргэжлийн үйлчилгээ | | 2,395,166 | 1,297,216 |
| Элэгдэл, хорогдол | 13 | 1,055,461 | 1,234,915 |
| Мэдээллийн технологи, програм хангамж | | 620,780 | 554,019 |
| Ашиглалт, засвар үйлчилгээ, харуул хамгаалалт | | 367,504 | 195,756 |
| Зээл цуглуулахтай холбоотой зардал | | 350,310 | 431,768 |
| Албан томилолт | | 315,827 | 198,950 |
| Хөрөнгийн татварын зардал | | 275,981 | 275,981 |
| Харилцаа холбоо бичиг хэрэг | | 213,202 | 195,195 |
| Зар сурталчилгаа | | 186,539 | 188,624 |
| Шатахуун болон тээврийн зардал | | 26,929 | 50,506 |
| Бага дүнтэй, богино хугацаат түрээсийн зардал | | 25,598 | 168,892 |
| Сургалтын зардал | | 23,569 | 20,783 |
| Даатгалын зардал | | 3,845 | 9,284 |
| Данснаас хассантай холбоотой алдагдал | | - | 84,453 |
| Бусад | | 100,589 | 84,346 |
| **Нийт үйл ажиллагааны зардал** | | **13,837,468** | **11,740,894** |

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 44

## 27. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Групп нь Монгол Улсын Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын тухай хуулийн дагуу 2020 оныг дуустал 3 тэрбум хүртэлх татвар ногдуулах орлогод 10 хувь, 3 тэрбумаас давсан татвар ногдуулах орлогод 25 хувиар орлогын албан татвар ногдуулна. 2020 оноос эхлэн татварын шинэ хууль тогтоомжийн дагуу 6 тэрбум хүртэлх татвар ногдуулах орлогод 10 хувь, 6 тэрбум төгрөгөөс давсан татвар ногдуулах орлогод 25 хувийн татвар ногдуулна.

Ашиг, алдагдал болон бусад орлогын дэлгэрэнгүй тусгагдсан үргэлжилж буй үйл ажиллагааны орлогын албан татварын зардлыг доор үзүүлэв:

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил |
|---|---|---|
| Тайлант үеийн орлогын албан татварын зардал | 1,023,603 | 27,496,153 |
| Хойшлогдсон татварын зардал/ (хөнгөлөлт) | (78,399) | 6,434,448 |
| **Тайлант үеийн орлогын албан татварын зардал/ (хөнгөлөлт)** | **945,204** | **33,930,601** |

Тооцоолсон болон бодит татварын зардлын тохируулгыг доорх хүснэгтэд харуулав:

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил |
|---|---|---|
| **Татварын өмнөх (алдагдал)/ ашиг** | **(50,403,197)** | **144,212,987** |
| Хуульд заасан хувиар тооцсон татварын зардал | (5,040,320) | 36,053,247 |
| Татвар ногдохгүй орлого, татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын татварын нөлөө: | | |
| - Бага хувиар татвар ногдуулах орлогын нөлөө | (944,980) | (1,800,000) |
| - Татварын зорилгоор хасагдахгүй зардал | 5,002,303 | 3,650,995 |
| - Татвараас чөлөөлөгдөх орлого | (3,454,155) | (4,334,786) |
| - Хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрөөгүй тайлант жилийн татварын алдагдал | (31,075,693) | - |
| - Тайлант үед үүссэн түр зөрүү | 35,103,525 | - |
| - Тусгай хувь хэмжээгээр тооцсон орлогын албан татвар | 151,952 | 176,316 |
| - Ялгаатай хувь хэмжээгээр ногдуулах татвар | 1,202,572 | 184,829 |
| **Тайлант үеийн орлогын албан татварын зардал / (хөнгөлөлт)** | **945,204** | **33,930,601** |

Монгол Улсын Засгийн газар зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш бизнес болон арилжааны дэд бүтцийг шинэчилсээр байгаа. Үүнтэй холбоотойгоор бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхүйц хууль тогтоомж, дүрэм журмууд түүн дотор 2020 оны 01 дүгээр сараас эхлэн өргөн хүрээтэй хэрэгжиж буй татварын хууль тогтоомж хурдацтай өөрчлөгдөн шинэчлэгдэж байна.

Эдгээр өөрчлөлтүүд нь зарим тохиолдолд хуулийн хангалтгүй боловсруулалт, маргаантай тайлбар болон татварын албадын ялгаатай хэрэглээ зэргээс хамаарч бий болдог. Ялангуяа, татварыг хуулийн дагуу торгууль, алданги ногдуулах эрх бүхий олон тооны байгууллагууд хянаж шалгадаг. Групп нь татварын хууль тогтоомжийн талаарх өөрсдийн ойлголт болон тайлант жилийн эцэс дэх санхүүгийн үр дүнд үндэслэн татварын өр төлбөрийг зохистойгоор тооцоолж илэрхийлсэн гэж үзэж байгаа боловч дээрх нөхцөл нь Группт татварын эрсдэлийг үүсгэж болзошгүй ба энэхүү эрсдэлийн тоо хэмжээгээр илэрхийлэх боломжгүй байна.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
Хуудас 45

## 27. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР (ҮРГЭЛЖЛЭЛ)

*Хойшлогдсон татварын хөрөнгө*

СТОУС болон Монгол Улсад үйлчилж буй татварын хуулийн ялгаатай байдал, санхүүгийн тайлагналын зорилгоорх хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ нь татварын зорилгоорх тайлагналын дүнгээс өөр байх тохиолдол гардаг бөгөөд үүнээс шалтгаалан түр зөрүү үүсдэг.

Хасагдах болон татвар ногдох түр зөрүү нь гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн ханшийн тэгшитгэлийн зөрүүнээс үүсдэг ба мөн биет бус хөрөнгийн хувьд татварын алба болон Банкны хорогдуулалтын хувийн ялгаатай байдал, борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас, дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаасаарх хөрөнгө оруулалт болон үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн дахин үнэлгээ, хэвийн зээлийн үнэ цэнийн бууралтын сангаас шалтгаалан хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг (Тодруулга 4).

Хойшлогдсон татварын хөрөнгийн үлдэгдэл 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дараах байдалтай байна:

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 01 дүгээр сарын 01 | Ашиг, эсвэл алдагдалд хүлээн зөвшөөрсөн | Бусад дэлгэрэнгүй орлогод тусгасан | 2023 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|---|
| *Хойшлогдсон татварын (өр төлбөр)/ хөрөнгөнд хамаарах:* | | | | |
| Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж | (8,138,068) | 8,137,792 | - | (276) |
| Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд | 6,357,094 | (6,357,094) | - | - |
| Бодит үнэ цэнээр хэмжсэн борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт | (14,889,192) | 3,287,210 | (1,340,651) | (12,942,633) |
| Зээл ба урьдчилгаа | (101,918,260) | 75,284,515 | - | (26,633,745) |
| Биет бус хөрөнгө | (311,974) | (33,709) | - | (345,683) |
| Бусад хөрөнгө | (3,472) | 3,347 | - | (125) |
| Харилцагчдын харилцах данс | 236,269 | (143,700) | - | 92,569 |
| Бусад өр төлбөр | 176,190 | (127,877) | - | 48,313 |
| Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан хөрөнгө | 624,340 | (287,607) | - | 336,733 |
| Өрийн бичиг | 118,019,538 | (118,040,466) | - | (20,928) |
| Бусдаас авсан зээл | 9,273,303 | (5,179,089) | - | 4,094,214 |
| Татвар ногдох алдагдал | 37,905,975 | 43,535,077 | - | 81,441,052 |
| **Хойшлогдсон татварын хөрөнгө** | **47,331,743** | **78,399** | **(1,340,651)** | **46,069,491** |

ЭРНСТ ЭНД ЯНГ ... МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 46

## 27. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хойшлогдсон татварын хөрөнгийн үлдэгдэл 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дараах байдалтай байна:

| *Мянган төгрөгөөр* | 2022 оны 01 дүгээр сарын 01 | Ашиг, эсвэл алдагдалд хүлээн зөвшөөрсөн | Бусад дэлгэрэнгүй орлогод хаасан | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|---|
| *Хойшлогдсон татварын (өр төлбөр)/ хөрөнгөнд хамаарах:* | | | | |
| Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж | 169,812 | (8,307,880) | - | (8,138,068) |
| Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд | (23,176,511) | 29,533,605 | - | 6,357,094 |
| Бодит үнэ цэнээр хэмжсэн борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт | (8,012,530) | (2,816,186) | (4,060,476) | (14,889,192) |
| Зээл ба урьдчилгаа | (88,791,260) | (20,899,843) | - | (109,691,103) |
| Хэвийн зээлд байгуулсан үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сан | 18,780,520 | (11,007,677) | - | 7,772,843 |
| Биет бус хөрөнгө | (207,983) | (103,991) | - | (311,974) |
| Бусад хөрөнгө | (10,151) | 6,679 | - | (3,472) |
| Харилцагчдын харилцах данс | 148,034 | 88,235 | - | 236,269 |
| Бусад өр төлбөр | 144,915 | 31,275 | - | 176,190 |
| Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан хөрөнгө | (415,966) | 1,040,306 | - | 624,340 |
| Өрийн бичиг | 99,451,250 | 18,568,288 | - | 118,019,538 |
| Бусдаас авсан зээл | 15,496,608 | (6,223,305) | - | 9,273,303 |
| Татвар ногдох алдагдал | 44,249,929 | (6,343,954) | - | 37,905,975 |
| **Хойшлогдсон татварын хөрөнгө** | **57,826,667** | **(6,434,448)** | **(4,060,476)** | **47,331,743** |

Бусад дэлгэрэнгүй орлого дахь хойшлогдсон татварын нөлөө дараах байдалтай байна:

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | | | 2022 оны 12 дугаар сарын 31 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Татварын өмнөх дүн | Хойшлогдсон татварын зардал | Цэвэр дүн | Татварын өмнөх дүн | Хойшлогдсон татварын зардал | Цэвэр дүн |
| **Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас:** | | | | | | |
| - Бодит үнэ цэнийн олз/ (гарз), цэвэр | 16,341,703 | (1,340,651) | 15,001,052 | 8,145,117 | (4,060,476) | 4,084,641 |

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 47

## 28. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

**Танилцуулга ба Ерөнхий тойм**

Групп нь үйл ажиллагаандаа учирч буй эрсдэлүүдийг дараах ерөнхий төрлүүдээр ангилдаг. Үүнд:

- Зээлийн эрсдэл
- Зах зээлийн эрсдэл
- Хөрвөх чадварын эрсдэл
- Үйл ажиллагааны эрсдэл
- Хөрөнгө оруулалтын эрсдэл

Энэхүү тодруулгад дурдсан Группийн эрсдэлүүдийн талаар мэдээлэл болон эрсдэлийн удирдлагын бодлого, журам ба эрсдэлийг хэрхэн үнэлж, удирдах ба хянах үйл ажиллагааг тусгасан болно.

**Эрсдэлийн удирдлагын бодлого**

Группийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Банкны эрсдэлийг тодорхойлох аргачлалыг тогтмол сайжруулах, эрсдэлийн удирдлагын үр ашигтай системийг бий болгож, хэрэгжүүлэх замаар Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, үнэлж, урьдчилан сэргийлж, бууруулж, зохистой удирдахад чиглэнэ.

**Эрсдэлийн удирдлагын тогтолцоо**

**Төлөөлөн Удирдах Зөвлөл** нь Группийн эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны хязгаарлалт, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, эрсдэлийн аппетитийг баталж эрсдэлийн удирдлагын үр дүнтэй хяналтын тогтолцоог бүрдүүлэн, тогтмол хяналт тавих үүрэгтэй.

**Гүйцэтгэх Захирлын удирдлага доорх Удирдлагын баг** нь эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын дагуу Групп нь тогтоосон эрсдэлийн параметрүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог боловсруулж ажиллах үүрэгтэй.

**Эрсдэлийн Удирдлагын Газар** нь эрсдэлийн удирдлагын хүрээг хянах, журмын хэрэгжилтийг хангах, эрсдэлийг тодорхойлох, хэмжих, удирдах, тайлагнах арга хэлбэрийг боловсруулах үүрэгтэй.

Дор дурдсан гурван хороодоос гадна Монгол Улсын Хөгжлийн банкны Захирлуудын зөвлөл нь гүйцэтгэх удирдлагын өдөр тутмын үйл ажиллагааны уялдааг хангаж, үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж гаргах замаар Гүйцэтгэх Захирлыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй.

**Зээлийн Удирдлагын Хороо** -ны үндсэн зорилго нь зээлийн ерөнхий болон багцын удирдлага болон бусад зээлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд оршино. Зээлийн Удирдлагын Хорооны зүгээс зээлийн үнэлгээ хийх, зээлийн эрсдэлийг багасгах, түүнийг удирдах арга замуудыг судлан, зээлийн нөхцөлийг тогтоодог.

Зээлийн Удирдлагын Хороо нь ирээдүйн төсөл түүний үйл ажиллагааны санхүүжилтийг зохион байгуулах, зээлдэгч-зээлдүүлэгчийн харилцааг тогтоосон стандарт, зарчмуудыг хэрэгжүүлэх, санхүүжилтийн горимд учирч болзошгүй эрсдэлийг багасгах явдлыг хангах үүрэгтэй. Мөн Зээлийн Удирдлагын Хороо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан журмын дагуу Гүйцэтгэх Удирдлагад санхүүжилтийн шийдвэр гаргалтад мэргэжлийн талаас санал бодлоо илэрхийлж, зөвлөмж өгөх үүрэгтэй. Зээлийн эрсдэлийн удирдлага болон зээлийн багцын хязгаарлалт, түүнд тогтоосон бодлого, журмууд нь Зээлийн Удирдлагын Хороогоор хянагддаг.Зээлийн Удирдлагын Хороо нь зээлийн эрсдэлийг хянаж, үнэлэх, зээлийн бүтээгдэхүүнийг барьцаалах, удирдамжийг хянах, мөрдүүлэх зорилгоор байгуулагдсан. Түүнчлэн, журмын дагуу Зээлийн Удирдлагын Хороо нь зээл олгох, батлах, зээл олгох нөхцөлийг өөрчлөх, зээлийн гэрээг удирдах, зээлийн багцын үр ашигт байдлыг зохицуулах байдлаар Банкны дүрмийн хүрээнд Зээлийн үйл ажиллагаанд хяналт тавина.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 48

## 28. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Хөрөнгийн Удирдлагын Хороо (ХУХ)** нь хөрөнгө удирдлагын үйл ажиллагааг зохицуулах, актив, пассивын бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах, хянах, түүнд санал оруулах зорилгоор байгуулагдсан. ХУХ нь Хөгжлийн банкны шинэчлэгдсэн хуулийн шаардлагад нийцүүлэн богино болон урт хугацааны хөрөнгийн хөрвөх чадварыг удирдах, цэвэр хүүгийн ашгийг хамгийн их байлгахаар балансын актив пассивын бүтцийг тодорхойлох үүрэгтэй. Мөн өдөр тутмын төлбөрийн чадварын зөрүүг хянах, стресс тест хийх, актив, пассив хөрөнгийн зохистой бүтцийг сар бүр тодорхойлж, шаардлагатай тохиолдолд тухай бүр өөрчлөлт оруулах санал өгөх үүрэгтэй. ХУХ-ны хурлыг сард нэг удаа тухайн улирал дуусахаас арван хоногийн өмнө санхүүгийн үйл ажиллагааг үнэлэх, Банкны улирлын тайлан болон хөндлөнгийн аудитын байгууллагаас баталгаажуулах аудитын тайланг хэлэлцэх зорилгоор хуралдана. Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага нь ХУХ болон Хөрөнгийн Удирдлагын газарт төвлөрөх бөгөөд хөрвөх чадварын зөрүүг хянаж, стресс тест хийн хөрвөх чадварын шинжилгээний тайланг тогтмол явуулдаг.

**Эрсдэлийн Удирдлагын Хороо** нь Банкны эрсдэлийн удирдлагын бодлогын зорилго зорилтыг хэрэгжүүлэх үүднээс банкны зээл, хөрвөх чадвар, зах зээл болон үйл ажиллагааны эрсдэлийн түвшин, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх, бууруулах арга замуудыг тодорхойлон, хууль, журмын дагуу тогтоосон эрсдэлийн хэм хэмжээ, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг хангахад чиглэн ажилладаг. Эрсдэлийн Удирдлагын Хороо нь дараах асуудлуудыг хэлэлцэн дүгнэлт гаргах үүрэгтэй. Үүнд:

- Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хууль, холбогдох журамд тусгагдсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хязгаарлалтуудын хэрэгжилтийг хянах, холбогдох журамд өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэх;
- Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгын хүрээнд банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, шинэчлэх, тэдгээрийн хэрэгжилтийн тайлан мэдээг хэлэлцэх;
- Банкны бизнес төлөвлөгөө, түүний зорилго зорилтын хэрэгжилтийн хүрээнд эрсдэлийн аппетит, Банкны хүлээн зөвшөөрөх алдагдлын хэмжээг тодорхойлох;
- Банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх холбогдох журам, заавар, аргачлалыг хэлэлцэх;
- Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж үнэлэн, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ, стратегийг хэлэлцэх;
- Банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн түвшний үнэлгээ дүгнэлтийг гаргах, эрсдэлийн удирдлагын зүй зохистой тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэх;
- Эрсдэлийн хэмжээний хязгаарлалтыг шинээр тогтоох, өөрчлөх, холбогдох арга аргачлалыг батлах, гүйцэтгэлийг дүгнэх;
- Засгийн газар, Монголбанк, хөндлөнгийн аудит болон Банкны дотоод хяналтын нэгжүүдийн хяналт шалгалтын дүгнэлт, зөвлөмжийг хэлэлцэх;
- Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэлийн түвшин, эрсдэлийг хаах үйл ажиллагааны зардал, ашгийн тооцоолол, нэвтрүүлэх явцад гарах эрсдэл, хяналт, зохион байгуулалттай холбоотой асуудлыг хэлэлцэх;
- Банкны бүртгэл тайлагналын эрсдэл, мэдээллийн технологи, системийн аюулгүй тогтвортой үйл ажиллагаа, мэдээ мэдээллийн нууцлал, зүй зохистой хүрэлцээг хангах талаар хэлэлцэх;
- Банкны ажлын байрны аюулгүй байдал, харуул хамгаалалт, Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй гадаад орчны нөлөөллийн эрсдэлийг бууруулах, онцгой нөхцөл байдлын үед хяналт тавих, даван туулах нөхцөл боломжоо хэрхэн хангаж байгаа эсэхийг хэлэлцэх;
- Банкны санхүүгийн онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө, зааврыг жил тутам хянаж, гадаад дотоод нөлөөллийн үнэлгээний дагуу шаардлагатай өөрчлөлтийг оруулах талаар хэлэлцэх;
- Банкны журам, заавраар зохицуулагдаагүй бусад үйл ажиллагааны эрсдэл, эрүүгийн гэмт хэргийн шинжтэй үйлдэл гарах нөхцөл, терроризм мөнгө угаалтын эсрэг үйл ажиллагааны хяналт, ажиллах хүчний тогтвортой байдал талаар хэлэлцэх;
- Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, холбогдох шийдвэрүүд тэдгээрийн хэрэгжилт, үр дүн болон цаашид баримтлах чиглэл, төлөвлөгөөний талаар санал боловсруулах;
- Хорооны хурлын үйл ажиллагааны үр дүн, дүгнэлтийн биелэлтийг улирал тутам хянах;
- Эрсдэлийн удирдлагатай холбоотой бусад асуудлын талаар хэлэлцэх.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 49

## 28. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл нь зээлдэгч болон бусад харилцагчид Банкны өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, барьцаа баталгааны хөрөнгө нь гэрээний үүргийн гүйцэтгэлийг үл хангах эрсдэл юм.

Банкны төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх үйл ажиллагааг чиглүүлэн зохион байгуулах, санхүүжилтийн багцын чанарын болон төвлөрлийн хязгаарлалт, зээлийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангах ажиллах, санхүүжилт, хөрөнгө оруулалтын учирч болзошгүй эрсдэлийг удирдах, өдөр тутмын зээл санхүүжилтийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг Зээлийн Удирдлагын Хороо болон зээлийн хэлтэсүүд хариуцдаг. Тайлант хугацаанд Банк зээлийн бодлого, Зээлийн Удирдлагын Хорооны ажиллах болон зээлийн үйл ажиллагааны журмуудыг шинэчлэн батлуулж мөрдөн ажиллаж байна.

Банк нь зээлийн эрсдэлийн удирдлагын талаарх бодлого, зохицуулалтыг байнга хянаж, шинэчилдэг. Тайлант жилд Банк эрсдэлтэй харилцагчдын жагсаалтын журмыг тогтоож, хөрөнгийн үнэлгээний журмыг шинэчилсэн.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, Банкны дүрмийн дагуу Гүйцэтгэх Захирал нь Банкны өөрийн хөрөнгийн 0.6%-иас доош үнийн дүнтэй төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх, баталгаа, батлан даалт гаргахтай холбоотой шийдвэрийг гаргадаг бөгөөд өөрийн хөрөнгийн 0.6%-иас дээш үнийн дүнтэй төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх, баталгаа, батлан даалт гаргахтай холбоотой шийдвэрийг ТУЗ-өөс гаргуулан ажилладаг. Мөн Банкны Гүйцэтгэх Захирал нь Банкны гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгчийн хувьд төсөл хөтөлбөрийн санхүүжилт, санхүүжилтийн нөхцөл өөрчлөх, санхүүжилтийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах талаар шийдвэр гаргахдаа мэргэжлийн хороо буюу Зээлийн Удирдлагын Хорооны дүгнэлтэд үндэсладаг.

Банк нь 2017 онд батлагдсан хуулийн шинэчилсэн найруулгын дагуу банкны зээл санхүүжилтийн үйл ажиллагааны стратеги чиглэл, санхүүжилтийн тэргүүлэх салбар, төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагыг тогтоож, улс орны стратегийн өндөр ач холбогдол бүхий эдийн засаг, санхүүгийн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх шийдвэрийг гарган ажиллаж байна.

Мөн Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8.2 дугаар заалтад "Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх, баталгаа, батлан даалт гаргах нийт санхүүжилтийн дүнгийн 60-аас доошгүй хувийг экспортыг дэмжсэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулна" гэж тусгасан бөгөөд энэ заалтын хэрэгжүүлэх хугацааг Банкны зээлийн удирдлагын бодлогод 2017 оны 4 дүгээр сараас гэж тусгасан байна. Банк одооноос энэ заалтын хэрэгжилтэд анхаарч, холбогдох тайлан мэдээ гаргаж, хязгаарлалтыг хянан ажиллаж байна.

Монголбанк 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдөр "Монгол Улсын Хөгжлийн Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ыг шинэчилсэн. Шинэчлэгдсэн журмын дагуу 2020 онд мөрдөгдөж байсан зарим зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд өөрчлөгдөж, хасагдаж, мөн тайлангийн маягтууд шинэчлэгдсэн.

Төлөөлөн удирдах зөвлөл нь зээлийн эрсдэлийн бодлого, журмуудад шалгалт хийж, зээлийн эрсдэлийн хязгааруудыг тогтоох, мөн зээлийн эрсдэлийн аппетитыг тодорхойлох болон зээлийн эрсдэлийн багцуудад хяналт тавин ажилладаг.

Зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцохдоо үндсэн зээл болон хүүгийн төлбөрийн хугацаа хэтэрсэн эсвэл оролцогч талын мөнгөн гүйлгээнд мэдэгдэхүйц хүндрэл учирсан, зээлжих чадварын үнэлгээ буурсан, гэрээний үндсэн нөхцөлийг зөрчсөн эсэхийг голлон анхаардаг. Үнэ цэнэ бууралтын хувь хэмжээгээр зээлийг таван бүлэгт ангилдаг байна.

Банк нь Монголбанкнаас баталсан "Активыг ангилах, эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам"-ын дагуу зээлийг ангилж зээлийн чанарыг хянадаг.

Балансын гадуурх санхүүгийн хэрэгслүүдийн хувьд Банк нь шийдвэр гаргах, хязгаарлалт тогтоох, байнгын хяналт тавих зэргээр балансын санхүүгийн хэрэгсэлтэй нэгэн адил зохицуулалтыг баримталдаг.

ИЕКСНА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 50

## 28. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Барьцаа

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчийн төлбөрийн чадвар, төслийн санхүүгийн үр ашгийн судалгаа шинжилгээнээс гадна санхүүжилтийн эрсдэлийн үнэлгээнээс үндэслэн харилцагчдад барьцаа баталгааны хөрөнгийн зохих шаардлага тавигдах бөгөөд Банк нь барьцааны хөрөнгө, баталгаа батлан даалтын хэрэгслээр үүргийн гүйцэтгэл хангуулах, тэдгээрийн үнэлгээний үзүүлэлтийг тодорхойлох журмыг үйл ажиллагаандаа мөрддөг. Банк нь төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчдэд олгох санхүүжилтийн дээд хэмжээ нь барьцаа хөрөнгийн үнэлгээний 100 хувиас хэтрэхгүй байх ерөнхий зарчмыг хангаж ажилладаг байна.

Банк дараах үндсэн төрлийн барьцаа хөрөнгийг зөвшөөрдөг:

1. Засгийн газар, нэр хүндтэй даатгалын компани, банкууд, хөрөнгө оруулалтын банкууд, B2-B3 буюу түүнээс дээш ерөнхий үнэлгээ бүхий арилжааны банкуудаас гаргасан баталгаа;
2. Үндсэн хөрөнгө: Газар, барилга, үйлдвэр;
3. Хөдлөх хөрөнгө: Тээврийн хэрэгсэл ба тоног төхөөрөмж;
4. Тусгай өмчийн эрх: Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, Төсөл гүйцэтгэх эрх;
5. Хугацаат хадгаламж, Үнэт цаас/Өрийн бичиг ба Хувьцаа;
6. Зээлдэгч ба төслийн гүйцэтгэгч талуудын үйл ажиллагааны үр дүнд бий болсон хөрөнгө ба орлого;

Эрсдэлийн Удирдлагын Газар нь барьцаа хөрөнгийг үнэлэх, барьцаа хөрөнгийн үнэ цэнийг хянах, зээл барьцаа хөрөнгийн бичиг баримтуудын хадгалалт хамгаалалтыг хариуцах үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг.

Барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолохдоо тухайн зээлийг авах үедээ барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлдог бөгөөд хөндлөнгийн болон дотоод үнэлгээгээр тогтмол дахин үнэлдэг.

Барьцаа хөрөнгийн санхүүгийн үр нөлөөг Тодруулга 11-д тусгасан болно.

### Санхүүгийн түрээсийн эрсдэл

Санхүүгийн түрээсийн эрсдэл гэдэг нь түрээслэгч түрээслүүлэгчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх эрсдэл юм.

Групп нь дээрх эрсдэлийг удирдах, урьдчилан сэргийлэх үүднээс Санхүүгийн түрээсийн бодлого, Санхүүгийн түрээсийн үйл ажиллагааны журамд доорх зүйлсийг багтаасан.

Үүнд:

- Санхүүгийн түрээсийн хүсэлтийг хянах, батлах заавар;
- Санхүүгийн түрээсийн үнэлгээний аргачлал;
- Барьцаа хөрөнгийн үнэлгээний аргачлал;
- Санхүүгийн түрээсийн хувийн хэргийн бүрдэл;
- Санхүүгийн түрээсийн зүйлд явцын хяналт хийх заавар;
- Түрээсийн зүйлийн урьдчилгаа төлбөр;
- Бусад хязгаарлалт.

Группийн Санхүүгийн түрээсийн бодлогод заасны дагуу лизингийн хороо нь Ди Би Эм Лизинг ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн 25%-иас доош үнийн дүнтэй төсөл, хөтөлбөрт санхүүгийн түрээс олгохтой холбоотой шийдвэрийг гаргана. Санхүүгийн түрээсийн бодлогод заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал нь Ди Би Эм Лизинг ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн 25%-иас дээш үнийн дүнтэй төсөл, түрээс олгохтой холбоотой шийдвэрийг гаргадаг.

Санхүүгийн түрээсийн хүсэлт нь санхүүгийн түрээс хүсэгчийн бизнесийн хэтийн төлөв буюу зээлийг эргэн төлөх чадвар, банкны чадвар болон одоогийн санхүүгийн гүйцэтгэлээр зөвшөөрөгдөнө. Лизингийн хороонд материалыг өгөхөөс өмнө Эрсдэл, Актив Пассивын удирдлагын газар нь санхүүгийн түрээсийн хүсэлт, холбогдох материалуудыг хянаж, тоног төхөөрөмжийн нийцлийн тодорхойлолт болон боломжит эрсдэлийг тодорхойлно. Лизингийн хороо нь санхүүгийн түрээсийн судалгаа, шинжилгээ болон тоног төхөөрөмжийн инженерийн, эх үүсвэрийн тодорхойлолт, эрсдэл, хууль зүйн дүгнэлтийг харгалзан үзсэний үндсэн дээр шийдвэр гаргадаг. Хэрэв шаардлагатай гэж үзвэл нэмэлт барьцаа хөрөнгийн шийдвэр гаргалтаас өмнө шаардана.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 51

## 28. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Санхүүгийн түрээсийн эрсдэл (үргэлжлэл)

Лизингийн хороо нь санхүүгийн түрээс олгох үйл ажиллагааг чиглүүлэн зохион байгуулах, санхүүжилтийн багцын чанарын болон төвлөрлийн хязгаарлалт, санхүүгийн түрээсийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангах ажиллах, санхүүжилт, хөрөнгө оруулалтын учирч болзошгүй эрсдэлийг удирдах үндсэн чиг үүргийг хариуцна.

### Зээлд учирч болзошгүй эрсдэлийн дээд хэмжээ

Дараах хүснэгт нь санхүүгийн байдлын тайлангийн бүрэлдэхүүн хэсэг бүрийн хувьд зээлийн эрсдэл учирч болзошгүй эрсдэлийн дээд хэмжээг харуулсан байна.

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 144,557,617 | 890,417,205 |
| Банкуудад байршуулсан мөнгөн хадгаламж | 32,792,377 | 28,931,618 |
| Үүсмэл санхүүгийн хөрөнгө | - | 21,753,965 |
| Бодит үнэ цэнээр хэмжсэн борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт | 212,183,194 | 312,472,007 |
| ААБҮЦ-ээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө | 11,807,750 | 19,248,584 |
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших үнэт цаасаарх хөрөнгө оруулалт | 180,962,377 | 568,788,930 |
| Зээл, урьдчилгаа ба түрээсийн авлага | 1,499,550,207 | 1,835,610,278 |
| Бусад хөрөнгө | 32,694,115 | 1,368,267 |
| **Балансын нийт дүн** | **2,114,547,637** | **3,678,590,854** |
| Гаргасан баталгаа (Тодруулга 31) | 550,000,000 | 550,000,000 |
| Төлөгдөөгүй үүрэг | 170,702,222 | 256,354,945 |
| **Балансын гадуурх нийт дүн** | **720,702,222** | **806,354,945** |
| **Зээлийн эрсдэлд өртөж болох нийт дүн** | **2,835,249,859** | **4,484,945,799** |

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 52

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 28. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Салбараар ангилсан зээлийн эрсдэл

2023 болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээл болон урьдчилгааны үлдэгдлийг салбарын хувьд ангилж, эрсдэлийн шинжилгээг доор харуулав:

| *Мянган төгрөгөөр* | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|
| Хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралтад ороогүй: | | |
| - Үйлдвэрлэл | 331,628,469 | 433,406,281 |
| - Уул уурхай, олборлолт | 98,649,459 | 98,845,415 |
| - Цахилгаан эрчим хүч | 406,960,763 | 35,238,526 |
| - Барилга байгууламж | - | 42,871,586 |
| - Тээвэрлэлт ба логистикийн үйл ажиллагаа | 7,559,685 | 13,370,508 |
| **Хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралтад ороогүй зээл ба урьдчилгааны нийт дүн** | **844,798,376** | **623,732,316** |
| Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтад ороогүй: | | |
| 30 хүртэлх хоногоор хугацаа хэтэрсэн: | | |
| - Тээвэрлэлт ба логистикийн үйл ажиллагаа | 457,207 | - |
| 30-аас 90 хүртэлх хоногоор хугацаа хэтэрсэн: | | |
| - Үйлдвэрлэл | - | 43,170,799 |
| - Уул уурхай, олборлолт | - | 3,630,261 |
| 90-ээс 180 хүртэлх хоногоор хугацаа хэтэрсэн: | | |
| - Цахилгаан эрчим хүч | - | 3,205,168 |
| 180-аас 360 хүртэлх хоногоор хугацаа хэтэрсэн: | | |
| - Барилга байгууламж | - | 42,064 |
| - Үйлдвэрлэл | - | 35,623,300 |
| 360 хоногоос дээш хугацаа хэтэрсэн: | | |
| - Барилга байгууламж | 17,739,402 | 5,169,314 |
| - Үйлдвэрлэл | 8,956,054 | 94,366,525 |
| - Уул уурхай, олборлолт | 12,253,379 | 27,198,472 |
| - Хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон загас агнуур | - | 2,778,478 |
| - Цахилгаан эрчим хүч | 120,905,847 | 390,328,242 |
| - Тээвэрлэлт ба логистикийн үйл ажиллагаа | 28,031,700 | - |
| **Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнэ бууралтад ороогүй зээл ба урьдчилгааны нийт дүн** | **188,343,589** | **605,512,623** |
| Тусгай үнэлгээгээр үнэ цэнэ буурсан гэж тодорхойлсон: | | |
| 30 хүртэлх хоногоор хугацаа хэтэрсэн: | | |
| - Үйлдвэрлэл | 1,099,777 | 1,321,600 |
| 360 хоногоос дээш хугацаа хэтэрсэн: | | |
| - Үйлдвэрлэл | 950,780,391 | 994,488,569 |
| - Барилга байгууламж | 104,272,982 | 144,053,762 |
| - Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 850,663 | 850,663 |
| - Цахилгаан эрчим хүч | 5,074,943 | 4,308,146 |
| - Уул уурхай, олборлолт | 172,857,926 | 180,919,107 |
| - Эрүүл мэнд, нийгмийн ажил | 40,900,000 | 68,067,045 |
| - Хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон загас агнуур | 8,490,903 | 60,761,901 |
| - Тээвэрлэлт ба логистикийн үйл ажиллагаа | - | 33,734,314 |
| - Бусад | 7,319,565 | 7,878,657 |
| **Үнэ цэнэ буурсан зээл ба урьдчилгааны нийт дүн** | **1,291,647,150** | **1,496,383,764** |
| **Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан** | **(825,238,908)** | **(890,018,425)** |
| **Нийт зээл ба урьдчилгааны цэвэр дүн** | **1,499,550,207** | **1,835,610,278** |

Зээлийн төвлөрлийн эрсдэлийн шинжилгээний тайлагналыг Тодруулга 11-ээс харна уу.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
ХУУДАС 53

*Монгол Улсын Хөгжлийн Банк*
*Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд - 2023 оны 12 дугаар сарын 31*
*(Өөрөөр заагаагүй тохиолдолд мянган төгрөгөөр илэрхийлэв)*

## 28. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Салбараар ангилсан зээлийн эрсдэл (үргэлжлэл)

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Банк нь үйл ажиллагаандаа дараах зохистой харьцаанууд болон хязгаарлалтуудыг мөрдөж ажиллах үүрэгтэй байна. Үүнд:

1. Банкны нийт зээлийн багц нь өөрийн хөрөнгийн хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэн хэмжээнээс хэтрэхгүй байна.
2. Нийт том зээлдэгч (Монголбанкны журмын дагуу Банкны өөрийн хөрөнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд тэдгээрийг банкны том зээлдэгч гэж тодорхойлсон), тэдгээрт холбогдогч этгээдүүдэд олгосон зээл, зээлтэй адилтгах хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь Банкны нийт зээл, зээлтэй адилтгах хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүнгийн 80 хувиас хэтрэхгүй байна.

| д/д | Үзүүлэлт | Хязгаар | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2022 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | Нийт зээл/Өөрийн хөрөнгө | ≤30x | 3.80 | 4.08 |
| 2 | Том зээлдэгч/Зээл+ Баталгаа+Зээлтэй адилтгах хөрөнгө | ≤80% | 83.6% | 78.2% |

### Хөрвөх чадварын эрсдэл

Группийн хувьд хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь "Банкны түргэн борлогдох актив хөрөнгө нь харилцагчийн өмнө хүлээсэн үүргийг биелүүлэхэд хангалтгүй байх эрсдэл" гэж тодорхойлсон.

Групп нь хэвийн болон онцгой нөхцөлд зөвшөөрөгдсөн алдагдлын хэмжээнд өр төлбөрөө гэрээний хугацаанд төлж барагдуулахад хүрэлцэхүйц мөнгөн хөрөнгийг өндөр хөрвөх чадвар бүхий хөрөнгөнд байршуулах замаар хөрвөх чадварын эрсдэлийг удирдан зохицуулдаг. Банк нь валют тус бүрийн хувьд болон нэгдсэн байдлаар хөрвөх чадварын эрсдэлийг хянан зохицуулдаг.

